

ДОРНОД АЙМАГ ДАХЬ ЦЭРГИЙН ГАВЪЯАНЫ ОДОНТ
ЦАГДААГИЙН ГАЗРЫН 2022 ОНЫ ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАНГИЙН БҮТЭЦ

Нэг. Удирдлага, зохион байгуулалтын талаар.

Хоёр. Гэмт хэрэгтэй тэмцэх, нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах чиглэлээр зохион байгуулсан ажил, арга хэмжээ.

Гурав. Сахилга хариуцлага, болон авилгаас урьдчилан сэргийлэх ажлын талаар

Дөрөв. Соён гэгээрүүлэх ажил болон албаны сургалтын талаар

Тав. Санхүү, бүртгэл, хангамж үйлчилгээний талаар

Зургаа. Дотоод хяналт, шалгалтын талаар

Долоо. Алба хаагч, ажилтны ажиллах нөхцөл, нийгмийн асуудлыг хангах, эрүүл мэндийг хамгаалах чиглэлээр

Найм. Дүгнэлт

Ес. Санал

ДОРНОД АЙМАГ ДАХЬ
ЦАГДААГИЙН ГАЗАР

ДОРНОД АЙМАГ ДАХЬ ЦЭРГИЙН ГАВЪЯАНЫ ОДОНТ ЦАГДААГИЙН ГАЗРЫН 2022 ОНЫ ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

2022 оны 07 дугаар
сарын 04-ны өдөр.

Хэрлэн сум.

Цагдаагийн газар 2022 онд Цагдаагийн байгууллагаас дэвшүүлсэн зорилтыг хэрэгжүүлэх, гэмт хэрэгтэй тэмцэх, нийгмийн хэв журам сахиулах ажлын арга барилыг боловсронгуй болгох, Хүний эрхийг дээдлэн үйл ажиллагаандаа иргэдийн оролцоо, дэвшилтэд технологийн ашиглалтыг нэмэгдүүлэх, алба хаагчдын эрүүл мэнд, хууль ёсны эрх ашгийг хамгаалах, хүний нөөцийн тогтвортой байдлыг бүрдүүлэх, сахилга ёс зүйг дээшлүүлэх тэдний дунд зохиох сургалт соён гэгээрүүлэх ажил, алба хаагчдын нийгмийн асуудал, ажлын байрны тохижилтыг сайжруулах, тасаг албад, алба хаагч бүрийн ажлын бүтээлч чанар, үр дүнг өнгөрсөн оныхоос ахиулах зорилт тавин ажиллалаа.

НЭГ. УДИРДЛАГА, ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТАЛААР

Цагдаагийн газраас Монгол улсын Ерөнхийлөгч, Улсын Их хурал, Засгийн газар, Хууль зүй дотоод хэргийн сайд болон аймгийн Иргэдийн хурал, Засаг дарга нараас гаргасан цагдаагийн байгууллагын үйл ажиллагаатай холбоотой шийдвэр, Цагдаагийн байгууллагаас дэвшүүлсэн зорилт, Цагдаагийн ерөнхий газрын даргын өгсөн үүрэг, шийдвэрийг алба хаагчдад судлуулах, тайлбарлан таниулах, бие бүрэлдэхүүнийг шинэ мэдээ мэдээллээр ханган тэдний мэргэжлийн ур чадвар, мэдлэг боловсролыг дээшлүүлэхэд үйл ажиллагаагаа чиглүүлэн мэргэжлийн удирдлагаар ханган ажиллаж байна.

Цагдаагийн байгууллагаас 2022 онд дэвшүүлсэн зорилт, үйл ажиллагааны төлөвлөгөөнд төв, орон нутгийн цагдаагийн газар, хэлтсээс хийж гүйцэтгэхээр заагдсан 5 зорилт, 63 заалтыг хэрэгжүүлэх, гэмт хэрэгтэй тэмцэх, нийгмийн хэв журам сахиулах ажлын арга барилыг боловсронгуй болгох, бүрэлдэхүүний сахилга ёс зүйг дээшлүүлэх тэдний дунд зохиох сургалт соён гэгээрүүлэх ажил, алба хаагчдын нийгмийн асуудал, ажлын байрны тохижилтыг сайжруулах зорилгоор Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны журмын “Цагдаагийн байгууллагын ажлыг төлөвлөх журам”-ын /код 108/ дагуу 5 зорилт 98 ажил, арга хэмжээ бүхий цагдаагийн газрын гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулан хэрэгжүүлэн ажиллалаа.

Цагдаагийн газрын бие бүрэлдэхүүнд долоо хоног бүрийн “Баасан” гаригт дотоод журмын дагуу цагдаагийн байгууллагын үйл ажиллагаатай холбоотой хууль тогтоомж, тушаал шийдвэр, холбогдох эрхийн актууд, байгууллагын бодлого чиглэл, цаг үеийн ажлын талаар тогтмол мэдээлж, албад, алба хаагчдын өдөр тутмын үйл ажиллагаатай холбоотой, нэн шаардлагатай зарим бичиг баримтыг хувилж олшруулан тарааж, хэрэгжүүлэх талаар үүрэг чиглэл өгч байна.

Тус Цагдаагийн газрын хэмжээнд 2022 оны эхний хагас жилд **нийт 819** бичиг хүлээн авч газрын удирдлагад танилцуулан хариуцсан алба хаагч нарт нь хувиарлан бүртгэлээр өгч, цагдаагийн газраас **нийт 981 албан** бичгийг хүргүүлж, явуулсан бичгийн бүртгэлд хөтөлж ажиллав.

АЙМГИЙН ИРГЭНИЙ ЗӨВЛӨЛД ЦАГДААГИЙН ГАЗРЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН ТАНИЛЦУУЛАХ, ТОДОРХОЙ ТӨРЛИЙН ГЭМТ ХЭРЭГ, ЗӨРЧЛИЙГ БУУРУУЛАХАД ТУЛГАМДАЖ БУЙ АСУУДЛЫН ТАЛААРХ ХЭЛЭЛЦҮҮЛЭГ, ЗӨВЛӨГӨӨН ЗОХИОН БАЙГУУЛЛАА

Тус цагдаагийн газраас Цагдаагийн албаны тухай хуулийн 15 дугаар зүйлийн 1.6, 15.2 дахь хэсэг, Хууль Зүй, Дотоод Хэргийн Сайдын 2017 оны А/133 дугаар тушаалаар баталсан "Иргэний зөвлөлийн дүрэм"-ийн 8.1.7-д "Нутаг дэвсгэр хариуцсан цагдаагийн байгууллага нь тухайн жилийн үйл ажиллагааны тайланг иргэний зөвлөл, оршин суугчдад тайлагнах" заалтыг хэрэгжүүлэх, Иргэний

зөвлөлтэй хамтын ажиллагааг эрчимжүүлэх зорилгоор тодорхой төрлийн гэмт хэрэг, зөрчлийг бууруулахад тулгамдаж буй асуудлын талаарх хэлэлцүүлэг, зөвлөгөөнийг 2022 оны 03 дугаар сарын 14-ны өдөр зохион байгууллаа.

Зөвлөгөөнд иргэний зөвлөлийн дарга Я.Насандэлгэр, иргэний зөвлөлийн гишүүд болох Л.Хишигтогтох, Д.Хандсүрэн, Г.Пүрэвсүрэн болон Цагдаагийн газрын даргын дэргэдэх Зөвлөлийн гишүүд, урьдчилан сэргийлэх, гэр бүлийн хүчирхийлэл, хүүхдийн асуудал хариуцсан мэргэжилтэн нар оролцож Цагдаагийн газрын 2021 онд хийж гүйцэтгэсэн ажлын видео тайланг танилцуулав.

Зөвлөгөөнөөр архидан согтуурахтай тэмцэх, гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх, мал хулгайлах гэмт хэрэгтэй тэмцэх, гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэхэд анхаарах асуудал, Цагдаагийн алба хаагчийн эрх ашгийг хамгаалах, Цагдаагийн алба хаагчийн зан харилцаа, зөрчил дутагдлыг арилгах, Цагдаагийн алба хаагчийн гэр бүлд чиглэсэн ажил арга хэмжээний талаар санал хүсэлтийг сонсож, асуусан асуултад холбогдох чиглэлээр хийсэн ажлыг тасгийн дарга, чиглэл хариуцсан мэргэжилтнүүд танилцуулж ажиллав.

Тайлангийн хугацаанд Монгол Улсад Дотоодын цэрэг үүсэж хөгжсөний 100 жилийн ойг угтаж, Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны журам /код 940/ “Соён гэгээрүүлэх ажил”, /код 941/ “Биеийн тамир, спортын арга хэмжээ зохион байгуулах”, Цагдаагийн ерөнхий газрын даргын баталсан “Байгууллагын соёл, эрүүл мэнд, сэтгэл зүйг дэмжих хөтөлбөр”-ийг хэрэгжүүлэх, алба хаагчдын бие бялдар бэлтгэлжилтийн түвшинг ахиулах зорилгоор Цагдаагийн газрын аварга шалгаруулах “Волейбол”, “Марш тактик”, “Мэргэн буудагч”, “Ширээний теннис”, “Хүчний 3 төрөлт” тэмцээнүүдийг зохион байгуулан алба хаагчдын бүрэн хамруулж ажиллаа.

Мөн “Байгууллагын соёл, эрүүл мэнд сэтгэл зүйг дэмжих хөтөлбөр”-ийг хэрэгжүүлэх, “Алба хаагч, ажилтны эрх, хууль ёсны эрх ашгийг хамгаалах” Цагдаагийн газрын алба хаагчдын ахуй амьдралтай танилцах, судлах, Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны тайланг танилцуулах, гэр бүлийн харилцаа хандлагыг тодорхойлох замаар тэдний гэр бүлийн гишүүдтэй уулзаж санал хүсэлтийг сонсох, тулгамдаж буй асуудлыг шийдвэрлэх зорилгоор “Гэр бүлээ сонсьё” арга хэмжээг зохион байгуулсан.

Цагдаагийн газрын алба хаагчдын нийгмийн баталгааг хангах, тулгамдаж буй асуудлыг шийдвэрлэх гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх, нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах, үндсэн чиг үүргийн ажлыг ахиулахад анхаарах асуудал, ажиллах орчин, чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэх, алба хаагчдын эрүүл мэндийг хамгаалах, алба хаагчдаас санал хүсэлтийг хүлээн авч удирдлагын түвшинд шийдвэрлэх зорилгоор “Алба хаагчаа сонсьё” арга хэмжээг зохион байгуулж сарын бүрийн 01-ны өдрийг “Алба хаагчаа сонсох” өдөр болгон хэрэгжүүлэн ажиллаж байна.

Алба хаагчийн үйл ажиллагаанд хяналт тавьж, алба хаагч, ажилтан гэмт хэрэг, зөрчил үйлдэх, ёс зүй, сахилгын зөрчил гаргахаас урьдчилан сэргийлж, шалтгаан нөхцөлийг арилгах арга хэмжээ авах, цагдаагийн албаны дотоод хяналт-аюулгүй байдлыг хангах, алба хаагчдын албандаа хандах хандлагыг эерэг болгож, ажлын бүтээмжийг дээшлүүлэх, харилаа, хандлагыг өөрчлөх зорилгоор бүхий “Ёс зүйгээ мөрдөж, дүрмээ биелүүлье” 1 сарын аяныг зохион явуулж байна.

А. Байгууллагын даргын зөвлөлийн хурлаар хэлэлцсэн асуудал: Цагдаагийн газрын даргын зөвлөлийн хурлаар хэлэлцэх асуудлыг урьдчилан бэлтгүүлж, долоо хоног бүрийн Мягмар гаригт 6 удаа хуралдаж, 116 асуудал хэлэлцсэнийг ангилж үзвэл: Удирдамж төлөвлөгөө батлах 5, ажлын байрны томилолт болон чөлөөлөх асуудлаар 28, шагнаж урамшуулах 2, албаны шалгалт 4, сахилга хариуцлагын талаар 6, ажлын хэсэг байгуулах

талаар 11, тасаг албадын сарын ажил дүгнэх талаар 4, хугацаатай үүрэг даалгаврын биелэлтийг авч хэлэлцэх талаар 4, сонсгол мэдээлэл 46, бусад асуудлыг хэлэлцэж шийдвэр гаргасан ба зөвлөлийн хурлаас 6 алба хаагчид хугацаатай үүрэг даалгавар өгч, биелэлт үр дүнг тооцсон байна.

Албадын дарга нарын манлайлал, бүтээлч ажиллагаа, алба хаагчдын сахилга ёс зүй, цагдаач шуурхай ажиллагааг хангаагүй, шат дараалсан шаардлага, хяналт сул байгаа байдлыг юуны түрүүнд сайжруулах удирдлага, зохион байгуулалтын арга хэмжээг авч хэрэгжүүлж байна.

Цагдаагийн газрын удирдлагаас албадын үйл ажиллагааг сайжруулж, оршиж буй алдаа дутагдлыг засч арилгах, орон нутгийн цагдаагийн тасаг, хэсгийн дарга, хэсгийн төлөөлөгч, цагдаа нарын ажлын хариуцлага сахилгыг дээшлүүлэх, урьдчилан сэргийлэх чиглэлээр газрын даргын 14 үүрэг, ажлын чиглэлийг албан бичгээр хүргүүлж, биелэлт үр дүнг нь тооцож ажиллалаа. Алба хаагчдын ажлын хариуцлага, сахилга ёс зүйг сайжруулах чиглэлээр бүрэлдэхүүнд 16 удаа үүрэг тавьж, давхардсан тоогоор 21 алба хаагчтай ганцаарчлан уулзаж зөвлөгөө өгч, 87 алба хаагчийн гэр бүлийн гишүүдтэй уулзаж ярилцан зөвлөгөө өгч, санал хүсэлтийг нь сонсов.

Б. Хүний нөөцийн талаар: Цагдаагийн газар нь алба хаагчдын эрх зүйн баталгааг хангах, ажлын таатай орчинг бүрдүүлж мэдлэг боловсрол ухамсраа дээшлүүлэх боломжоор хангах, хүн төвтэй цагдаагийн үйлчилгээний тогтолцоог бий болгох, ил тод нээлттэй байж өргөдөл гомдлыг хүлээн авах барагдуулах ажлыг боловсронгуй болгох, орчин үеийн мэдээллийн технологийг ашиглан иргэдэд мэдээ, мэдээллийг шуурхай хүргэж байгууллагын нэр хүндийг дээшлүүлэхэд өдөр тутам анхаарч ажиллалаа.

Цагдаагийн байгууллагад ажилд орохоор хүсэлт гаргасан иргэдийг Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны журмын “Хүний нөөцийн бодлого хэрэгжүүлэх /код 900/ журам”, “Хүний нөөцийг судлах, ажилд томилох /код 901/ журам”-ын дагуу сонгон шалгаруулалт зарлаж, цагдаагийн байгууллагад ажилд орох хүсэлт гаргасан 7 иргэнийг бүртгэн шаардлага шалгуур хангасан 2 иргэний материалыг Цагдаагийн ерөнхий газрын Хүний нөөцийн хэлтэст хүргүүлэн сонгон шалгаруулалтад хамруулав.

Дорнод аймаг дахь Цагдаагийн газар нь Цагдаагийн ерөнхий газрын даргын 2017 оны 06 дугаар сарын 30-ны өдрийн А/135 дугаар тушаалаар батлагдсан 187 алба хаагч, мөн даргын 2020 оны 01 дүгээр сарын 14-ний өдрийн “Экологийн цагдаагийн алба байгуулах, зохион байгуулалтын бүтэц, орон тоог батлах тухай” Б/17 дугаар тушаалаар 8 орон тоо батлагдаж, нийт байвал зохих 201 алба хаагч байхаас одоогийн байдлаар бэлэн

194 алба хаагч /Чойбалсан хотын ус хангамжийн эх үүсвэр хамгаалах Дотоодын цэргийн тусгай салбарт 23 алба хаагч/ ажиллаж байна.

Алба хаагчдыг хүйсийн байдлаар нь авч үзвэл 157 буюу 91,7 хувь нь эрэгтэй, 14 буюу 8,2 хувь нь эмэгтэй, 103 буюу 60 хувь нь офицер, 63 буюу 37 хувь нь ахлагч, 5 буюу 2,9 хувь нь энгийн гэрээт ажилчид байна. Алба хаагчдыг насны байдлаар нь ангилж үзвэл 21-25 насны 21, 26-30 насны 53, 31-35 насны 52, 36-40 насны 24, 41-45 насны 15, 46-50 насны 6 алба хаагч байна.

Цагдаагийн байгууллагад ажилласан жилээр нь ангилж үзвэл 1 жил хүртэл 12, 1-5 жил ажилласан 56, 6-7 жил ажилласан 17, 8-10 жил ажилласан 29, 11-15 жил ажилласан 34, 16-20 жил ажилласан 17, 21-25 жил ажилласан 4, 26-гаас дээш жил ажилласан 2 алба хаагч байна. Тус Цагдаагийн газарт өнөөдрийн байдлаар 6 /Эрүүгийн мөрдөгч 1, эргүүлийн цагдаа 1, мэдээлэл хүлээн авагч цагдаа 1, харуулчин 1, ахлах мэрэгжилтэн /Урьдчилан сэргийлэх, гэр бүлийн хүчирхийлэл, хүүхдийн асуудал хариуцсан/ түдгэлзүүлсэн офицер 1/ алба хаагчийн орон тоо дутуу байгаа болно.

Цагдаагийн байгууллагад олон жил үр бүтээлтэй ажилласан хамт олны дунд нэр хүндтэй, ажлын дадлага, чадвар, туршлагатай, албаны мэдлэг чадвар сайтай нэр бүхий алба хаагчдын гаргасан санал хүсэлт, боловсрол мэргэжлийн түвшин, дадлага, туршлагыг харгалзан Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны “Албан тушаал дэвшүүлэх” /код 909/ журамд заасан болзол шаардлагыг хангасан алба хаагчдыг байгууллагын даргын зөвлөлийн хурлаар хэлэлцэн 2022 оны эхний 1 дүгээр улирлын байдлаар тасаг хэсгийн даргаар 1, ахлах албан тушаалд 5, офицер бүрэлдэхүүнд оруулсан 4, ажлын байр өөрчлөгдсөн 16, шинээр томилогдсон 1 алба хаагч байна.

В. Байгууллагын удирдлагад хандаж ирүүлсэн өргөдөл, гомдол шийдвэрлэлтийн талаар: Цагдаагийн газрын удирдлага, албан тушаалтанд хандаж иргэд, аж ахуй, нэгж байгууллагаас жилийн эцсийн байдлаар 66 өргөдөл, гомдол, санал ирүүлснийг хүлээн авч бүрэн шийдвэрлэж хариу өгөв. Ирүүлсэн өргөдөл, гомдол, саналыг ангилбал ажил өөрчлөх шилжихийг хүссэн 19, захиргааны чөлөө хүссэн 47 байна.

Цагдаагийн газрын удирдлага алба хаагчдын талаар иргэдээс ирүүлсэн өргөдөл, гомдол мэдээлэл, дотоодын хяналт, шалгалтаар илрүүлсэн зөрчил бүрийг бүртгэн авч албаны шалгалт явуулан шалтгаан нөхцөлийг тогтоож буруутай этгээдэд хариуцлага тооцох, буруугүй болох нь тогтоогдсон алба хаагчийн талаар гомдол мэдээлэл гаргагчид хариу мэдэгдэж байгууллагын болон алба хаагчийн нэр төрийг сэргээхэд анхаарч ажиллав.

**Г. Төрийн болон төрийн бус байгууллагатай хамтран ажилласан тухай:
ИРГЭН ТАНЫ ТӨЛӨӨ” АЯНЫГ АЙМГИЙН ХЭМЖЭЭНД ЗОХИОН БАЙГУУЛЖ
ЭХЭЛЛЭЭ**

Чойбалсан хотын хэмжээнд үйлдэгдэж байгаа гэмт хэргийн гаралтыг бууруулах, түүнээс урьдчилан сэргийлэх, таслан зогсоох, шалтгаан нөхцөлийг судлан дүгнэх, иргэдэд эрх зүйн үйлчилгээг сайжруулах, төрийн байгууллагуудын уялдаа холбоо, хамтын ажиллагааг эрчимжүүлэх зорилгоор Хэрлэн сумын Засаг даргын 2022 оны А/128 дугаар захирамжаар “Иргэн таны төлөө” нөлөөллийн аянг 3 сарын хугацаатай аймгийн хэмжээнд зохион явуулж эхэллээ.

Нээлтийн үйл ажиллагаанд Хэрлэн сумын засаг даргын орлогч, багийн засаг дарга нар болон Нийтийн хэв журам хамгаалах тасгийн дарга, ахлах байцаагч, урьдчилан сэргийлэх хэсгийн алба хаагчид, хэсгийн байцаагч нар бүрэн хамрагдаж, аяны хүрээнд хийх ажлыг төлөвлөлөө.

Аяны хүрээнд гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлын хүрээнд иргэд олон нийттэй уулзан санал хүсэлтийг нь сонсож, зөвлөмж, санамж сэрэмжлүүлэг тараах, байгууллага, аж ахуй нэгжийн үйл ажиллагаанд хяналт шалгалт явуулж, гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх нөлөөллийн арга хэмжээ зохион байгуулах юм.

ПРОКУРОРЫН ГАЗАРТАЙ ХАМТАРСАН ЗӨВЛӨГӨӨН ЗОХИОН БАЙГУУЛЛАА.

Тус Цагдаагийн газраас аймгийн Прокурорын газартай 2 дугаар сарын мөрдөн шалгах ажиллагааны талаар хамтарсан уулзалт, зөвлөгөөнийг 2022 оны 02 дугаар сарын 09-ний өдөр хурлын танхимд зохион байгууллаа. Зөвлөгөөнд Цагдаагийн газрын дарга, цагдаагийн хурандаа Т.Ганзориг, аймгийн ерөнхий прокурор, хууль цаазын шадар зөвлөх Н.Доржсүрэн, мөрдөн шалгах ажиллагаа явуулах эрх бүхий алба хаагч болон хяналтын прокурор нар оролцон, шалгагдаж буй хэргийн талаар тулгамдаж буй асуудал, цаашид хэрэгжүүлэх ажлын талаар хэлэлцлээ. Мөн үеэр аймгийн Прокурорын байгууллагатай 2022 онд хамтран ажиллах төлөвлөгөөг баталсан байна.

Цагдаагийн газраас Цагдаагийн албаны тухай хуулийн 15 дугаар зүйлийн 1.6, 15.2 дахь хэсэг, Хууль Зүй, Дотоод Хэргийн Сайдын 2017 оны А/133 дугаар тушаалаар баталсан "Иргэний зөвлөлийн дүрэм"-ийн 8.1.7-д "Нутаг дэвсгэр хариуцсан цагдаагийн байгууллага нь тухайн жилийн үйл ажиллагааны тайланг иргэний зөвлөл, оршин суугчдад тайлагнах" заалтыг хэрэгжүүлэх зорилгоор үйл ажиллагааны тайланг иргэдэд тавих арга хэмжээ"-г Цагдаагийн газрын 2021 онд хийж гүйцэтгэсэн ажлын тайланг видео хэлбэрээр үзүүлэн, иргэдийн санал, хүсэлтийг сонсож, тасаг албадууд цагдаагийн байгууллагын үйл ажиллагаанд ашиглаж байгаа багаж, тусгай хэрэгслийг иргэдэд танилцууллаа. Орон

нутгийн “ТВ6”, “Мижи”, “Дорнод”, “Шинэ суваг” телевизүүдтэй хамтран тайлангийн талаар мэдээ мэдээллийг бэлтгэн иргэд олон нийтэд сурталчлан ажиллав.

Мөн энэ ажлын хүрээнд үйл ажиллагааны талаар “Дорнодын цагдаа 2021” сэтгүүлийг гарган аймаг, сумдын Засаг дарга, ИТХ-ын дарга, төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгжүүдэд хамтран ажиллах “Ил захидал”-ын хамт хүргүүлэн ажиллав.

Цагдаагийн байгууллагаас гэмт хэрэгтэй тэмцэх, нийгмийн хэв журам хамгаалах, урьдчилан сэргийлэх үндсэн үүргээ гүйцэтгэхдээ энэ чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг хууль хяналтын байгууллагатай хамтын ажиллагааг сайжруулах, үр дүнг ахиулах зорилгоор Прокурорын газар, Тагнуулын газар, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар, Мэргэжлийн хяналтын газар, Автотээрийн үндэсний төв, Гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжлийн газар, “Дорнод нийтийн аж ахуй” ОНӨААТҮГ, Хил хамгаалах анги, байгууллагууд, Эрүүл мэндийн газар, Цагдаагийн ахмадын хороо зэрэг нийт 25 газруудтай оны эхэнд хамтарсан уулзалтыг зохион байгуулж, 2021 оны ажил, ололт амжилт, анхаарах асуудлаа ярилцан, санал бодлоо солилцож, 2022 онд хийж гүйцэтгэх ажлын төлөвлөгөө гарган хэрэгжүүлэн ажиллаж байна.

Цагдаагийн газрын үйл ажиллагааг олон нийтэд таниулах, сурталчлах, иргэдэд тухайн байгууллагын мэдээлэл нээлттэй ил тод байх, мэдээ мэдээллийг түргэн шуурхай хүргэх зорилгоор Цагдаагийн газрын “Dornod.police.gov.mn” веб сайтад 44 шинэ мэдээлэл, “Дорнод аймгийн цагдаагийн газар” фэйсбүүк хуудсанд мөн 58 мэдээ, мэдээлэл тавьж, 3450 мэдээг share хийн, 42 төсвийн гүйцэтгэлийн мэдээ, шилэн дансны шинэчилсэн хувилбар, бусад төрлийн мэдээллийн баяжилтыг тухай бүр сайтад байршуулсан.

Цагдаагийн газраас хэвлэл мэдээллийн байгууллагуудтай хамтран ажиллах гэрээний дагуу 7 хоног бүр эрүү, хэв журмын нөхцөл байдал болон гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлын талаар D1, Дорнод, ТВ-6, Мижи, Шинэ суваг зэрэг орон нутгийн телевизүүдээр мэдээлэл хийж ажиллалаа.

ХОЁР. ГЭМТ ХЭРЭГТЭЙ ТЭМЦЭХ, НИЙТИЙН ХЭВ ЖУРАМ ХАМГААЛАХ, ОЛОН НИЙТИЙН АЮУЛГҮЙ БАЙДЛЫГ ХАНГАХ ЧИГЛЭЛЭЭР

БҮРТГЭГДСЭН ГЭМТ ХЭРЭГ, ЗӨРЧЛИЙН НӨХЦӨЛ БАЙДАЛ: Аймгийн хэмжээнд 2022 оны 3 дугаар сард 106 холбогдогчтой, 460.5 төгрөгийн хохиролтой, 173 гэмт хэрэг бүртгэгдэж, 17 хэргээр буюу 10.9 хувиар урьд оны мөн үеэс өссөн байна. Гэмт хэргийн илрүүлэлт 27.8 хувьтай байгаа нь өмнөх оны мөн үеэс 2.7 хувиар өсч.

Гэмт хэргийн улмаас 4 хүн нас барж, 75 хүн гэмтсэн нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад нас барсан хүн 1 буюу 20 хувиар буурч, гэмтсэн хүний тоо 14 буюу 22.5 хувиар өссөн байна. Иргэд аж ахуйн нэгж байгууллагад учирсан хохирлын 125.5 төгрөг буюу 27.1 хувийг нөхөн төлүүлжээ.

Гэмт хэргийн гаралт:-Хэрлэн сумын 2, 6, 7,8, 10 дугаар багууд, Баяндун, Дашбалбар, Баянтүмэн, Гурванзагал, Булган сумдуудад өсөж,

Хэрлэн сумын 1, 3,4,5 дугаар багууд, Чойбалсан, Сэргэлэн, Цагаан-Овоо, Баянтүмэн, Хөлөнбуйр, Матад, Халхгол сумдад буурч, Хэрлэн сумын 11-р багууд, Баян-Уул сумдад урьд оны мөн үетэй ижил түвшинд байна.

Үйлдэгдсэн байдлаар: Согтуугаар үйлдэгдсэн гэмт хэрэг 46 бүртгэгдэж 28 буюу 1.5 дахин, хүүхэд оролцсон гэмт хэрэг 3 бүртгэгдэж 3 дахин, галт зэвсгээр үйлдэгдсэн гэмт хэрэг 1 бүртгэгдэж 100 хувиар тус тус өсөж,

Бүлэглэн үйлдсэн гэмт хэрэг 6, мөнсуурсан үедээ 1 бүртгэгдэж ижил түвшинд, урьд ял шийтгэгдсэн хүмүүсээс дахин гэмт хэрэгт 3 хүн холбогдсон нь 24 буюу 88.8.5 хувь, гэр бүлийн хүчирхийллийн улмаас үйлдэгдсэн гэмт хэрэг 7 бүртгэгдэж 6 буюу 46.1%, эмэгтэй хүн оролцсон гэмт хэрэг хэрэг 9 бүртгэгдэж 2 буюу 18.1 хувиар тус тус буурсан.

Үйлдэгдсэн газраар: Гудамж талбайд үйлдэгдсэн гэмт хэрэг 17 бүртгэгдэж 4 буюу 30.7 хувь, олон нийтийн газарт үйлдэгдсэн гэмт хэрэг 8 бүртгэгдэж 6 буюу 3 дахин, байгууллага аж ахуй нэгжид үйлдэгдсэн гэмт хэрэг 8 бүртгэгдэж 1 буюу 14.2 хувь, бусад газарт үйлдэгдсэн гэмт хэрэг 38 бүртгэгдэж 16 буюу 72.3 хувиар тус тус өссөн байна.

Гэр, орон сууцанд үйлдэгдсэн гэмт хэрэг 58 бүртгэгдэж 14 буюу 19.4 хувь, хөдөө хээр үйлдэгдсэн гэмт хэрэг 14 бүртгэгдэж 1 буюу 6.6 хувь, бэлчээрт үйлдэгдсэн гэмт хэрэг 16 бүртгэгдэж 3 буюу 15.7 хувиар тус тус буурчээ..

Хэргийн төрлөөр: Хүнийг алах 2 бүртгэгдэж 100%, Хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг 59 бүртгэгдэж 11 буюу 22.9 хувь, залилах гэмт хэрэг 21 бүртгэгдэж 7 буюу 50 хувь, хууль бусаар мод бэлтгэх гэмт хэрэг 6 бүртгэгдэж 2 буюу 50 хувь, гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх, эрүүл мэндийн эсрэг гэмт хэргүүд тус бүр 1 бүртгэгдэж 100 хувь, бусад төрлийн гэмт хэрэг 17 бүртгэгдэж 4 буюу 1.5 дахин өсөж,

Хүнийг амиа хорлох нөхцөл байдалд хүргэх гэмт хэрэг 1 буюу 50 хувь, бэлгийн эрх чөлөө хөлдөшгүй байдлын эсрэг гэмт хэрэг 3 буюу 60 хувь, дээрэмдэх гэмт хэрэг 2 дахин, мансууруулах эм сэтгэцэд нөлөөт бодисыг хууль бусаар ашиглах 1 дахин тус тус буурч, хөрөнгө завших, нийтийн албаны ашиг сонирхлын эсрэг, хөдөлгөөний аюулгүй байдал, тээврийн хэрэгслийн ашиглалтын журмын эсрэг гэмт хэрэг ижил түвшинд байна.

Хүний амь насыг болгоомжгүй хохироох, хүүхдийн эсрэг, гээгдэл эд зүйл, алдуул мал завших, улсын хилээр барааг хууль бусаар нэвтрүүлэх, олон нийтийн амгалан тайван байдлыг алдагдуулах, авлигын эсрэг, цахим мэдээллийн аюулгүй байдлын эсрэг гэмт хэргүүд бүртгэгдээгүй байна.

Б. ЦАГДААГИЙН ГАЗРЫН ТАСАГ, АЛБАДААС ХИЙЖ ГҮЙЦЭТГЭСЭН АЖЛЫН ТАЛААР

ЭРҮҮГИЙН ЦАГДААГИЙН ТАСАГ: Аймгийн хэмжээнд 2022 оны 01 дүгээр улирлын байдлаар 103 холбогдогчтой, 462,271,363 төгрөгийн хохиролтой, 170 гэмт хэрэг бүртгэгдэж 14 хэргээр буюу 8.2 хувиар урьд оны мөн үеэс өсч. Гэмт хэргийн илрүүлэлт 26.5 хувьтай байгаа нь өмнөх оны мөн үеэс 1.8 хувиар өссөн байна.

Хэрэг бүртгэлтийн нийт 210 хэрэгт холбогдох ажиллагааг явуулснаас урьд онд үйлдэгдэн эзэн холбогдогч нь тогтоогдоогүй 43 хэргийг, илрүүлэн 2105 маягтаар мөрдөн байцаах тасагт шилжүүлсэн.

Нийслэлийн дүүргүүд болон бусад орон нутгийн цагдаагийн газар, хэлтсээс харьяаллын бус байгууллагаар мөрдөн шалгах ажиллагаа хийлгэх тухай 13, аймгийн Прокурорын газраас эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тодорхой ажиллагаа гүйцэтгүүлэхээр ирүүлсэн 6 даалгаврын биелэлтийг ханган, тогтоолд дурдагдсан ажиллагааг хийж гүйцэтгэн, хариуг хүргүүлсэн байна.

Эрүүгийн цагдаагийн тасгаас яллагдагчаар татагдвал зохих этгээд нь тогтоогдоогүй хэргүүдийг нөхөн илрүүлэх, хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтаас оргосон сэжигтэн, яллагдагчийг эрэн сурвалжилж олж тогтоох, эрчимжүүлэх зорилгоор “Орон байр- Хяналт”, “Шийдвэрлэлт”, “Зочид буудал”, “ Тэнэмэл” Мал хулгайлах гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх ажлын хүрээнд аймгийн засаг даргын захирамжаар “Бод-мал 2022” нэгдсэн арга хэмжээг удирдамж, төлөвлөгөөний хүрээнд зохион байгуулж “Орон байр-Хяналт” нэгдсэн арга хэмжээний хүрээнд 7 орон байрны эзэн холбогдогч нь тогтоогдоогүй гэмт хэргүүдийг илрүүлэн ажиллажээ.

Мал хулгайлах гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх чиглэлээр: Аймгийн хэмжээнд үйлдэгдэж байгаа мал хулгайлах гэмт хэргүүдийг илрүүлэх, таслан зогсоох, хэрэг бүртгэлтийн хэргүүдийн шийдвэрлэлтийг ахиулах, энэ төрлийн гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлыг эрчимжүүлэх, мал хулгайлах гэмт хэрэгтэй тэмцэхэд Төрийн болон төрийн бус байгууллага олон нийтийн оролцоог нэмэгдүүлэх зорилгоор 2022 оны 03 дугаар сарын 10-ны өдөр Цагдаагийн газрын хурлын зааланд бүх сумдын Засаг дарга, ИТХурлын дарга, тасаг, хэсгийн дарга, хэсгийн төлөөлөгч, мал эмнэлэгийн улсын байцаагч нарыг цахимаар хамруулан Аймгийн засаг даргын 2022 оны 03 дугаар сарын 03-ны өдрийн А/133 дугаар захирамжаар батлагдсан “Бод мал-2022” нэгдсэн арга хэмжээний удирдамж төлөвлөгөөг танилцуулан мэдээлэл хийж үүрэг чиглэл өгч нээлтийн үйл ажиллагааг зохион байгуулав.

Мал хулгайлах гэмт хэрэгтэй тэмцэх, илрүүлэлтийг ахиулах, таслан зогсоох, урьдчилан сэргийлэх ажлыг эрчимжүүлэх, энэ төрлийн гэмт хэрэгт эрэн сурвалжлагдаж байгаа этгээдүүдийг олж тогтоох, хэрэг бүртгэлийн хэргүүдийг шуурхай шалгаж шийдвэрлэх зорилгоор Мал хулгайлах гэмт хэрэгтэй тэмцэх урьдчилан сэргийлэх ажлыг эрчимжүүлэх 2018 оны 106 дугаар дэд хөтөлбөрийн хэрэгжилтийг хангах, сумдын гэмт хэргээс урьдчилан сэргийлэх салбар зөвлөл иргэдийн оролцоог нэмэгдүүлэх зорилгоор аймгийн Засаг даргын 2022 оны 03 дугаар сарын 03-ны өдрийн а/138 тоот захирамжаар батлагдсан “Бод мал-2022” нэгдсэн арга хэмжээг аймгийн хэмжээнд зохион байгуулав.

Аймгийн Засаг даргын 2022 оны 03 дугаар сарын 03-ны өдрийн а/138 тоот захирамжаар батлагдсан “Бод мал-2022” нэгдсэн арга хэмжээний удирдамж, төлөвлөгөөг нийт бие бүрэлдэхүүнд танилцуулж, сумдын тасаг, хэсэг, хэсгийн төлөөлөгч нар салбар төлөвлөгөөг гаргаж зохион байгуулах ажлын хэсгийг байгуулан салбар төлөвлөгөөг боловсруулан 2022 оны 05 дугаар сарын 02-ны өдрөөс 60 хоногийн хугацаатай зохион байгуулав.

Аймгийн Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөл, аймгийн Засаг даргын зөвлөлд танилцуулан Мал хулгайлах гэмт хэрэгтэй тэмцэх урьдчилан сэргийлэх ажлыг эрчимжүүлэх дэд хөтөлбөрийн хүрээнд 1,000,000 /нэг сая/ төгрөгийг батлуулан шийдвэрлүүлж ажилласан.

Аймгийн хэмжээнд үйлдэгдэж байгаа мал хулгайлах болон малын гоц халдварт өвчин туссан малын махыг зах зээлд худалдан борлуулах зөрчлийг илрүүлэх, хэрэг бүртгэлт, зөрчлийн хэргүүдийг шийдвэрлэх ажлыг эрчимжүүлэх, Сумдад үйлдэгдсэн эзэнгүй малын хулгайн гэмт хэргүүдийн судалгааг сум бүрээр гарган, илрүүлэх, шийдвэрлэх дэмжлэг туслалцаа үзүүлэх зорилгоор зорилгоор нийт сумдад 5 ажлын хэсгийг тасаг, хэсгийн дарга, эрүүгийн ахлах мөрдөгч, эрүүгийн мөрдөгч, мөрдөгч нараар ахлуулан хөдөө сумдад үйл ажиллагаа явуулж байгаа мал, мах худалдан авах хувь хүн, аж ахуй нэгж байгууллагууд стандартын шаардлага хангаж байгаа эсэхэд Мэргэжлийн хяналтын газар, Мал эмнэлгийн газар, Цагдаагийн газар хамтарсан шалгалтыг зохион байгуулж илэрсэн зөрчлийг арилгуулан холбогдох арга хэмжээнүүдийг авч хяналтын камертай болох мал эмнэлгийн гэрчилгээний хэрэгжилтийг хангаж ажиллах чиглэлээр зөвлөмж, зааварчилга, ажлын чиглэл өгч ажиллав.

Мал хулгайлах гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх ажлыг эрчимжүүлэх чиглэлээр төрийн болон төрийн бус байгууллагуудтай хамтран ажиллах, мал бүхий иргэд, олон нийтэд мэдээлэл хүргэх ажлыг үр дүнтэй зохион байгуулах зорилгоор 2022 оны 03 дугаар сарын 10-ны өдөр Цагдаагийн газар, Мал эмнэлгийн газар, Мэргэжлийн хяналтын газар, Онцгой байдлын газар, ХХААГазар, бүх сумдын Засаг дарга, ИТХурлын дарга, багийн Засаг дарга, малын эмч, Сумдын хэсгийн төлөөлөгч, цагдаа зэрэг нийт 160 гаруй төрийн алба хаагч нарыг оролцуулан цахимаар зөвлөгөөнийг зохион байгуулан холбогдох мэдээ, мэдээллийг хүргүүлэн энэ төрлийн гэмт хэрэгтэй тэмцэх ажил бүх нийтийн үүрэг хариуцлага өндөр байгаа тул хамтарч ажиллах чиглэлээр мэдээлэл солилцож ажиллав. Зөвлөгөөний хүрээнд хил залгаа сумдын алба хаагч нарын цахим хаяг /и-майл, facebook/, утасны дугаарын судалгааг гаргаж алба хаагч нарт хүргүүлэн зүүн бүс “Бод-мал-2022” цахим групп нээж уг хаягаар алдсан, олдсон малын мэдээлэл, гэмт хэрэг үйлдэж болзошгүй сэжигтэй этгээдүүд, үйлдэгдэж буй гэмт хэргийн талаарх мэдээллийг солилцон хамтран ажиллаж байна.

“Бод мал-2022” нэгдсэн арга хэмжээний хүрээнд Дорнод аймгийн Баянтүмэн сумын 2 дугаар багийн нутаг дэвсгэрт зохиогдсон “Улсын хил хамгаалалтанд туслах хүчний гишүүдийн хэсэгчилсэн цугларалт уулзалтыг Эрүүгийн цагдаагийн эрүүгийн мөрдөгч цагдаагийн ахмад Э.Болор-Эрдэнэ хэсгийн төлөөлөгч, цагдаагийн дэслэгч Д.Батнасан нар Хилийн цэргийн 0132 дугаар ангийн 3 дугаар заставт 2022 оны 04 дүгээр сарын 26-ны өдөр зохион байгуулав.

Зөвлөгөөнд Хилийн албаны дарга, дэд хурандаа П.Эрдэнэбаяр, Баянтүмэн сумын засаг дарга Э.Нарангарав, Баянтүмэн сумын 2 дугаар багийн засаг дарга Ц.Буянхишиг нар болон Хилийн албаны туслах хүчний 12 гишүүдийн бүрэлдэхүүнтэйгээр цугларалт болж Эрүүгийн мөрдөгч, цагдаагийн ахмад Э.Болор-Эрдэнэ нь “Бод мал-2022” хэсэгчилсэн арга хэмжээ болон 2021 он, 2022 оны Мал хулгайлах гэмт хэргийн нөхцөл байдлыг танилцуулж Хэсгийн төлөөлөгч, цагдаагийн дэслэгч Д.Батнасан зөрчлийн тухай хууль, хилийн журам зөрчих үед авах арга хэмжээ, хариуцлага сэдвээр сургалт мэдээлэл зохион байгуулав

2022 оны 03 дугаар сарын 30-ны өдөр Сэргэлэн суманд “Малчдын зөвлөгөөн-2022” зохион байгуулж аймгийн малын хулгайн нөхцөл байдал, хулгайн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, туслах малчидын хувийн байдлыг судалж авах, малчдын бүлэг холбоог байгуулах, мал махны гарал үүслийн гэрчилгээнд хяналт тавих талаар илтгэл тавьж ажилласан. Малчдын зөвлөгөөнд Сэргэлэн сумын 43 иргэн оролцсон, зөвлөгөөнд оролцсон мал бүхий иргэдээс санал хүсэлтийг хүлээн авч ажиллав.

“Дорнод Бүсийн Эрчим Хүчний Систем” ТӨХК-ний зааланд Дорнод аймгийн Мал эмнэлэгийн газрын алба хаагчид болон сумдын мал эмнэлэгийн эмч нарыг оролцуулсан “ТАВАН ЭРДЭНИЙГ ЭМНЭХҮЙ” сэдэвт Мал эмнэлэгийн нэгдсэн зөвлөгөөнд оролцож Дорнод аймгийн малын хулгайн нөхцөл байдал, хулгайн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, мал махны гарал үүслийн гэрчилгээ олгоход малын зураг, им, тамга, онцлог содон шинж тэмдэг, тээврийн хэрэгсэлийн зураг оруулах, хариуцсан багаас бусад багийн иргэдэд малын гарал үүслийн гэрчилгээ олгохгүй байх, малын А дансгүй иргэдэд гарал үүслийн гэрчилгээ олгохгүй байх сэдвээр сургалт зохион байгуулж ажилласан.

Баянтүмэн сумын 4 багийн дарга, 5 малын эмч, мал үржлийн тасгийн дарга, сумын засаг дарга, хурлын дарга, хурлын нарын бичиг нарыг оролцуулан “Малын эмч нарын зөвлөгөөн”-г Баянтүмэн сумын иргэний танхимд зохион байгуулж Дорнод аймгийн малын хулгайн нөхцөл байдал, хулгайн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, малчдын бүлэг холбоог байгуулах, мал махны гарал үүслийн гэрчилгээ олгоход анхаарах асуудлын талаар илтгэл тавьж ажиллав.

Тус аймгийн нутаг дэвсгэрт мах, махан бүтээгдэхүүний үйлдвэрлэл, хадгалалт, бэлтгэн нийлүүлэлт, экспортын чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг иргэд /ченж/ аж ахуй нэгжүүд, гадаадын иргэдийн судалгааг гаргаж цагдаагийн хяналтанд авах зорилгоор Хэрлэн суманд мал мах бэлтгэх төвлөрсөн цэг “Их чулуут”, “Дорнод Мах маркет”, “Хөвчийн тал”, “Дорнын алтан тал”, “Талын таван толгой”, “Дорнод Хаан хүнс” зэрэг компаниуд бөөний үнээр их хэмжээгээр мал, мах бэлтгэж байгаад олон нийтийн 2 цагдаа, чиглэл хариуцсан алба хаагч нар хяналтыг тогтмол хийж ажилласан.

Хэрлэн суманд мал мах худалдан борлуулж байгаа 150 орчим ченж, хөдөө орон нутагт 50 гаруй ченж үйл ажиллагаа тогтмол явуулж байгаа тэдгээрт хууль тогтоомжид нийцүүлэн үйл ажиллагаагаа явуулах чиглэлээр санамж, мэдэгдэл өгч, худалдагдаж байгаа мал, маханд заавал гарал үүслийн гэрчилгээтэй байх, мал нэг бүрийн зургийг авч, бүртгэл хөтлөх шаардлагыг тавьж, хяналт шалгалтыг зохион байгуулж ажиллаж байна.

Мал хулгайлах гэмт хэрэгтэй тэмцэх, илрүүлэлтийг ахиулах, таслан зогсоох, урьдчилан сэргийлэх ажлыг эрчимжүүлэх, энэ төрлийн гэмт хэрэгт эрэн сурвалжлагдаж байгаа этгээдүүдийг олж тогтоох, хэрэг бүртгэлийн хэргүүдийг шуурхай шалгаж шийдвэрлэх зорилгоор Мал хулгайлах гэмт хэрэгтэй тэмцэх урьдчилан сэргийлэх ажлыг эрчимжүүлэх 2018 оны 106 дугаар дэд хөтөлбөрийн хэрэгжилтийг хангах, сумдын гэмт хэргээс урьдчилан сэргийлэх салбар зөвлөл иргэдийн оролцоог нэмэгдүүлэх зорилгоор аймгийн Засаг даргын 2022 оны 03 дугаар сарын 03-ны өдрийн а/138 тоот захирамжаар батлагдсан “Бод мал-2022” нэгдсэн арга хэмжээг аймгийн хэмжээнд зохион байгуулав. Нэгдсэн арга хэмжээний хүрээнд аймаг, сумдын Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөл болон Хэрлэн сумын Иргэдийн Төлөөлөгчдийн хурал, Засаг даргын тамгын газартай хамтран аймаг, сумдын нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж байгаа мал, махны худалдаа эрхэлдэг аж ахуй нэгж, зах худалдааны төвүүд, аймгийн төв зам дагуу малын хулгайн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр хийсэн зурагт самбар, боршур, аймгийн төвөөс орох, гарах төв зам дагуу байрлах Ялалт, Баянтүмэн гүүрний /10x12/ самбаруудад аннос байршуулж, 13 сумдаас гарах замуудад иргэдэд хандсан ухуулга сурталчилгааг хийсэн.

Мөн малын хулгайн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр ажиллаж буй алба хаагч нар аймгийн Хөгжимт драмын театрын найруулагч, жүжигчидтэй хамтран 2 шторк, контент нэвтрүүлэг бэлтгэн орон нутагт үйл ажиллагаа явуулдаг “Мижиг”, “Дорнод ТВ”, “Шинэ суваг”, “Жаран.мн” зэрэг хэвлэл мэдээллийн байгууллагуудаар цагдаагийн газар болон аймгийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөлийн раге хуудсаар мал хулгайлах гэмт хэргийн хохирогч болохоос урьдчилан сэргийлэх, малаа хариулга маллагаатай байлгах талаар анхааруулга сэрэмжлүүлгийг тогтмол нэвтрүүлж нэгдсэн арга хэмжээний талаарх мэдээллийг иргэдэд хүргэх зорилгоор орон нутгийн 6 телевизэд ярилцлага өгч, 2 ФМ радио болон Jaran.mn сайтад мэдээлэл тавьсан.

Арга хэмжээний хүрээнд “Хулгайч нарт боломж бүү олго”, “Малчин таны хариуцлага хамгийн чухал”, “Мал хулгайлах гэмт хэрэг үйлдэхээр бэлтгэж завдаж байгаа болон үйлдсэн тухай мэдээллийг иргэдээс төлбөртэй авч байна”, “Эрдэнэт болсон мал сүргээ эзэнгүй бүү орхи”, “Малын хулгайн ял шийтгэл чангарлаа” зэрэг 2500 ширхэг боршур зурагт хуудсыг бэлтгэн малчин болон мал бүхий иргэдэд түгээж, олон нийтийн цахим хэрэгсэл “facebook” хуудсанд бэлтгэсэн мэдээллийг түгээсэн нь үр дүнтэй урьдчилан сэргийлэх ажил болж байна

Нэгдсэн арга хэмжээний удирдамж төлөвлөгөөг батлуулж, сумдын тасаг, хэсгийн дарга, хэсгийн төлөөлөгч нарт арга хэмжээний төлөвлөгөөг хүргүүлж, арга хэмжээ эхэлсэнээс хойш эзэн холбогдогч нь тогтоогдоогүй 9 хэргийг илрүүлэн холбогдогч нарын мэдээлэл танилцуулж анхаарах асуудлын талаар Цагдаагийн газрын дарга үүрэг чиглэл өгч ажилласан.

“БОД МАЛ-2022” НЭГДСЭН АРГА ХЭМЖЭЭНИЙ НЭЭЛТИЙН АРГА ХЭМЖЭЭ БОЛЛОО

Аймгийн хэмжээнд үйлдэгдэж байгаа мал хулгайлах гэмт хэргүүдийг илрүүлэх, таслан зогсоох, хэрэг бүртгэлтийн хэргүүдийн шийдвэрлэлтийг ахиулах, энэ төрлийн гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлыг эрчимжүүлэх, мал хулгайлах гэмт хэрэгтэй тэмцэхэд төрийн болон төрийн бус байгууллага, олон нийтийн оролцоог нэмэгдүүлэх зорилгоор Аймгийн засаг даргын 2022 оны А/133 тушаалаар “Бод мал-2022” нэгдсэн арга хэмжээг 60 хоногийн хугацаатай зохион байгуулж эхэллээ.

Нээлтийн арга хэмжээ 2022 оны 03 дугаар сарын 10-ны өдөр цахимаар зохион байгуулагдаж, Цагдаагийн газрын дарга, дэд дарга, мал хулгайлах гэмт хэрэгтэй тэмцэх хэсгийн дарга, Мал эмнэлэгийн мэргэжилтэн, 13 сумын Засаг дарга, Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дарга, хэсгийн төлөөлөгч, цагдаа нар оролцож, Цагдаагийн газрын дарга, цагдаагийн хурандаа Т.Ганзориг сумдын удирдлага нарт хандаж, 14 хоног тутам үр дүнг тооцож, хамтарч ажиллах талаар үүрэг, ажлын чиглэл өгсөн байна.

“Мал хулгайлах гэмт хэргээс урьдчилан сэргийлэх” дэд зөвлөлийн гишүүд хуралдаж Цагдаагийн газрын Мал хулгайлах гэмт хэрэгтэй тэмцэх хэсгийн алба хаагчид 2021 онд Мал хулгайлах гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх чиглэлээр авч хэрэгжүүлсэн ажил, мал хулгайлах гэмт хэргийн нөхцөл байдал болон 2022 онд хийж гүйцэтгэх ажлын талаар ГХУСАЗСЗ-н зөвлөлийн гишүүдэд танилцуулав.

ОХУ-тай хил дамнан мал хулгайлах гэмт хэрэгтэй тэмцэх зорилгоор цахим зөвлөгөөн зохион байгуулж Цагдаагийн газрын даргын санаачлагаар аймгийн ЗДТГ-ын гадаад харилцааны хэлтсээр дамжуулан ОХУ-ын Өвөрбайгалын хязгаарын цагдаагийн газартай хамтран хил дамнан мал хулгайлах гэмт хэрэгтэй тэмцэх нь цахим хурал зохион байгуулахаар хүргүүлсэн хүсэлтийн хүрээнд цагдаагийн Ерөнхий газрын даргын зөвшөөрлөөр 2022 оны 03 дугаар сарын 01-ны өдөр ОХУ-н Дотоод яамны харъяа Өвөрбайгалийн хязгаарын цагдаагийн газрын удирдлагуудтай хамтарсан цахим зөвлөгөөн зохион байгуулж улирал бүр харилцан мэдээлэл солилцон ажиллахаар төлөвлөгөөнд тусгаж ажиллав.

Малчдын бүлгийг зохион байгуулсан талаар:

Иргэдийн сайн дурын үүсгэл санаачилгаар, мал сүргийг хамгаалах зорилготой малчид, мал бүхий иргэдийн бүлгийг баг хооронд ажиллуулах, олон нийтийн үүсэл санаачилгыг дэмжих иргэд малчдын эргүүл шалгалт зохион байгуулах, тэдний эрх үүрэг шагнал урамшуулал, нутаг дэвсгэр, айл саахалт, төрөл садангаараа хоршиж хамтын ажиллагаанд ахиц гаргах, аймгийн хэмжээнд мал хулгайлах гэмт хэргийн гаралтыг бууруулах, хууль тогтоомжийг сурталчлах, тайлбарлах, таниулах зорилгоор болзолт уралдааныг ГХУСАЗСЗ-н дарга М.Энхтөрөөр 03 дугаар тогтоол батлуулж ажиллаж байна.

Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын тэргүүлэгчдийн 106 дугаар тогтоолоор баталсан “Мал хулгайлах гэмт хэргээс урьдчилан сэргийлэх” дэд хөтөлбөрийн хүрээнд болзолт уралдаан зарлаж Чойбалсан, Дашбалбар, Булган сумдууд тус тус шалгарч ажлыг идэвхжүүлэх ажил арга хэмжээг зохион байгуулж байна.

Нийт бүртгэгдсэн гэмт хэргийн 40 буюу 23.1 хувийг хулгайн гэмт хэрэг эзлэж үүнээс хувийн өмчийн хулгай 19 бүртгэгдэж өмнөх оны мөн үетэй харьцуулбал ижил түвшинд, мал хулгайлах хэрэг 21 бүртгэгдсэн нь өнгөрсөн мөн оны үетэй харьцуулахад 10 хэргээр буюу 32.2 хувиар буурсан үзүүлэлттэй байна.

Эрэн сурвалжлах ажлын талаар: Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны журам код /229/-ийн 11 дэх заалтыг баримтлан Цагдаагийн газрын эрэн сурвалжлах ажлын “Орон тооны бус зөвлөл”-ийг Цагдаагийн газрын даргын 2019 оны 04 дүгээр сарын 09-ны өдрийн а/46 дугаар тушаалаар 9 алба хаагчийн бүрэлдэхүүнтэйгээр байгуулж, “Орон тооны бус зөвлөл”-ийг 14 хоног тутам хуралдуулж, эрэн сурвалжлах ажлын чанар, үр дүнг дээшлүүлэх, эрэн сурвалжлагдаж байгаа оргодол, гэмт хэрэгт сэрдэгдсэн этгээд, мал, амьтан, эд зүйлийг эрэн сурвалжлах ажлыг эрчимжүүлэх, шинээр томилогдсон алба хаагчдыг эрэн сурвалжлах “ASAP” сантай ажиллахад сурган дадлагажуулах зорилгоор цахим сургалтыг тогтмол зохион байгуулж байна.

Эрэн сурвалжлах “ASAP” сангийн ашиглалтыг сайжруулах, алба хаагчид мэдлэг, мэдээлэл олгох чиглэлээр Цагдаагийн газрын бие бүрэлдэхүүнд эрэн сурвалжлагдаж байгаа хүн, мал, амьтан, эд зүйл, тээврийн хэрэгслийг зарлан мэдээлэх, эрэн сурвалжлалтыг зогсоох, зарлан мэдээлэлтэй танилцах, эрэн сурвалжлах “ASAP” санд ажиллахдаа алдаа дутагдал гаргахгүй байх талаар сургалтын материал болон Эрэн сурвалжлах ажлын 7 хоногийн нөхцөл байдлын танилцуулгыг товч байдлаар бэлтгэн цагдаагийн газрын дотоод журамд заасан хуваарийн дагуу долоо хоног бүрийн баасан гарагт нийт алба хаагч нарт танилцуулж, мөн “Дорнод цагдаа-Дотоод ажил” цахим хаалттай хуудсанд байршуулан алба хаагч нарт танилцуулах ажлыг хэвшүүлсэн.

Эрэн сурвалжлах “asap” сангийн ашиглалт, бүрдүүлэлтийн талаар:

Эрэн сурвалжлах, зарлан мэдээллийн “ASAP” сангийн ашиглалтад 2022 оны 1 дүгээр улирлын байдлаар мэдээлэл бүртгэлийн төлөв байдалд дүн шинжилгээ хийхэд оршин суугаа газраасаа алга болсон хүн 3, шүүхээс даалгасан хүн 27, оргодол 6, гэмт хэрэгт сэрдэгдсэн этгээд 23, тээврийн хэрэгсэл 2, мал амьтан 22, эд зүйл 21, аман зургаар 1, зөрчил үйлдсэн хүн 3, нийт 108 мэдээлэл оруулснаас бүртгэгдээгүй, шаардлага хангаагүй мэдээлэл байхгүй ба 108 зарлан мэдээллийг оруулж, 68 зарлан мэдээллийг олж тогтоон зогсоож, төвлөрсөн тоо бүртгэлд авснаар тус цагдаагийн газрын “Asap” сангийн илрүүлэлтийн хувь 2022 оны 1 дүгээр улирлын байдлаар 62,9 хувьтай байна.

Эрэн сурвалжлагдсан хүн, мал, эд зүйлийг олж тогтоосон талаар:

Эрэн сурвалжлах мэдээллийн “ASAP” сангийн ашиглалт 2022 оны 1 дүгээр улирлын байдлаар мэдээлэл бүртгэлийн төлөв байдалд дүн шинжилгээ хийхэд алба хаагчдаас эрэн сурвалжлах мэдээллийн “ASAP” санд 108 зарлан мэдээллийг оруулснаас 68 зарлан мэдээллийг олж тогтоон, зарлан мэдээллийг зогсоосноор “ASAP” сангийн илрүүлэлтийн хувь 2022 оны 1 дүгээр улирлын байдлаар байдлаар 62,9 хувьтай байна.

Одоогийн байдлаар санд энэ оны 40, урьд оны 41, нийт 81 зарлан мэдээлэл шийдвэрлэгдээгүй байна.

Эрэн сурвалжлах “Орон тооны бус ажлын хэсэг”-ийн ажлыг эрчимжүүлэх, алба хаагчдад ажлын зааварчилга хүргүүлж, санд оруулсан зөрчилтэй мэдээллийг тухай бүр засуулах арга хэмжээг тогтмол авч, тасаг, албадын дарга нараас тавих хяналтыг сайжруулах чиглэлээр үүргийг өгч, үр дүнг тооцон ажилласан.

МӨРДӨН БАЙЦААХ ТАСАГ: Тус тасгаас хүн, хуулийн этгээдээс ирүүлсэн урьд оны үлдэгдэл 26, энэ оны эхний 06 сард 378, нийт 404 гомдол мэдээлэл хүлээн авч шалгаснаас 225

гомдол мэдээллийг хэрэг бүртгэлтийн хэрэг нээхээс татгалзаж, 42 гомдол мэдээлэлд хэрэг бүртгэлтийн хэрэг нээж, 113 гомдол мэдээлэлд эрүүгийн хэрэг үүсгэн яллагдагчаар татаж шийдвэрлэн, 2 гомдлыг харьяаллын дагуу шилжүүлж, 22 гомдол мэдээллийн үлдэгдэлтэй ажилласан.

Урьд оны үлдэгдэл хэрэг бүртгэлтийн 35, энэ оны эхний 06 сард шинээр нээсэн болон харьяаллын дагуу шилжиж ирсэн 76 хэргийг хүлээн авч, нийт 111 хэрэгт мөрдөн шалгах ажиллагаа явуулснаас 38 хэргийг хааж, 41 хэргийг эрүүгийн хэрэг үүсгэн яллагдагчаар татаж, 8 хэргийг харьяаллын дагуу шилжүүлж шийдвэрлэн 24 хэргийн үлдэгдэлтэй ажилласан.

Нийт шийдвэрлэсэн хэргээс өмнө оны үлдэгдэл 12 хэрэгт эрүүгийн хэрэг үүсгэн яллагдагчаар татаж, 14 хэргийг хааж, 5 хэргийг харьяаллын дагуу шилжүүлж шийдвэрлэсэн байна.

Мөрдөн байцаалтын 246 хэрэгт мөрдөн шалгах ажиллагаа явуулснаас 213 хэргийг шүүхэд шилжүүлэх, 14 хэргийг хэрэгсэхгүй болгох саналтай прокурорт хүргүүлж, 9 хэргийг нэгтгэн, 2 хэргийг харьяаллын дагуу шилжүүлж, 8 хэргийн үлдэгдэлтэй ажиллалаа.

Энэ оны эхний хагас жилийн байдлаар Шүүх, прокуророос нэмэлт мөрдөн байцаалтад 7 хэрэг буцсан байна. Тус тасагт түдгэлзүүлсэн хэрэг байхгүй болно.

Тус тасагт энэ оны 06 дугаар сарын байдлаар олон үйлдэл, холбогдогчтой, ээдрээ төвөгтэй, хугацаа хэтэрсэн, олны анхаарал татсан хэрэг шалгагдаагүй болно.

Тайлангийн хугацаанд иргэн, хуулийн этгээдээс ирүүлсэн урьд оны үлдэгдэл 26, энэ оны эхний 03 дугаар сард 195, нийт 221 гомдол мэдээлэл хүлээн авч шалгаснаас 110 гомдол мэдээллийг хэрэг бүртгэлтийн хэрэг нээхээс татгалзаж, 22 гомдол мэдээлэлд хэрэг бүртгэлтийн хэрэг нээж, 61 гомдол мэдээлэлд эрүүгийн хэрэг үүсгэн яллагдагчаар татаж шийдвэрлэн, 1 гомдлыг харьяаллын дагуу шилжүүлж, 27 гомдол мэдээллийн үлдэгдэлтэй ажилласан.

Урьд оны үлдэгдэл хэрэг бүртгэлтийн 35, энэ оны эхний 03 сард шинээр нээсэн болон харьяаллын дагуу шилжиж ирсэн 39 хэргийг хүлээн авч, нийт 74 хэрэгт мөрдөн шалгах ажиллагаа явуулснаас 19 хэргийг хааж, 20 хэргийг эрүүгийн хэрэг үүсгэн яллагдагчаар татаж, 2 хэргийг харьяаллын дагуу шилжүүлж шийдвэрлэн 33 хэргийн үлдэгдэлтэй ажилласан.

Нийт шийдвэрлэсэн хэргээс өмнө оны үлдэгдэл 11 хэрэгт эрүүгийн хэрэг үүсгэн яллагдагчаар татаж, 9 хэргийг хааж, 1 хэргийг харьяаллын дагуу шилжүүлж шийдвэрлэсэн байна.

Мөрдөн байцаалтын 128 хэрэгт мөрдөн шалгах ажиллагаа явуулснаас 114 хэргийг шүүхэд шилжүүлэх, 5 хэргийг хэрэгсэхгүй болгох саналтай прокурорт хүргүүлж, 1 хэргийг нэгтгэн, 2 хэргийг харьяаллын дагуу шилжүүлж, 6 хэргийн үлдэгдэлтэй ажиллалаа.

Энэ оны 03 дугаар сарын байдлаар нэмэлт мөрдөн байцаалтад шүүх, прокуророос хэрэг буцаагүй байна. Тус тасагт түдгэлзүүлсэн хэрэг байхгүй болно.

“ИТГЭВЭЛ ШАЛГА” ХЭСЭГЧИЛСЭН АРГА ХЭМЖЭЭ ЗОХИОН ЯВАГДАЖ БАЙНА.

Цагдаагийн ерөнхий газрын даргын 2022 оны А/104 дугаар тушаалын хэрэгжилтийн хүрээнд тус Цагдаагийн газраас цахим залилах гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, иргэдийн санхүүгийн зах зээлийн тогтвортой байдлыг хангах, санхүүгийн хэрэглэгчийн хууль ёсны эрхийг хамгаалах, цахим орчинд мэдээллийн аюулгүй байдлыг хангах, иргэдийн эрх зүйн мэдлэгийг дээшлүүлэх, цаашид энэ төрлийн гэмт хэргийн хохирогч, хариуцагч болохоос сэргийлэх зорилгоор “Итгэвэл шалга” хэсэгчилсэн арга хэмжээг 2022 оны 04 дүгээр сарын 25-ны өдрөөс эхлэн нэг сарын хугацаатай зохион явуулж байна.

Арга хэмжээний хүрээнд аймаг, орон нутаг төдийгүй улсын хэмжээнд залилах гэмт хэргийн гаралт өсөх хандлагатай байгааг шинжлэн судалж, шалтгаан нөхцөлийг тогтоох, урьдчилан сэргийлэхэд чиглэсэн олон талт ажил, арга хэмжээнүүдийг хэрэгжүүлэн ажиллаж байна.

Мөн Цагдаагийн ерөнхий газрын Мөрдөн байцаах алба, Эрүүгийн цагдаагийн албаны Кибер гэмт хэрэгтэй тэмцэх хэлтсээс барьж буй бодлого зорилтын хүрээнд төрийн болон төрийн бус байгууллагуудад цахим залилах гэмт хэргийн талаарх ойлголт, онцлог мэдээ мэдээлэл, энэ төрлийн гэмт хэргийн эрх

зүйн орчны талаарх сургалт, соён гэгээрүүлэх ажлыг зохион байгуулан ажиллаж байна.

ЗАМЫН ЦАГДААГИЙН ТАСАГ: Иргэдийн төлөөлөгчдийн хурал, Аймгийн Гэмт Хэргээс Урьдчилан Сэргийлэх Ажлыг Зохицуулах Салбар Зөвлөлд тээврийн осол, хэргийн улмаас иргэдийн нас барах, гэмтэж бэртэх явдлыг бууруулах чиглэлээр “Зам тээврийн гэмт хэрэг, осол, зөрчлөөс урьдчилан сэргийлэх 2021-2023” хэрэгжүүлэх дэд хөтөлбөрийн 2021 онд зохион байгуулсан ажлын танилцуулга, гарсан гэмт хэрэг, осол, зөрчлийн шалтгаан нөхцөл, хүрсэн үр дүнгийн талаарх криминологи судалгааг танилцуулгын хамт гарган Аймгийн Гэмт Хэргээс Урьдчилан Сэргийлэх Ажлыг Зохицуулах Салбар Зөвлөлийн тэргүүлэгчдийн хурлаар хэлэлцүүлэн ажиллалаа.

Гудамж замын хяналт шалгалтаар 5151 зөрчил илрүүлэн ажилласнаас согтуугаар тээврийн хэрэгсэл жолоодсон 421, эрхийн үнэмлэхгүй болон эрхээ хасуулсан үедээ тээврийн хэрэгсэл жолоодсон 58, нийт түр саатуулах үндэслэлээр 459 тээврийн хэрэгслийг түр саатуулж, замын хөдөлгөөний хууль, дүрмийг бусад байдлаар зөрчсөн 4657 жолоочид 126,267.5 мянган төгрөгийн торгуулийн арга хэмжээ оногдуулан 64 жолоочийн эрхийг хасаж 22 жолоочийг шүүгчийн шийтгэврээр 7-30 хоногийн хугацаагаар баривчлуулан шийтгэлийн хуудсаар 363 жолоочийн жолоодох эрхийг тус бүр 1 жилээр хасаж 363 жолоочийг 145.200.0 мянган төгрөгийн торгуулийн арга хэмжээ оногдуулж ажиллажээ.

Цагдаагийн газрын даргын баталсан удирдамж, төлөвлөгөөний дагуу Зам тээврийн гэмт хэрэг, осол, зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр “Уусан бүү жолоод” нэгдсэн арга хэмжээ, “Өвлийн дугуй”, “Тусгай дуут дохио” хэсэгчилсэн арга хэмжээг аймгийн хэмжээнд зохион байгуулав.

Согтуугаар тээврийн хэрэгсэл жолоодох зөрчлийг таслан зогсоох, “Уусан бол бүү жолоод” нөлөөллийн арга хэмжээ сурталчилах мөн Дорнод аймгийн цагдаагийн газраас зохион байгуулж буй арга хэмжээний талаар орон нутгийн ЖАРАН, D-1 ТВ-д видео мэдээлэл өгсөн. “DON'T DRINK AND DRIVE” арга хэмжээний хүрээнд “Шөнийн сурвалжлага” контетийг Дорнод аймагт идэвхтэй үйл ажиллагаа явуулдаг “Дорнод ДАТА”, “Jaran.mn” page хуудастай хамтран бэлтгэн олон нийтийн мэдээллийн сүлжээнд түгээж ажилласан.

Цагдаагийн Ерөнхий газар Тээврийн цагдаагийн албанаас зохион зөвийг хэвшүүлье уриан дор зохион байгуулж буй “Гар утас” нөлөөллийн арга хэмжээ, цагийн менежентийн хуваарийн дагуу үүрэг гүйцэтгэхдээ 500 ширхэг санамж сэрэмжлүүлэг хуудас тараан зам тээврийн гэмт хэрэг, осол, зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр улсын чанартай хатуу хучилттай А/0502 дугаарын авто замд Баянтүмэн сумын чиглэлд байнгын 1, Булган сумын чиглэлд хөдөлгөөнт эргүүл 1, Хөлөнбуйр сумын чиглэлд байнгын хяналтын пост 1, хөдөлгөөнт эргүүл 1, тус тус хяналт шалгалтыг эрчимжүүлэн ажиллуулснаар магистрал замд зам тээврийн гэмт хэрэг, осол бүртгэгдээгүй байна.

Засгийн газрын 2019 оны 163 дугаар тогтоолоор Замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах үндэсний стратеги /2019-2023/-ийг хэрэгжилтийг хангах зорилгоор “Зам тээврийн ослын улмаас үүсэх нийгмийн эрсдэлийг 50 хувиар бууруулна” гэсэн зорилтыг хэрэгжүүлэх зорилгоор Дорнод аймагт хэрэгжиж буй “Зам тээврийн гэмт хэрэг, осол, зөрчлөөс урьдчилан сэргийлэх 2021-2023” хэрэгжүүлэх дэд хөтөлбөрийг батлуулан ажиллаж байна.

Бүртгэгдсэн хэрэг, осол ижил түвшинд, гэмтсэн хүн 2 нэгжээр буурсан бол зам тээврийн ослын улмаас нас барсан хүн бүртгэгдээгүй эерэг үзүүлэлттэй байна.

НИЙТИЙН ХЭВ ЖУРАМ ХАМГААЛАХ ТАСАГ: Тус тасгаас *òîäîððîé òðëëéí äýìò õýäýä, ç°ð÷-ëëëä áóððóóëäð, òàñëàí çîäñîð, óðüä÷-ëëäí ñýðäëëëýð +ëäëýëýýð “Nàð øëé-*

MNS5527:2019, Цагдаагийн ерөнхий газрын даргын 2017 оны А/39 дүгээр тушаалаар баталсан Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны “Захиргааны журмаар албадан саатуулах /код 623/ журам, А/40 дүгээр тушаал: “Албадан эрүүлжүүлэх /код 630/ журам”-аар зохицуулагдан, үйл ажиллагаагаа хэрэгжүүлэн ажиллаж байна.

Эрүүлжүүлэх, саатуулах байрны ахуй нөхцөл шаардлагад нийцэж байгаа эсэхэд дүн шинжилгээ хийж, аймгийн Онцгой байдлын газартай хамтран галын аюулгүй байдлын дүгнэлт гаргуулан, Мэргэжлийн хяналтын газарт албан тоот хүргүүлж Эрүүлжүүлэх, саатуулах, байрны ахуй нөхцөл шаардлагад нийцэж байгаа эсэхэд Мэргэжлийн хяналтын газрын улсын хяналтын байцаагчаар саатуулагдсан хүмүүсийн хоногт олгож буй хоолны дээжийг шинжилгээнд өгч, илчлэгийг тодорхойлуулан хэвийн үйл ажиллагааг хангаж ажиллаж байна.

Эрүүлжүүлэх, саатуулах байранд эрүүл ахуй нян судлалын дүгнэлт гаргуулахад бохирдолгүй, нянгийн үүсгэвэргүй гэж дүгнэгдсэн байна.

Эрүүлжүүлэх, саатуулах байранд “Эгэл-Альфа” ХХК-р ариутгал, халдваргүйжүүлэлт хийлгэх талаар гэрээ байгуулж ариутгал халдваргүйтгэлийг хийлгэсэн.

Эрүүлжүүлэх, саатуулах байрны ачааллыг нэмэгдүүлэхгүй байх, нэг хүнд ноогдох талбайн хэмжээнд тохируулж үйл ажиллагаагаа зохион байгуулах чиглэлээр эрүүлжүүлэх, саатуулах байрны алба хаагч нарт “Зааварчилга, зөвлөмж”-ийг өгч ажилласан.

MNS 5527:2019 стандартад заагдсан эм тариа тоног төхөөрөмжийн хангалт ашиглалтын хугацааг шалган нөхөн хангалт хийж “Ази фарм” эмийн сантай гэрээ байгуулсан.

Аймгийн хэмжээнд 2022 оны хагас жилийн байдлаар эрүүлжүүлэх байранд 1237 хүн зөрчлийн улмаас эрүүлжүүлэгдсэн байна. Үүнээс эрэгтэй-1146 эмэгтэй-90, насанд хүрээгүй хүүхэд-1, гадаадын иргэн-0 бүртгэгдсэн байна.

Аймгийн Эрүүл мэндийн газар, болон Бүсийн оношилгоо, эмчилгээний төвийн дарга, захирал нарт хамтран ажиллах талаар тоот албан бичгийг хүрүүлэн Согтуурах, мансуурах донтой 66 хүнийг үзлэг, шинжилгээнд хамруулсанаас 55 иргэнд биеийн ерөнхий байдал хөнгөн, архинд донтох өвчтой болох нь үзлэгээр тогтоогдож Сум дундын иргэний хэргийн анхан шатны шүүхэд холбогдох материалыг хүргүүлээд байна. Согтуурах, мансуурах донтой хүнийг албадан эмчилгээнд хамруулах болон сайн дүрын эмчилгээнд хамруулах хүсэлтийг хүлээн авах бүртгэлийг гаргаж, алба хаагч нараас хүний эрх, эрх чөлөөг зөрчихгүй байх талаар зааварчилга өгч, мэргэжлийн удирдлагаар ханган ажиллаж байна. Мөн Хэрлэн сумын 7 дугаар багийн нутагт дэвсгэрт тэнэмэл байдлаар амьдардаг согтуурах, мансуурах донтой, сэтгэцийн эмгэгтэй Б.Хүрэлбаатар, Б.Болдбаатар нарыг эмчилгээнд хамруулах зорилгоор Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төвийн эмч нартай холбогдон эмчилгээнд хамруулсан. Уг иргэдийн хэсгийн байцаагч д/ч Э.Золбаяр цагдаа жолооч Х.Хүрэлбаатар нар 10-61 дор улсын дугаартай тээврийн хэрэгсэлээр хуяглан хүргэх ажиллагааг зохион байгуулсан.

Эрүүлжүүлэгдсэн нийт хүмүүсийг багаар нь авч үзэхэд: 1-р багаас-149, 2-р багаас-184, 3-р багаас-97, 4-р багаас-167, 5-р багаас-12, 6-р багаас-127, 7-р багаас-76, 8-р багаас-30, 9-р багаас-85, 10-р багаас-114, 11-р багаас-27 тодорхой оршин суух хаяггүй-25, Улаанбаатар хотын харъяат-20, хөдөө орон нутгаас-108 тус тус бүртгэгдэж, Булган сумаас-25, Баян-түмэн сумаас 32, Цагаан-Овоо сумаас-21, Баян-Уул сумаас-7, Баяндун сумаас-5, Дашбалбар сумаас-4, Сэргэлэн сумаас-3, Чулуунхороот сумаас-3, Гурванзагал сумаас-3, Чойбалсан сумаас-8, Матад сумаас-6 Халх голоос-10, Хөлөнбуйр сумаас-5, Бусад аймгаас-9 хүнийг албадан эрүүлжүүлж холбогдох бүртгэл тэмдэглэлийг хөтлөн, эрүүл мэндийн үзлэгийг хийж хяналтандаа авч ажилласан байна.

Цагдаагийн газрын дотоод сүлжээнд 1242 картыг шивж, Шүүх шинжилгээний албаны папилон санд 241 хүний гарын хээг шинээр авч бүртгэв.

Тайлангын хугацаанд Эрүүлжүүлэгдсэн нийт 978 хүнээс өдөрт нь төлбөр хураамж авсан, нөхөн төлсөн-150 хүн, нийт 1128 хүнээс 4.726.850 / Дөрвөн сая долоон зуун хорин зургаан мянга найман зуун тавин / төгрөгийн төлбөр хураамжийг авч, төлбөрийн тайланг тухай бүрт нь санхүү албанд хүргүүлэн ажилласан. Төлбөр төлөлт 91.2 %-тай барагдуулсан байна.

Тус байранд албадан эрүүлжүүлэгдсэн хүмүүсийг зөрчлийн утгаар нь ангилвал: гэр орон сууцанд 945, гудамж талбайд 169, замаас 48, олон нийтийн газар -2, нийтийн зах-5, дэлгүүр түц-17, зочид буудал-48, баар-24, ресторан-9, төрийн байгууллага-12, аж ахуй нэгж-8, Засвар үйлчилгээнээс-2, орц хонгил-32, бусад газраас-7 хүн тус тус бүртгэгдсэн байна.

Хууль зүйн сайдын 2017 оны 09 сарын 05-ны өдрийн А/185 дугаар тушаалаар батлагдсан “Саатуулах байрны дэглэм, журам” ”Цагдаагийн ерөнхий газрын даргын 2017 оны А/39 дүгээр тушаал: “Захиргааны журмаар албадан саатуулах /код 623/ журам”, А/40 дүгээр тушаал: “Албадан эрүүлжүүлэх /код 630/ журам”, “Эрүүлжүүлэх байрны ариун цэвэр, эрүүл ахуйн нөхцөл, эмнэлгийн үйлчилгээ MNS 5527:2019 стандарт болон бусад холбогдох хууль журмын хэрэгжүүлтийн биелэлтийг хангах зорилгоор дотоод нөөц бололцоог ашиглан хувцас хадгалах өрөөг тохижуулан жижүүрийн өрөөгөөр дамжин орох эмэгтэй баривчлах өрөө болгон засварлаж, номын сан, сургалтын өрөөний зохиулалтаар, ариутгал халдваргүйжүүлэлт, цагаан хэрэглэл угааж индүүдэх өрөөг гурван давхарт тохижуулсан,. Эрүүлжүүлэх, саатуулах байрны даргын ажлын өрөөг сургалтын өрөөний зохиулалтаар ашиглаж журмын хэрэгжилтийг ханган ажиллаж байна.

Эрүүлжүүлэх байрны хамгаалалт, гэрэлтүүлэг, дохиолол, телехяналтын болон дуу бичлэгийн хэрэгслийн хэвийн эсэхийг тогтмол шалган алба хаагч, үйлчлүүлэгч нарын аюулгүй байдлыг ханган ажиллаж байна. Цагдаагийн газрын жижүүрийн шуурхай алба /102/-т суурьлуулсан нэгдсэн /төв/ телекамер болон тус эрүүлжүүлэх байранд байрлуулсан нэмэгдэл камеруудын тусламжтайгаар байранд тавих хяналтыг 24 цагаар тасралтгүй явуулж алба хаагч, үйлчлүүлэгч нарын аюулгүй байдлыг ханган ажиллаж байна.

Цагдаагийн байгууллагын эрэн сурвалжилах, мэдээ мэдээлэл олж илрүүлэх нийтлэг үүргийн хүрээнд цагдаагийн газрын дотоод сүлжээ “Asap” сантай танилцах ажлыг тогтмолжуулан ажиллаж байна.

Эрүүлжүүлэх байрны жижүүрийн алба хаагчдаас цагдаагийн байгууллагын нийтлэг үүргийн дагуу зохион байгуулж буй нэгдсэн эргүүлд хувиарын дагуу хамрагдаж, орон нутгийн төр захиргааны байгууллага, аж ахуй нэгжийн харуул манааны сонор сэрэмж, аюулгүй ажиллагаа болон архи тамхины тусгай зөвшөөрлийн хугацаа, худалдаа үйлчилгээний газруудын цагийн хуваарь, шатахуун түгээх станц, онцгой объектын хамгаалалт, замын хөдөлгөөний бүрэн бүтэн байдалд үзлэг, шалгалтыг хийж, гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлыг эрчимжүүлэн, холбогдох мэргэжлийн байгууллагын урьдчилан сэргийлэх хамтын ажиллагааг өргөжүүлэн ажиллав.

Цагдаагийн ерөнхий газрын болон цагдаагийн тасаг, албад, аймаг орон нутгаас зохион байгуулж буй урьдчилан сэргийлэх ажил, арга хэмжээнд тогтмол оролцож, гэмт хэрэг, зөрчлийг илрүүлэн ажилласан талаар холбогдох албан тушаалтанд “Илтгэх хуудас”-аар танилцуулан ажилласан байна.

Тус Цагдаагийн Эрүүлжүүлэх, саатуулах байр нь Монгол Улсын үндсэн хууль, Зөрчлийн тухай хууль, Согтууруулах ундаа хэтрүүлэн хэрэглэсэн этгээдийг албадан эрүүлжүүлэх тухай хууль, Хууль зүйн, дотоод хэргийн сайдын 2017 оны А/185 дугаар тушаалаар батлагдсан “Саатуулах байрны дэглэм, журам”, Эрүүлжүүлэх байрны ариун цэвэр, эрүүл ахуйн нөхцөл, эмнэлгийн үйлчилгээ MNS5527:2019, Цагдаагийн ерөнхий газрын даргын 2017 оны А/39 дүгээр тушаалаар баталсан Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны “Захиргааны журмаар албадан саатуулах /код 623/ журам, А/40 дүгээр

тушаал: “Албадан эрүүлжүүлэх /код 630/ журам”-аар зохицуулагдан, үйл ажиллагаагаа хэрэгжүүлэн ажиллаж байна.

Эрүүлжүүлэх, саатуулах байранд “Эгэл-Альфа” ХХК-р ариутгал, халдваргүйжүүлэлт хийлгэх талаар гэрээ байгуулж ариутгал халдваргүйтгэлийг хийлгэсэн.

Эрүүлжүүлэх, саатуулах байрны ачааллыг нэмэгдүүлэхгүй байх, нэг хүнд ноогдох талбайн хэмжээнд тохируулж үйл ажиллагаагаа зохион байгуулах чиглэлээр эрүүлжүүлэх, саатуулах байрны алба хаагч нарт “Зааварчилга, зөвлөмж”-ийг өгч ажилласан.

MNS 5527:2019 стандартад заагдсан эм тариа тоног төхөөрөмжийн хангалт ашиглалтын хугацааг шалган нөхөн хангалт хийж “Ази фарм” эмийн сантай гэрээ байгуулсан.

Аймгийн хэмжээнд 2022 оны 01 дүгээр улирлын байдлаар эрүүлжүүлэх байранд 672 хүн зөрчлийн улмаас эрүүлжүүлэгдсэн байна. Үүнээс эрэгтэй-611 эмэгтэй-50, насанд хүрээгүй хүүхэд-0, гадаадын иргэн-0 бүртгэгдсэн байна.

Эрүүлжүүлэгдсэн нийт хүмүүсийг багаар нь авч үзэхэд: 1-р багаас-84, 2-р багаас-105, 3-р багаас-45, 4-р багаас-277, 5-р багаас-7, 6-р багаас-10, 7-р багаас-38, 8-р багаас-21, 9-р багаас-47, 10-р багаас-80, тодорхой оршин суух хаяггүй-24, Улаанбаатар хотын харъяат-6, хөдөө орон нутгаас-40 тус тус бүртгэгдэж, Булган сумаас-317, Баян-түмэн сумаас 9, Цагаан-Овоо сумаас-13, Баян-Уул сумаас-15, Баяндун сумаас-5, Дашбалбар сумаас-1, Сэргэлэн сумаас-1, Чулуунхороот

сумаас-1, Гурванзагал сумаас-2, Чойбалсан сумаас-2, Матад сумаас-5, Халхгол сумаас-7, Хөлөнбуйр сумаас-1, бусад аймгаас 4 хүнийг албадан эрүүлжүүлж холбогдох бүртгэл тэмдэглэлийг хөтлөн, эрүүл мэндийн үзлэгийг хийж хяналтандаа авч ажилласан байна.

Цагдаагийн газрын дотоод сүлжээнд 668 картыг шивж, Шүүх шинжилгээний албаны папилон санд 136 хүний гарын хээг шинээр авч бүртгэв.

Албадан эрүүлжүүлэгдсэн иргэдэд “Албадан сургалт”-ыг тогтмол зохион байгуулж, холбогдох хууль эрх зүйн болон урьдчилан сэргийлэх сургалт мэдээллийг олон нийтэд сурталчлах ажлыг эрчимжүүлэв. “Ухаарал” төрийн бус байгууллагын мэргэжилтэн, сургагч багш С.Батболд “Архинаас татгалзах арга” сэдвээр, ГБХЗХГазрын сургалт хариуцсан ажилтан Д.Болорчимэг нартай хамтарч “Архины хор нөлөө” сэдвээр, “Гэр бүлийн хүчирхийллийн тухай”, Зөрчлийн тухай хууль зэрэг сэдвүүдээр архины хамааралтай иргэдийн зан чанарт нөлөөлөх сургалтыг тасралтгүй явуулж, урьдчилан сэргийлэх хамтын ажиллагааг өргөжүүлэн ажиллаж байна.

Шүүх, шүүгчийн аюулгүй байдлыг хангах чиглэлээр: Нийтийн хэв журам хамгаалах тасгийн Шүүх, шүүгчийн аюулгүй байдлыг хангах хэсгийн алба хаагчид тайлангийн хугацаанд батлагдсан хувиар томилгооны дагуу шүүхийн байранд 24 цагаар 160 удаа гарч 3840 хүн цагийн үүрэг гүйцэтгэж ажиллаа.

Тус хэсгийн хамгаалалтын цагдаа нар Эрүүгийн хэргийн анхан шатны шүүх хурал 207, Эрүүгийн хэргийн анхан шатны урьдчилсан хэлэлцүүлгийн хурал 16, ял солих шүүх хурал 10, цагдан хорио сунгах шүүх хурал 23, Иргэний хэргийн анхан шатны шүүх хурал 295, Эрүүгийн хэргийн давж заалдах шатны шүүх хурал 34, Иргэний хэргийн давж заалдах шатны шүүх хурал 23, Зөрчлийн хэргийн хурал 258, Захиргааны хэргийн анхан шатны шүүх хурал 22 нийт 888 шүүх хурлын дэг журам сахиулж ажилласан. Үүнээс шүүх хуралдаанд давхардсан тоогоор шүүгч-1076 улсын ялагч 550, нарийн бичгийн дарга 888, өмгөөлөгч 186, шүүгдэгч 261, хохирогч 75, хариуцагч 266, нэхэмжлэгч 184, зөрчилд холбогдогч 271, гэрч 21, бусад 78 тус тус оролцсон.

ШШГГазрын Цагдан хорих байрнаас шүүхийн байр хүртэл 63 удаа 155 яллагдагч, шүүгдэгч яланг /насанд хүрсэн эрэгтэй 154, насанд хүрсэн эмэгтэй 1/ шүүхийн байрнаас ШШГГазрын цагдан хорих байр хүртэл 75 удаа 169 шүүгдэгч, /насанд хүрсэн эмэгтэй 2, насанд хүрсэн эрэгтэй 167/ яланг албаны автомашинаар нийт 138 удаа 322 яллагдагч,

гудамж тайлбай олон нийтийн газруудад гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх зохион байгуулалтын арга хэмжээ авч ажиллаж байна.

Цагдаагийн газрын даргын 2021 оны 04 дүгээр сарын 01-ны өдрийн А/33 тушаалаар “Вакцинжуулалтад цагдаагийн алба хаагчдыг хамруулах” ажлын хэсгийг 3 алба хаагчийн бүрэлдэхүүнтэй байгуулж алба хаагч, олон нийтийн цагдаа, ажилчдыг вакцинжуулалтад хамруулах үйл ажиллагааг зохион байгуулснаар 3-р тунд бүрэн хамрагдсан 4-р тунд 164 алба хаагчийг хамруулан 2022 оны 03 дугаар сарын 23-ны байдлаар 98,5%-тай хамрагдлаа.

Коронавируст халдварт /КОВИД-19/ цар тахлаас урьдчилан сэргийлэх чиглэлээр Цагдаагийн газрын даргын тушаалаар томилогдсон Шуурхай удирдлагын тасгийн даргаар ахлуулан, 6 алба хаагчийн бүрэлдэхүүнтэй ажлын хэсгээс үүрэг гүйцэтгэж байгаа бие бүрэлдэхүүнд халдвараас урьдчилан сэргийлэх, халдвар, хамгааллын хувцас хэрэгсэл хэрэглэх чиглэлээр цахим болон бичгээр 16 удаа зөвлөмж хүргүүлж, 4 удаа сургалт, мэдээлэл хийх, халдвар хамгааллын хувцас хэрэглэлийн нөөц бүрдүүлэх, албан хаагчдад хуваарилах, ариутгал, хадваргүйтгэл хийх зэрэг ажил арга хэмжээг тухай бүр нь зохион байгуулсан.

ШУУРХАЙ УДИРДЛАГЫН ТАСАГ: Тайлангийн хугацаанд “Монгол Улсад бүртгэгдсэн гэмт хэргийн мэдээллийн сан бүрдүүлэх /код-701/ журам”-ийн хэрэгжилтийг хангах үүднээс 2022 оны эхний 1 дүгээр улирлын байдлаар иргэд байгууллагаас нийт 1229 гомдол мэдээллийн хүлээн авч мэдээлийн сангийн гомдол мэдээллийн санд шивж оруулан ажилласан. Гэмт хэргийн мэдээллийн санд 366, зөрчлийн санд 863 мэдээлэл шивэгдсэнийг хянаж, баталгаажуулан мэдээллийн үнэн зөв, бодит байдлыг хангаж, мэдээлэл бүрийг төвлөрсөн тоо бүртгэлд бүртгэн авч ажилласан.

Энэ оны 1 дүгээр улирлын байдлаар гэмт хэргийн шинжтэй 366 гомдол мэдээллийг хүлээн авч шалгаснаас 129 буюу 35.2 хувьд нь хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын хэрэг нээж, 159 гомдол мэдээлэл буюу 43.4 хувийг хэрэг бүртгэлтийн хэрэг нээхээс татгалзах саналтай прокурорт шилжүүлэн, зөрчлийн шинжтэй 871 гомдол мэдээлэл хүлээн авч шалгаснаас 115 буюу 13.2 хувьд нь зөрчлийн хэрэг нээж, 436 буюу 50.4 хувийг хялбаршуулсан журмаар шийдвэрлэн, 264 буюу 30.3 хувийг зөрчлийн шинжгүй гэх үндэслэлээр татгалзаж шийдвэрлэжээ.

Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны “Монгол улсад бүртгэгдсэн гэмт хэргийн тоо бүртгэл хөтлөх /код 701/ журам”, “Зөрчлийн тоо бүртгэл хөтлөх /код 702/ журам”-ыг хэрэгжүүлэх, мэдээллийн сангийн ашиглалт, бүрдүүлэлтийг сайжруулах, нэмэгдүүлэх зорилгоор 2022 оны 01 дүгээр сарын 06-ны өдөр “Эрүүгийн хэргийн тулгалт-хяналт”, 01 дүгээр сарын 10-ны өдөр “Гэмт хэргийн сан бүрдүүлэх”, 01 сарын 17-ны өдөр “Зөрчлийн сан бүрдүүлэх” 02 дугаар сарын 02 сарын 09-ний өдөр “Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны журам 701, 702”-ын хэрэгжилтийг хангах, 03 дугаар сарын 16-ны “Өргөдөл гомдлын сан бүрдүүлэх” зэрэг хэсэгчилсэн болон тусгай арга хэмжээнүүдийг зохион байгуулж алба хаагч нар сургалт орж ажилласан.

Цагдаагийн байгууллагын мэдээллийн нэгдсэн системээс зөрчилд холбогдож байсан талаар лавлагаа авахаар хандсан 13 албан бичгийн 265 иргэнд иргэний эрүүгийн хариуцлага хүлээж байсан эсэх лавлагааг, алба хаагч нараас захиргааны хяналтаны ХӨТЯШ-тэй иргэдийн гэмт хэрэг, зөрчилд холбогдсон эсэх талаарх лавлагааг давхарсан тоогоор 3, эрүүгийн хэрэгт шалгагдаж байгаа этгээдүүд эрүүгийн хариуцлага хүлээсэн эсэх талаарх лавлагааг давхардсан тоогоор 15, иргэний гэмт хэрэг зөрчилд холбогдсон талаарх лавлагаа тус тус мэдээллийн сангаас шалган өгч цагдаагийн байгууллагын ажил үйлчилгээг түргэн шуурхай үзүүлэв.

Судалгааны хяналтын сангийн чиглэлээр гэмт хэргийг илрүүлэхэд ашиглах зорилгоор хамтарсан багуудаас объект, субъектийн 16 төрлийн судалгааг мэдээллийн санд шивж оруулсаныг зөрчлийн тоо бүртгэгч, мэдээлэл судалгааны мэргэжилтэн нар хянаж төвлөрсөн тоо бүртгэлд авч ажилласан. Үүнд: Гэмт хэрэг үйлдэгдэж болзошгүй эмзэг цэг 26, зочид буудал 6, автомашин дулаан граж, ил зогсоол 4, банк, банк бус

санхүүгийн байгууллага, хадгаламж зээлийн хоршоо 2, томоохон зах бөөний төв 1, хаягдал түүхий эд авдаг газар 2, эмнэлэг 1, архи согтууруулах ундаагаар үйлчилдэг аж ахуйн нэгж 42, аялал жуулчлал, амралтын газар 1, авто засвар сэлбэг хэрэгсэл борлуулдаг газар 4, интернет, РС тоглоом, өнгөт хэвлэгч, олшруулагч ашигладаг газар 1, боловсролын байгууллага 1, эмийн сан, үйлдвэр 2, улсын онц чухал объект 1, гэмт хэрэгт уруу татагч 41, гэр бүлийн хүчирхийлэл үйлдэгч 24, архаг архичин 44, тэнэмэл иргэд 12, ченжүүд 24, алт мөнгөний дархан 1, зэрэг объект, субъектын судалгаанд тогтмол баяжилт хийж ажиллаж байгааг хянаж ажиллаж байна.

Цагдаагийн ерөнхий газрын Мэдээлэл дүн, шинжилгээ шуурхай удирдлагын албанаас ирүүлсэн 2, бусад албанаас ирүүлсэн 3 төрлийн ажлын зөвлөмж, үүрэг, албан тоотыг хүлээн авч, төлөвлөгөө гарган, Цагдаагийн газрын даргаар батлуулан, гүйцэтгэж ажилласан бөгөөд хугацаанд нь хүргүүлж ажиллалаа. Мөн Цагдаагийн газрын даргаас өгсөн 8 төрлийн үүрэг, Шуурхай удирдлагын тасгийн даргаас өгсөн 5 төрлийн үүргийг тухай бүр нь хугацаанд нь хийж хэрэгжүүлэн танилцуулж ажилласан.

Аймгийн аж ахуйн нэгж, төрийн болон төрийн бус байгууллагуудыг Цагдаагийн байгууллагын нэгдсэн камерт холбох зорилгоор бааз антен 99 дүгээр байранд суурилуулан, аймгийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зардлаас шийдвэрлүүлэн 105 цэгийн 128 теле камерыг Цагдаагийн газрын жижүүрийн өрөөнд өдөр тутам хяналт тавьж ажиллаж байна.

Мөн 2022 онд Аймгийн орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр шинээр тавигдах телехяналтын камерын 48 цэгийн судалгаа гаргах, Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар шинээр тавигдах телехяналтын камерын 210 цэгийн судалгааг google earth програм дээр хийж холбогдох газарт хүргүүлж ажилласан.

Цагдаагийн газрын Шуурхай удирдлагын тасгийн жижүүрийн 102 дээр хянагдаж байгаа Аймгийн гудамж, зам талбайн хяналтын 128 камераас бүрэн бүтэн байдал, хэвийн ажиллагааг хангах зорилгоор ажиллахгүй камерыг газар дээр нь үзэж, шалгах ажлыг “Гэрэл сэтгэмж” ОНӨҮГ-тай хамтран гүйцэтгэн ажиллаж байна.

ЗӨРЧЛИЙН ХЭРЭГ БҮРТГЭХ ТАСАГ: Тус Цагдаагийн газраас иргэн хуулийн этгээдээс 2020-2022 онд 9214 зөрчлийн шинжтэй гомдол, мэдээлэл хүлээн авснаас 2022 оны эхний 6 сарын байдлаар 1636 гомдол мэдээлэл хүлээн авсан байна. Үүнээс 2022 оны эхний 6 сарын байдлаар 219 гомдол, мэдээлэлд зөрчлийн хэрэг нээж, 458 гомдол, мэдээллийг зөрчлийн хэрэг нээхээс татгалзах саналтай прокурорт шилжүүлж, 853 хялбаршуулсан журмаар шийдвэрлэж, 12 гомдол мэдээллийг харъяаллын дагуу шийлжүүлж шийдвэрлэсэн.

Хүлээн авсан нийт гомдол, мэдээллийг хуулийн хугацаанд шалгасан ба ажиллагаанд 94 гомдол мэдээлэл хуулийн хугацаанд шалгагдаж байна. Хугацаа хэтрүүлэн шалгасан гомдол мэдээлэл байхгүй.

Хялбаршуулсан журмаар 2022 оны эхний 6 сард 926 хүнд 306.955.000₮ төгрөгийн торгууль оногдуулж шийдвэрлэсэн.

Аймгийн Прокурорын газраас санаачлан зохион байгуулсан тус аймаг дахь хууль, хяналтын байгууллагуудын хамтарсан зөвлөгөөний арга хэмжээ батлагдсан удирдамжийн дагуу 2022 оны 04 дүгээр сарын 08-ны өдрийн 14.00 цагаас 17.30 цагийн хооронд Цагдаагийн газрын хурлын зааланд зохион байгуулагдаж, аймгийн Шүүх, Прокурор, Цагдаа, Шүүхийн шийдвэр гүйцэтгэл, Шүүхийн шинжилгээний албаны дарга удирдлага, алба хаагчид хамрагдсан.

Зөвлөгөөний үйл ажиллагааг Аймгийн орлогч прокурор Б.Арсланбаатар удирдан явуулж, удирдамжийн дагуу аймгийн Шүүхийн газраас Эрүүгийн хэргийн давж заалдах шатны ерөнхий шүүгч Б.Ганчимэг, аймгийн Прокурорын газрын мэдээллийг аймгийн ерөнхий прокурор, хууль цаазын шадар зөвлөх Н.Доржсүрэн, Шүүхийн шинжилгээний албаны дарга, хурандаа Баярбат, Шийдвэр гүйцэтгэх газрын дарга, дэд хурандаа Эрдэнэбат, Цагдаагийн газрын дэд бөгөөд эрүүгийн цагдаагийн тасгийн дарга, цагдаагийн дэд хурандаа

3.Баянжаргал нар тус бүр 10 минутын мэдээлэл хийж, мэдээлэлтэй холбогдуулан зөвлөгөөнд оролцогчдын асуултад хариулав.

Прокурорын шаардлагын мөрөөр зөрчил гаргасан алба хаагчдад заагдсан зөрчлийг арилгуулах талаар бичгээр зааварчлага өгч, Прокурорын байгууллагатай хамтран 2 удаа зөвлөгөөн зохион байгуулж, Зөрчлийн хэрэг бүртгэх тасгийн даргаас 1 удаа, ахлах байцаагчаас 1 удаа “Шийтгэлийн болон шийтгэлээс чөлөөлөх хуудасны маягт, хэрэглэх журам”, “Албадлагын арга хэмжээний төрөл, ойлголт, шийтгэлийн хуудас, хариу мэдэгдэх хуудас үйлдэх” сэдэвт сургалтыг зөрчлийн хэрэг бүртгэл явуулах эрх бүхий албан тушаалтнуудыг хамруулан зохион байгуулсан, зөрчил шалган шийдвэрлэх эрх бүхий албан тушаалтнаар хууль, тогтоомжийг бие даан судлуулах хяналтын хуудас болосруулан гаргаж, прокурорын шаардлагад зөрчил заагдсан албан тушаалтнуудаар холбогдох хууль, тогтоомжийг судлуулан тэмдэглэл хөтлүүлж, Цагдаагийн газрын дарга болон Зөрчлийн хэрэг бүртгэх тасгийн дарга нараас хянаж, хангалгүй үнэлгээтэй алба хаагчдаас хууль, эрх зүйн мэдлэгийн түвшинг тогтоох шалгалт авч, шалгалтын үнэлгээнд үндэслэн сургалтын материал боловсруулж, албаны сургалтыг зохион байгуулж байгаа нь зөрчил гаргасан алба хаагчдыг бие даан хууль, тогтоомжийг судалж, мэдлэг, чадвараа дээшлүүлэхэд ач холбогдолтой байна.

Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны журам “Зөрчлийн хэрэг бүртгэх ажиллагаанд хяналт тавих /Код-409/ журам”-ын 409.3.3- д заасны дагуу тодорхой зөрчлийн хэргийг шийдвэрлэх, зөрчлийн хэрэг бүртгэх ажиллагаанд учирч буй хүндрэл, бэрхшээлийг арилгах, харилцан санал солилцох чиглэлээр харьяалах шүүх, прокурорын байгууллагатай 2020 онд 1 удаа, 2021 онд 2 удаа, 2022 оны эхний 6 сарын байдлаар 2 удаа хамтарсан зөвлөгөөн зохион байгуулж ажилласан.

Долоо хоног бүр зөрчил шалган шийдвэрлэх чиглэлээр зохион байгуулсан ажил, алба хаагчдын ажлын ачаалал, гомдол, мэдээлэл болон зөрчлийн хэргийн шийдвэрлэлт, хугацааны байдалд дүн шинжилгээ хийж, 7 хоногийн “Баасан” гарагийн өглөөний нэгдсэн мэдээллийн үеэр танилцуулан ажиллаж байна.

Мөн Зөрчлийн хэрэг бүртгэх тасгийн даргаас зөрчил шалган шийдвэрлэх ажиллагааны чиглэлээр зөрчил шалган шийдвэрлэх эрх бүхий албан тушаалтнуудад 2022 оны 03 дугаар сарын 30-ны өдөр 1 төрлийн 12 заалт бүхий зааварчилга, 5 заалт бүхий зөвлөмж, ахлах байцаагчаас 1 төрлийн 12 заалт бүхий зааварчилга туус тус бичгээр хүргүүлсэн.

ЧОЙБАЛСАН ХОТЫН УНДНЫ ЭХ ҮҮСВЭРИЙГ ХАМГААЛАХ ТУСГАЙ САЛБАР:

Чойбалсан хотын ус хангамжийн эх үүсвэрийг хамгаалах тусгай салбарын алба хаагчид батлагдсан томилгооны дагуу 2022 оны эхний хагас жилд “Дорнод нийтийн аж ахуй” орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газартай байгуулсан харуул хамгаалалтын ажлын гэрээнд заасны дагуу улсын онц чухал объектын харуул хамгаалалтад 850 удаа 20400 хүн/ цагийн харуул, хамгаалалтын үүрэг гүйцэтгэсэн.

Салбарын харуулчин, ахлагч нар улсын онц чухал объектын шалган нэвтрүүлэх 1-р пост, хяналтын 2,3-р постонд албан үүрэг гүйцэтгэх хугацаандаа цэвэр усны анги хориотой болон ариун цэврийн бүсэд өдрийн болон өглөө оройн ээлжинд гарч ажилласан 2819, гаднаас албан ажлаар нэвтэрсэн 469 хүний бичиг баримт болон биед үзлэг шалгалт хийж нэвтрүүлэн, 1282 тээврийн хэрэгсэлд үзлэг шалгалт хийж, 4142 хөдөлгөөн хяналтад авч, зориулалтын бус газраар нэвтрэхийг оролдсон 44 зөрчил, объектод тогтоосон дэглэм журам зөрчсөн 20, бичиг баримтын 11 зөрчил, нийт 75 зөрчлийг тус тус илрүүлэн шийдвэрлэж ажиллалаа.

Улсын онц чухал объектын хамгаалалтын нөхцөл байдлын талаар Дотоодын цэргийн штабын жижүүр Марал-10 болон цагдаагийн газрын жижүүрт тогтмол танилцуулж, үүрэг чиглэл авч ажиллаж байна. Улсын онц чухал объектын харуул, хамгаалалтад үүрэг

гүйцэтгэсэн харуулчин, ахлагч нарын ажлын хариуцлага, албаны сонор сэрэмжийг цагдаагийн газрын ёс журмын эргүүл, салбарын захирагч, хариуцлагатай эргүүлүүд нийт 280 удаа шалгаж, тодорхой үүрэг чиглэл бичгээр өгч, биелэлтийг тооцон ажиллалаа.

Салбарын хариуцлагатай эргүүлийг 24 цагаар томилон улсын онц чухал объектын харуул хамгаалалтад үүрэг гүйцэтгэж байгаа алба хаагчдын сонор сэрэмж, албаны бэлэн байдлыг тогтмол шалгаж, хамгаалуулагч байгууллагын удирдлагад хамгаалалтын үйл ажиллагааны мэдээлэл болон хамгаалуулагч байгууллагын ажилчдаас илрүүлсэн зөрчил, харуул хамгаалалтад ашиглагдаж байгаа инженер техник хэрэгслийн засвар үйлчилгээ бусад шаардлагатай зүйлийн талаарх мэдээллийг албан бичгээр өгч, хариуг тооцон, улсын онц чухал объектод нэвтэрч байгаа ажилчдын биеийн халууныг хэмжиж бүртгэл хөтлөн, гарыг ариутган нэвтрүүлж амны хаалтгүй ажилтныг нэвтрүүлэхгүйгээр буцаан хамгаалуулагч байгууллагын удирдлагад танилцуулж, заавар зөвлөмж хүргүүлэн хяналт тавин ажиллаж байна. Шалган нэвтрүүлэх байр болон хяналтын цэгүүдэд ариутгал цэвэрлэгээг тогтмол хийлгүүлж, үүрэг гүйцэтгэх хугацаанд амны хаалтыг тогтмол зүүж хэвших талаар үүрэг, ажлын чиглэл өгч, хамгаалуулагч байгууллагатай хамтран ариутгал, халдваргүйтгэлийг хийн, тогтоосон дэглэмийг сахиулан, урьдчилан сэргийлэх арга хэмжээ авч ажиллаж байна.

Чойбалсан хотын ус хангамжийн эх үүсвэрийг хамгаалах тусгай салбарын алба хаагчид батлагдсан томилгооны дагуу 2022 оны 01 дүгээр улиралд “Дорнод нийтийн аж ахуй” орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газартай байгуулсан харуул хамгаалалтын ажлын гэрээнд заасны дагуу улсын онц чухал объектын харуул хамгаалалтад 445 удаа 10680 хүн/ цагийн харуул, хамгаалалтын үүрэг гүйцэтгэсэн.

Салбарын харуулчин, ахлагч нар улсын онц чухал объектын шалган нэвтрүүлэх 1-р пост, хяналтын 2,3-р постонд албан үүрэг гүйцэтгэх хугацаандаа цэвэр усны анги хориотой болон ариун цэврийн бүсэд өдрийн болон өглөө оройн ээлжинд гарч ажилласан 1149, гаднаас албан ажлаар нэвтэрсэн 135 хүний бичиг баримт болон биед үзлэг шалгалт хийж нэвтрүүлэн, 612 тээврийн хэрэгсэлд үзлэг шалгалт хийж, 1663 хөдөлгөөн хяналтад авч, зориулалтын бус газраар нэвтрэхийг оролдсон 13 зөрчил, объектод тогтоосон дэглэм журам зөрчсөн 9, бичиг баримтын 2 зөрчил, нийт 24 зөрчлийг тус тус илрүүлэн шийдвэрлэж ажиллалаа.

Улсын онц чухал объектын хамгаалалтын нөхцөл байдлын талаар Дотоодын цэргийн штабын жижүүр Марал-10 болон цагдаагийн газрын жижүүрт тогтмол танилцуулж, үүрэг чиглэл авч ажиллаж байна. Улсын онц чухал объектын харуул, хамгаалалтад үүрэг гүйцэтгэсэн харуулчин, ахлагч нарын ажлын хариуцлага, албаны сонор сэрэмжийг цагдаагийн газрын ёс журмын эргүүл, салбарын захирагч, хариуцлагатай эргүүлүүд нийт 135 удаа шалгаж, тодорхой үүрэг чиглэл бичгээр өгч, биелэлтийг тооцон ажиллалаа.

Салбарын хариуцлагатай эргүүлийг 24 цагаар томилон улсын онц чухал объектын харуул хамгаалалтад үүрэг гүйцэтгэж байгаа алба хаагчдын сонор сэрэмж, албаны бэлэн байдлыг тогтмол шалгаж, хамгаалуулагч байгууллагын удирдлагад хамгаалалтын үйл ажиллагааны мэдээлэл болон хамгаалуулагч байгууллагын ажилчдаас илрүүлсэн зөрчил, харуул хамгаалалтад ашиглагдаж байгаа инженер техник хэрэгслийн засвар үйлчилгээ бусад шаардлагатай зүйлийн талаарх мэдээллийг албан бичгээр өгч, хариуг тооцон, улсын онц чухал объектод нэвтэрч байгаа ажилчдын биеийн халууныг хэмжиж бүртгэл хөтлөн, гарыг ариутган нэвтрүүлж амны хаалтгүй ажилтныг нэвтрүүлэхгүйгээр буцаан хамгаалуулагч байгууллагын удирдлагад танилцуулж, заавар зөвлөмж хүргүүлэн хяналт тавин ажиллаж байна. Шалган нэвтрүүлэх байр болон хяналтын цэгүүдэд ариутгал цэвэрлэгээг тогтмол хийлгүүлж, үүрэг гүйцэтгэх хугацаанд амны хаалтыг тогтмол зүүж хэвших талаар үүрэг, ажлын чиглэл өгч, хамгаалуулагч байгууллагатай хамтран ариутгал, халдваргүйтгэлийг 7 хоногт 2 удаа хийж нийт 20 удаа халдваргүйжүүлэлт хийн, тогтоосон дэглэмийг сахиулан, урьдчилан сэргийлэх арга хэмжээ авч хяналт тавин ажиллаж байна.

В. СЭТГЭЛ ЗҮЙН ЧИГЛЭЛЭЭР ЗОХИОН БАЙГУУЛСАН АЖИЛ: Цагдаагийн ерөнхий газрын даргын 2017 оны 12 дугаар сарын 20-ны өдрийн А/246 дугаар тушаалаар баталсан ЦБҮАЖ-ийн /код-938/-д заасны дагуу алба хаагчид сэтгэл

зүйн тусламж дэмжлэг үзүүлэх үйлчилгээний чиглэлээр цагдаагийн алба хаагчийн сэтгэл зүйн байдлыг судлан оношлох, цагдаагийн байгууллагын алба хаагч, ажиллагсдад зориулсан сэтгэл зүйн сургалт зохион байгуулах, мэдээлэл өгөх, алба хаагч, ажиллагсдын хүсэлтээр сэтгэл зүйн зөвлөгөө өгөх, сэтгэл засал болон дэмжих бүлгийн ярилцлага хийх, мэргэжлийн тусламж, үйлчилгээний явцад гарсан асуудлаар санал, зөвлөмж боловсруулж, удирдлагад мэдээлэл өгөх, цагдаагийн байгууллагын хүний нөөцийн сонгон шалгаруулалтад мэргэжлийн туслалцаа үзүүлж, хамтран ажиллах, мэргэжлийн мэдлэг, чадвараа хөгжүүлэх, шинийг санаачилж, хэрэгжүүлэх чиглэлээр ажил, арга хэмжээ зохион байгуулж ажиллалаа.

Алба хаагчдын сэтгэл зүйн байдлыг тодорхойлох, ажлаас халшрах хам шинжийн судалгааны дүгнэлтэд үндэслэн сэтгэл зүйн тусламж үзүүлэх, алба хаагчдын ажлын онцлог байдлыг үнэлж дүгнэн, хийж хэрэгжүүлэх ажлыг тодорхойлох зорилгоор Цагдаагийн байгууллагын хүний нөөцийн цахим санд байршуулсан сэтгэл зүйн судалгаанд давхардсан тоогоор нийт 284 алба хаагч хамрагдсан ба судалгааны үр дүнг боловсруулан ажиллав.

Алба хаагчдын стресс, сэтгэл гутрал, сэтгэл түгшүүр, ажлаас халшрах хам шинжийн хоорондын хамаарлыг судлах, статистик дүн шинжилгээ хийж хамаарлын түвшинг тогтоох зорилгоор SPSS программ¹-ыг ашиглах дүн шинжилгээ хийж ажиллалаа.

Дээрх судалгааны дүнд үндэслэн ажлаас халшрах хам шинжийн хэт өндөр илрэлтэйгээр судлагдсан 7 алба хаагчтай сэтгэл зүйн ярилцлага хийж, сэтгэл зүйн зөвлөмж, зөвлөгөө өгч, стрессийн түвшин өндөр, сэтгэл гутралтай 11 алба хаагчид зөвлөмж бичиж ажилласан.

Сэтгэл зүйн байдлыг илрүүлэх судалгаанд стресс, сэтгэл гутроын түвшин өндөр судлагдсан алба хаагчид тухайн албан тушаалд томилогдоод 1-2 жил болсон байгаа нь ажлын туршлага бага, тухайн албан тушаалд мэргэшээгүй, мэргэжил арга зүйн хувьд дутмаг байдал нөлөөлж байгаа тул шинээр томилогдсон, шинээр болон албан тушаал өөрчлөн ажиллаж байгаа алба хаагчдыг Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны “Цагдаагийн байгууллагын үйл ажиллагаанд дасан зохицох” журмын /код-944/- ын хэрэгжилтийг ханган, энэ онд шинээр томилогдсон 2 алба хаагчид сэтгэл зүйн зөвлөмж, зөвлөгөө өгсөн.

Алба хаагчдын мэдлэгийг дээшлүүлэх зорилгоор “Бие хүний хоорондын харилцаа ба ёс зүй, мэргэжлийн онцлогоос шалтгаалах сэтгэл зүйн өөрчлөлт”, “Харилцаанд тулгамддаг асуудал, түүнийг даван туулах арга зам” сэдвүүдээр сургалт зохион байгуулсан.

Тус цагдаагийн газрын “Дорнод цагдаа-Алба хаагчдын чөлөөт индэр” цахим хаягт эрүүл мэнд, сэтгэл зүйн багаас алба хаагчдын эрүүл мэнд, сэтгэл зүйн боловсролыг нэмэгдүүлэх зорилгоор цахим зөвлөмж 2, сэтгэл зүйн мэдээлэл 5 удаа байршуулан ажиллаж байна.

Г. АРХИДАН СОГТУУРАЛТАЙ ТЭМЦЭХ, ХУУЛИЙН ХЭРЭГЖИЛТИЙГ ХАНГАХ ЧИГЛЭЛЭЭР:

Аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын тэргүүлэгчдийн 2018 оны 11 дүгээр сарын 27-ны өдрийн 105 дугаар тогтоолоор батлагдсан “Архигүй Дорнодчуудын төлөө” дэд хөтөлбөрийн хүрээнд Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөлөөс 2022 онд авч хэрэгжүүлэх ажил, арга хэмжээнд төлөвлөгөөнд 10.000.000 төгрөгийг тусгуулан авч, удирдамж төлөвлөгөөний дагуу ажил арга хэмжээг зохион байгуулан ажиллаж байна.

Аймгийн Засаг даргын захирамжийн хэрэгжилтэд хяналт тавин ажиллах хугацаанд цагийн хязгаар зөрчин үйл ажиллагаа явуулсан аж ахуй нэгжийг Гамшгаас хамгаалах тухай хуулийн 5.13.2 дахь заалтаар 6 иргэнийг 900,000 төгрөгөөр, зохих зөвшөөрөлгүй тамхи худалдан борлуулсан 4 аж ахуй нэгжийг Монгол улсын Зөрчлийн тухай хуулийн 6.3.2 дахь хэсгээр нийт 1,200,000 төгрөгийн торгуулийн арга хэмжээг ногдуулан ажиллав.

Мөн иргэд Хэрлэн сумын 24-р байрны такси зогсоол дээр иргэд архи согтууруулах ундааг гар дээрээс хууль бусаар худалдан борлуулдаг зөрчлийг илрүүлэх, таслан зогсоох чиглэлээр ажлын хэсэг томилон, “Архи хяналт-шалгалт”, “Такси хяналт шалгалт” хэсэгчилсэн арга хэмжээнүүдийг зохион байгуулан ажиллуулж тухайн бүс нутагт 1

автомашинтай 2 алба хаагч, мөн Замын цагдаагийн хөдөлгөөнт постыг байршуулан ажилласнаар нийт 7 зөрчил илрүүлэн Зөрчлийн тухай хуулийн 6.5-р зүйлийн 13 дахь хэсэгт зааснаар 35 иргэнийг тус бүр 50,000 төгрөгөөр буюу нийт 1.650,000 төгрөгийн торгуулийн арга хэмжээ ногдуулан ажиллалаа.

Арга хэмжээний хүрээнд аймаг, орон нутгийн “Дорнод ТВ”, “Мижи”, “Jaran.mn” хэвлэлийн байгууллагуудтай хамтарсан үзлэг шалгалтын 12 удаа зохион байгуулж илэрсэн зөрчил дутагдлыг олон нийтэд хүргэж ийм зөрчил дутагдал гаргасан иргэдэд хүлээлгэх хариуцлагын талаар сануулж хууль бусаар архи согтууруулах ундаа худалдан борлуулахгүй байхыг уриалсан нэвтрүүлэг бэлтгэн иргэдэд хүргэж ажилласан.

Аймгийн Гэр бүл хүүхэд хөгжлийн залуучуудын газартай хамтран Их дээд болон, ерөнхий боловсролын сургуулийн орчинд үйлдэгдэх гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх зорилгоор оюутан, сурагчдад архины хор уршгийг ойлгуулан таниулах сургалтыг эрүүл мэндийн байгууллагатай хамтран “Дорнод их сургууль”, “Политехникийн коллеж”, “Мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төв, Ерөнхий боловсролын 12 сургууль, сумдын 13 сургуулийн 3120 оюутан сургачдад “Архины хор уришиг, “Зөвийг зөвлөө”, “Архи ба үе тэнгийнхэн” сэдэвт сургалтуудыг зохион байгуулсан.

Монгол Улсад орчин цагийн зэвсэгт хүчин үүсэн байгуулагдсаны 101 жилийн ой, “Монгол цэргийн өдөр”-ийг угтаж, Дорнод аймгийн үндэсний аюулгүй байдлыг хангах, тусгайлсан чиг үүрэг бүхий байгууллагуудын дунд зохион байгуулагдсан урлаг спортын 11 төрлийн тэмцээн зохион байгуулагдаж энэ үеэр тэмцээний баг тамирчид, хөгжөөн дэмжигч нар нөлөөлийн аян арга хэмжээг сурталчилан 965 иргэнд эрх зүйн мэдлэгийг дээшлүүлэх, согтууруулах ундааны зохисгүй хэрэглээг багасгах, тэднийг зөв үйлдэлд уриалах, согтууруулах ундааг хэрүүлэн хэрэглэхгүй байх талаар зөвлөгөө мэдээлэл өгч ажилласан.

Согтууруулах ундаагаар үйлчилдэг аж ахуй нэгж байгууллагаар гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, архины хор хөнөөлийг иргэдэд сурталчлах чиглэлээр уриалга, зөвлөмж, мэдэгдэл хүргэх ажлыг баг хариуцсан хэсгийн байцаагч, хэсгийн төлөөлөгч, эргүүлийн цагдаа, хэсгийн ахлагч нартай хамтран зохион байгуулж аймгийн хэмжээнд үйл ажиллагаа явуулдаг 312 аж ахуй нэгж байгууллагатай хамтран сурталчилгааны ажлыг зохион байгуулан байгууллагын мэдээллийн самбар иргэд үйлчлүүлэг хэсэгт постерыг байршуулан ажиллалаа.

Д. ГЭР БҮЛИЙН ХҮЧИРХИЙЛЭЛ, ХҮҮХДИЙН ГЭМТ ХЭРГЭЭС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ ЧИГЛЭЛЭЭР:

Тус Цагдаагийн газраас аймгийн хэмжээнд "Олон улсын хүүхдийн эрхийг хамгаалах өдөр"-ийг тэмдэглэн өнгөрүүлэхтэй холбогдуулан аймгийн Засаг даргын захирамжаар авто замын хөдөлгөөнийг Хэрлэн сумын төв хэсэг болох Тусгаар тогтнолын талбайн уулзвар гарцуудад түр хязгаарлалт хийж, хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах ажлыг зохион байгуулан ажиллав.

Мөн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зорилгоор баярын үйл ажиллагааны үеэр хүн ам ихээр бөөгнөрөх, хүүхэд багачууд төөрөх явдлаас сэргийлж, Тусгаар тогтнолын талбай дээр алба хаагч нар эргүүл, хамгаалалтын үүрэг гүйцэтгэн ажиллалаа.

сарын 18-ны өдрийн А/128 дугаар захирамжаар “ИРГЭН ТАНЫ ТӨЛӨӨ” аян аймгийн хэмжээнд зохион явуулж эхлээд байна.

Аяны хүрээнд иргэд олон нийттэй уулзан, санал хүсэлтийг нь сонсох, хууль, эрх зүйн тусламж үзүүлэх, гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх нөлөөллийн “Сэрэмжилье-Нэгдье” сарын аян зохион байгуулагдаж байна.

Уг арга хэмжээний хүрээнд “Гэр бүлийн хүчирхийллийн тухай ойлголт”, “Залилан мэхлэх гэмт хэргээс урьдчилан сэргийлэх”, “Бэлгийн хүчирхийлэл”, “Хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх” зэрэг сэдвээр нутаг дэвсгэрийн хэмжээнд үйл ажиллагаа явуулж байгаа байгууллага, аж ахуй нэгж, ерөнхий боловсролын сургууль, сургуулийн өмнөх боловсролын байгууллагуудад хуваарийн дагуу сургалт мэдээллийг хийлээ.

Цагдаагийн ерөнхий газар, Гэр бүлийн хүчирхийлэл хүүхдийн эсрэг гэмт хэрэгтэй тэмцэх хэлтсээс зохион байгуулсан Жендерийн хүчирхийллийн эсрэг “Жаргалтай гэр бүл” арга хэмжээг цагдаагийн газрын фэйсбүүк болон аймгийн олон дагагчтай группүүд болон аймгийн Дорнод телевиз, ТВ6, МИЖИ телевиз, цагдаагийн газарт байрлах урсдаг самбараар нэвтрүүлж иргэд олон нийтэд хүргэн мөн цагдаагийн газрын фэйсбүүк хэрэглэдэг алба хаагч нар болон хамтран ажилладаг төрийн болон төрийн бус байгууллагын ажилтнуудад уриалга гарган арга хэмжээний хүрээнд хийгдсэн 20 шторк, постер, подкаст, видеог цагдаагийн газрын фэйсбүүк болон олон хандагчтай 25-40 группт тухай бүр түгээсэн “Жаргалтай-гэр бүл” хэсэгчилсэн арга хэмжээг зохион явууллаа.

Тус Цагдаагийн газраас “Олон улсын хүүхдийн эрхийг хамгаалах өдөр”-ийг тохиолдуулан “Хүүхэд бидний ирээдүй” арга хэмжээг 2022 оны 05 дугаар сарын 31-ний өдөр “Мөрөөдлийн ордон” тоглоомын төв дээр зохион явууллаа.

Арга хэмжээг нээж, дарга цагдаагийн хурандаа Т.Ганзориг ирээдүй хойч үе болсон хүүхэд багачууддаа хандан, баярын мэндчилгээ хүргэж, “Шинэ суваг” телевизийн “Хүүхдийн цаг” хөтөлбөрийн хүүхдүүд урлагийн хэсэгчилсэн тоглолт сонирхуулсан байна. Мөн хүрэлцэн ирсэн хүүхдүүдийг Цайллагын танхимд амттангаар дайлж, гарын бэлэг гардууллаа.

Арга хэмжээний үеэр хүүхэд, багачуудын дунд “Биднийг хамгаалах цагдаа” сэдвээр уран зураг, “Цагдаа миний бахархал” сэдвээр зохион бичлэг болон шүлгийн уралдаан тэмцээн зохион явагдаж, 1,2 дугаар байранд шалгарсан хүүхдүүдийг “Өргөмжлөл”, дурсгалын зүйлээр шагнаж урамшуулав. Мөн урлаг, спортоороо бусдыгаа манлайлж буй алба хаагчдын хүүхдүүдээс 3 хүүхэд Монголын хүүхдийн ордны “Эрдэн алтан” медаль, 4 хүүхэд “Эрдэм мөнгөн” медалиар тус тус шагнагдсан байна.

Уралдаан тэмцээнд идэвхтэй хамрагдсан болон цахимаар шүлгээ уншиж ирүүлсэн хүүхэд багачууддаа талархал илэрхийлж, цаашдын сурлаганд нь өндөр амжилтыг хүсэн ерөөе.

“Хамтарсан баг-хяналт” хэсэгчилсэн арга хэмжээг зохион байгууллаа. Уг арга хэмжээний хүрээнд Хэрлэн сумын 11 багийн хамтарсан багтай хамтран гэр бүлийн хүчирхийллээр баривчлагдсан иргэдийн хаягаар очиж нөхцөл байдлын үнэлгээг хийж, дахин зөрчил гаргахгүй байх талаар зөвлөмж өгч ажилласан. Кейс нээж ажиллаагүй багийн ажлын албанд мэдэгдэл өгч биелэлтийг тооцож ажилласан. Гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх чиглэлээр гаргасан шторкийг томоохон зах, худалдааны төвийн дэлгэцээр гаргаж иргэдэд сурталчилж ажиллалаа. Мөн 4 төрлийн сэрэмжлүүлэг постерыг орон сууцны хорооллын орц, төмөр зам, дэлгүүрүүдэд байршуулах ажлыг зохион байгуулсан. “Лайф”, “Улз”, “Дорнын ундарга” зэрэг цэвэр усны ХХК-тай хамтран иргэдийн өргөнөөр хэрэглэдэг цэвэр усны саванд байршуулан иргэдэд сурталчиллаа.

Хүүхдийг бэлгийн хүчирхийлэл, аливаа эрсдэлээс урьдчилан сэргийлж, тэдний эрхийг хамгаалах, аюулгүй байдлыг хангахад хамтарсан багийн оролцоо, үүрэг, хариуцлагыг нэмэгдүүлэх зорилгоор “Хүүхдийн өмнө үүрэг хүлээгчдийн Улсын зөвлөгөөн”-ийг угтан “ХАМТАРСАН БАГААРАА ХАМГААЛТЯ, ХАМТДАА ХӨГЖЬЕ, СУРАЛЦАЯ” зөвлөгөөнийг өнөөдөр буюу 2022 оны 05 дугаар сарын 21-ний өдөр зохион байгууллаа.

Зөвлөгөөнд Дорнод аймгийн засаг даргын орлогч бөгөөд Хүүхдийн эрхийн хууль зүйн хорооны тэргүүн Ш.Ёл, Хэрлэн сумын засаг даргын орлогч

Б.Лхагвасүрэн, Хэрлэн сумын 11 багийн хамтарсан баг, хэсгийн байцаагч, 12 сумын хэсгийн төлөөлөгч, мөрдөгч, холбогдох газар, хэлтэс агентлагийн мэргэжилтнүүд оролцож, зөвлөгөөнийг нээж Цагдаагийн газрын дарга, цагдаагийн хурандаа Т.Ганзориг албан ёсоор нээж үг хэллээ.

Урилгаар Д.Ундраа хүрэлцэн ирж, зөвлөгөөнд оролцож буй хамтарсан багуудын хүүхдийн эрхийг хамгаалах, аюулгүй байдлыг хангах, аливаа эрсдлээс урьдчилан сэргийлэхэд хэрхэн ажиллах, хамтын ажиллагааны уялдаа холбооны ач холбогдолын талаар сургалт, мэдээлэл хийсэн байна.

Мөн зөвлөгөөний үйл ажиллагаанд Хөдөлмөр Нийгмийн Хамгааллын Сайд бөгөөд Хүүхдийн Төлөө Үндэсний Зөвлөлийн дэд тэргүүн А.Ариунзаяа цахимаар мэндчилгээ дэвшүүлж, ХНХЯ-ны зүгээс хэрэгжүүлж буй бодлого, шинээр батлагдсан журам, стандарт, хүүхэд хамгааллын зардлын санхүүжилт, хамтарсан багийн гишүүдийн урамшуулал, НАМС программ, эцэг эхийн зөвлөл, хүүхэд хамгааллын бодлогын хэрэгжилтийн талаар мэдээлэл хүргэлээ.

"ЗАМЫН ХӨДӨЛГӨӨНИЙ ЦАГААН ТОЛГОЙ-2022" ТЭМЦЭЭН ЗОХИОН БАЙГУУЛАГДЛАА.

Сургуулийн өмнөх насны хүүхэд, эцэг, эхчүүдэд замын хөдөлгөөнд оролцох, зөв дадал олгох, хэвшүүлэх, зам тээврийн осол зөрчлөөс урьдчилан сэргийлэх, хууль дүрмийн мэдлэг олгох аймгийн Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөл, Улаан загалмайн хороо, авто сургуулиудтай хамтран "Зөвийг хэвшүүлье" уриан дор "Замын хөдөлгөөний цагаан толгой-2022" тэмцээнийг зохион байгууллаа.

Тэмцээнд сургуулийн өмнөх боловсролын байгууллагын нийт 8 баг тамирчид оролцон, хурд хүч авахаалж самбаагаа сорин өрсөлдөж, шилдгүүдээ тодрууллаа.

"Тэргүүн байр"-нд 10 дугаар цэцэрлэг, "Дэд байр"-нд 2 дугаар цэцэрлэг, "Гутгаар байр"-нд 4 дүгээр цэцэрлэг, тэмцээний "Уран зохицуулагч"-аар 10 дугаар цэцэрлэгийн н.Уудам тус тус шалгарлаа.

Тэмцээнд оролцсон нийт цэцэрлэгийн багш, баг хамт олонд талархал илэрхийлье.

Цагдаагийн газрын мөрдөгч болон зөрчил шалгах эрх бүхий албан тушаалтан нарт гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх хуулийн хэрэгжилтийг хангах, иргэдийн эрүүл мэнд, амь нас эрсдэхээс урьдчилан сэргийлэх чиглэлээр "Гэр бүлийн хүчирхийллийн дуудлага, мэдээлэл болон зөрчил шалган шийдвэрлэхэд анхаарах асуудал", "Гэр бүлийн хүчирхийллийн хохирогчтой харилцах арга зүй" сэдэвт 2 сургалтыг 2 удаа орж 3ш гарын авлага бүхий өврийн дэвтэрийг бэлтгэн тараасан.

Цагдаагийн ерөнхий газрын Урьдчилан сэргийлэх хэлтэс, Гэр бүлийн хүчирхийлэл, хүүхдийн гэмт хэрэгтэй тэмцэх хэлтэс болон өөрсдийн бэлтгэсэн 9 шторк, постер, подкаст, видеог Дорнод цагдаагийн газрын фэйсбүүк болон олон хандагчтай 100-120 группт тухай бүр түгээлтийг хийж давхардсан тоогоор 897121 хүнд хүргэсэн.

Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн 1.1, 34.1, Монгол улсын Хөдөлмөр, Нийгмийн хамгааллын сайдын 2017 оны А/116 дугаар тушаалаар батлагдсан "Түр хамгаалах байрны үйлчилгээ үзүүлэх журам"-ын дагуу хүлээн авч, үйлчлүүлэгчид үзүүлэх суурь үйлчилгээ, үйлчлүүлэгчийг асран хамгаалах, үйлчлүүлэгчийг тайвшруулах, сэтгэл зүйн дэмжлэг, зөвлөгөө, эрүүл мэнд, аюулгүй байдлыг хангаж, холбон зуучлах болон гэр бүлд нь эргэн нэгтгэх үйлчилгээнүүдийг үзүүлэн ажиллалаа.

Е. ХҮҮХДИЙН ГЭМТ ХЭРГЭЭС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ ЧИГЛЭЛЭЭР: “Хүүхэд хамгаалал” ерөнхий арга хэмжээг аймгийн хэмжээнд зохион байгуулж эрсдэлт нөхцөлд байгаа, хараа хяналтгүй хүчирхийлэлд өртсөн хүүхдийг илрүүлэх чиглэлээр хариуцсан нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулдаг Нийтийн аж ахуйн харъяа усан сангийн 43 түгээгч ажилтан, дэлгүүрийн худалдагч 92 иргэн, хөрш айл-41 иргэн, байрны жижүүрээр ажилдаг 36 иргэдтэй уулзаж санал хүсэлтийг авч гэр бүлийн хүчирхийлэл, хүүхдийн эсрэг хүчирхийллийн шинжтэй үйлдлийн талаар холбогдох газарт буюу Цагдаагийн газарт дуудлага мэдээлэл өгч иргэний мэдээлэх үүргээ биелүүлэх талаар зөвлөмж өгч хамтран ажиллаж байна. Үүний үр дүнд эрсэлд нөхцөлд байгаа хараа хяналтгүй, хүчирхийлэл өртөж болзошгүй 13 хүүхдийг илрүүлж кейс нээж ажиллах талаар хариуцсан багийн хамтарсан багт шилжүүлэн, Гэр бүл хүүхэд залуучуудийн хөгжлийн газрын хүүхдийн улсын байцаагчид арга хэмжээ тооцуулахаар 5 эцэг, эх асран хамгаалагчийн кейсийг шилжүүлэн өгч ажилласан.

Цагдаагийн ерөнхий газрын Гэр бүлийн хүчирхийлэл, хүүхдийн эсрэг гэмт хэрэгтэй тэмцэх хэлтсээс насанд хүрээгүй хүнийн эсрэг бэлгийн хүчирхийллийн гэмт хэрэгтэй тэмцэх урьдчилан сэргийлэх “Сэрэмжлүүлье” нэгдсэн арга хэмжээний хүрээнд тус Цагдаагийн газраас бага насны хүүхдийг бэлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх зорилгоор бүтээсэн “УЛААН ГЭРЭЛ - УЛААН БӨМБӨГ” дууг Хэрлэн сумын сургуулийн өмнөх боловсролын хүүхэд багачуудад сурталчлах ажлыг зохион явуулж байна.

Арга хэмжээний хүрээнд Хэрлэн сумын 9 дүгээр цэцэрлэгийн хүүхдүүд “Найрамдал” парк дээр “УЛААН ГЭРЭЛ - УЛААН БӨМБӨГ” дууг дуулж, бусдад сурталчилсан байна.

Эцэг эх, сурган хүмүүжүүлэгч та бүхнийг цэцэрлэгийн насны хүүхэд багачууддаа уг дууг зааж өгч, арга хэмжээнд нэгдэхийг Дорнод аймаг дахь Цагдаагийн газраас уриалж байна.

Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлаас баталсан “Зам тээврийн гэмт хэрэг, осол, зөрчлөөс урьдчилан сэргийлэх 2021-2023” хэрэгжүүлэх дэд хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд “ЗӨВИЙГ ХЭВШҮҮЛЬЕ” уриан дор “Зам тээврийн осол, гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлыг эрчимжүүлье” сэдэвт хэлэлцүүлэгийг 2022 оны 05 дугаар сарын 12-ны өдөр “Гэр” кофе шопт зохион байгууллаа.

Хэлэлцүүлэгт Аймгийн Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх салбар зөвлөлийн нарийн бичгийн дарга Ц.Одчулуун, Хууль эрх зүйн хэлтсийн мэргэжилтэн Г.Мягмарсүрэн, Цагдаагийн газрын дарга, цагдаагийн хурандаа Т.Ганзориг, Замын цагдаагийн тасгийн алба хаагч нар болон Хэрлэн сумын зхиргаа удирдлагын хэлтсийн дарга Б.Энхбилэг, Прокурорын газрын хэрэг бүртгэх, мөрдөн байцаах ажиллагаанд хяналт тавих хууль цаазын зөвлөх С.Ариунаа, Авто тээврийн төвийн улсын байцаагч Э.Батхүү, “Иргэн таны төлөө” ТББ-ын захирал Алтанцэцэг, “Зөв нөлөөлөл” ТББ-ын захирал Н.Хаяндорж нар урилгаар оролцож, 13 сумын Засаг дарга, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зөвлөлийн дарга нар цахимаар бүрэн хамрагдлаа.

Энэ үеэр согтуугаар тээврийн хэрэгсэл жолоодох зөрчлийг таслан зогсоох, энэ төрлийн зам тээврийн ослыг бууруулах, түүнээс урьдчилан сэргийлэх ажилд инноваци нэвтрүүлэх, төрийн болон төрийн бус байгууллага, иргэдийн санал хүсэлт дээр тулгуурлан нөлөөллийн арга хэмжээг үе шаттай зохион байгуулах талаар хэлэлцүүлэг өрнүүлсэн байна.

Цагдаагийн газрын жижүүрийн шуурхай албаны 7058102 тусгай дугаарын утас болон хүүхэд хамгааллын 108 дугаарын утсанд иргэдээс удаа дараа гэр бүлийн

хүчирхийлэлийн талаар давтамжтай ирүүлсэн мэдээллийг тухайн нутаг дэвсгэрээр гаргаж Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэж болзошгүй этгээдүүдийн судалгааг гарган тухайн иргэдэд дахин зөрчил үйлдэхгүй байх урьдчилан сэргийлэх чиглэлээр 52 иргэнд эрх зүйн зөвлөгөө өгч дахин зөрчил үйлдэхгүй байх талаар баталгаа гаргуулан авч сургалт зохион байгуулан ажиллаж байна. Давтан зөрчил гаргасан иргэдийн гэрийн хаягаар эргүүлийн чиглэлд хамруулан 7 хоног бүрийн 2 өдөрт оройн цагаар гэрт нь очиж шалгуулан нэг бүрчилсэн хяналтыг тавин ажилласан.

Хүүхдийг бэлгийн хүчирхийлэл, аливаа эрсдэлээс урьдчилан сэргийлж, тэдний эрхийг хамгаалах, аюулгүй байдлыг хангахад эцэг, эх асран хамгаалагчийн үүрэг, хариуцлагыг нэмэгдүүлэх зорилгоор “СЭРЭМЖЛҮҮЛЬЕ” хэлэлцүүлэг, зөвлөгөөнийг 2022 оны 05 дугаар сарын 12-ны өдөр зохион байгууллаа.

- Цагдаагийн газар, Аймгийн Прокурорын газар, Хүүхдийн эрхийн хууль зүйн хороо, Гэр бүл хүүхэд залуучуудын хөгжлийн газар, Боловсрол шинжлэх ухааны газар, Эрүүл мэндийн газар, Зөв чигийн зөвлөхүүд, нийгэмд үйлчлэх төрийн бус байгууллага болон төрийн байгууллага, ЕБСургуулийн нийгмийн ажилтан, эцэг эхийн төлөөлөл зэрэг нийт 500 гаруй иргэд хамрагдав.

Зөвлөгөөнд:

-Цагдаагийн газрын ахлах мэргэжилтэн, цагдаагийн хошууч Г.Болортуяа “Насанд хүрээгүй хүүхдээс үйлдсэн гэмт хэргийн нөхцөл байдал, анхаарах асуудал”,

- Эрүүл мэндийн газрын мэргэжилтэн П.Баттуяа “Өсвөр үеийн хүүхдүүдийн өвчлөлийн нөхцөл байдал”,

-Аймгийн Гэр бүл хүүхэд залуучуудын хөгжлийн газрын дарга Э.Жавхлан “Бэлгийн хүчирхийлэлд өртсөн хүүхдийн эрхийн хэрэгжилт, хамгааллын үйлчилгээний нөхцөл байдал, тулгамдаж буй асуудал”,

-Аймгийн Боловсрол шинжлэх ухааны газрын мэргэжилтэн Байгалмаа “Боловсролын орчин дахь хүүхэд хамгаалал, тулгамдаж буй асуудал”,

- Зөв чигийн зөвлөхүүд, нийгэмд үйлчлэх төрийн бус байгууллагын тэргүүн хуульч Ч.Эрдэнэбат “ Насанд хүрээгүй хүнийг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх нь ”,

- Аймгийн Цагдаагийн газрын Мөрдөн байцаах тасгийн мөрдөгч, ахлах дэслэгч Б.Болорбат “ Бэлгийн хүчирхийллийн гэмт хэргийн өнөөгийн нөхцөл байдал”,

-Аймгийн прокурорын газрын хяналтын прокурор Ч.Мөнхзул “Насанд хүрээгүй хүнээс үйлдсэн гэмт хэргийн шийдвэрлэлт, анхаарах асуудал” зэрэг сэдвүүдээр тус тус илтгэл тавьсан юм.

Мөн эцэг эхийн төлөөллөөс 4 иргэний санал хүсэлтийг хүлээн авч, холбогдох албан тушаалтнууд хариулт өгч ажилласан байна.

Энэ үеэр Цагдаагийн газартай хамтран үр дүнтэй ажиллаж буй Дорнод аймгийн Гэр бүл хүүхэд залуучуудын хөгжлийн газар, Хэрлэн сумын 11 дүгээр багийн засаг дарга, Г.Оюунтуяа, Ерөнхий боловсролын 5 дугаар сургуулийн нийгмийн ажилтан Д.Ганчимэг нарт Цагдаагийн газрын “Талархал” гардууллаа.

Хэлэлцүүлгийн төгсгөлд Ерөнхий боловсролын 12 дугаар сургуулийн найрал дууны сурагчид “Хүүхэд бид бүхэн дуулж байна” ая дуу өргөж, “Уриалга” танилцуулснаар өндөрлөв.

Цагдаагийн байгууллагын судалгаа хяналтын сангийн “Хүүхдийн нэгдсэн бүртгэлд”-д 7 хүүхдийг илрүүлэн газ, цавуу хэрэглэдэг хүүхдийн санд оруулан эцэг эх асран хамгаалагч нарын хамтаар тогтмол хяналтыг тавин ажиллаж байна

Хүүхдийг гэмт хэрэг, зөрчил үйлдэхээс урьдчилан сэргийлэх чиглэлээр Хэрлэн сумын ерөнхий боловсролын 1, 2, 5, 8, 11, 12, Хан-Уул цогцолбор, Шинэ хөгжил сургууль, Шинэ зуун, Flower, Долоодой, Түгээмэл оюун сургуульд тус тус “School police” эргүүл ажилладаг эцэг эхчүүд үүрэг гүйцэтгэхэд мэргэжлийн удирдлагаар ханган замын цагдаагийн тасгийн алба хаагч нар өглөө хичээлд ирэх үеийн хөдөлгөөн зохицуулалтад үүрэг гүйцэтгэн ажиллаж байна. Өсвөрийн сэргийлэгч бүлгэм”, “School police” зэрэг бүлгүүдэд 215 иргэнийг мэргэжлийн удирдлагаар ханган ажилласан байна. Тус аймагт үйл ажиллагаа явуулдаг “Анна хоум” асрамжийн газарт байдаг 25 хүүхдэд гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр 3 удаа 2 цагийн сургалт зохион байгуулж, санал хүсэлтийг нь авч ажилласан. Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэж Шүүхийн шийдвэрээр баривчлагдсан этгээд гэр бүлийн хүчирхийллийн хор уршиг, хүчирхийллийг үл тэвчих, гэр бүлийн халуун дулаан уур амьсгал, хүүхдийг эерэг аргаар хүмүүжүүлэх зэрэг сэдвээр зан үйлд нөлөөлөх албадан сургалтыг тогтмол зохион байгуулан давхардсан тоогоор 78 иргэнийг хамруулаад байна. Мөн Хэрлэн сумын 2,3,4 дүгээр багийн 36 хэсгийн ахлагч нарт сургалтыг зохион байгуулж ажилласан.

Хэрлэн сумын ерөнхий боловсролын сургуулиуд, Хан-Уул цогцолбор, Шинэ хөгжил сургууль, Шинэ зуун, Flower, Долоодой, түгээмэл оюун сургуульд тус тус “School police” эргүүл ажиллуулж, эцэг эхчүүдийн үүрэг гүйцэтгэх үед мэргэжлийн удирдлагаар ханган замын цагдаагийн тасгийн алба хаагч нар өглөө хичээл ирэх үеийн хөдөлгөөн зохицуулалтад үүрэг гүйцэтгэн ажиллаж байна.

Тус сургуулийн нийгмийн ажилтан нарыг 7 хоног бүр мэргэжлийн удирдлагаар ханган ажиллаж, Хүүхэд хамгааллын 13 “Хамтарсан баг”-уудад 1 удаа зөвлөн туслах ажлыг зохион байгуулж, “Өсвөрийн сэргийлэгч бүлгэм”, “Хамтарсан баг”, “School police” зэрэг бүлгүүдэд 541 иргэнийг мэргэжлийн удирдлагаар ханган ажилласан байна

ГУРАВ. САХИЛГА ХАРИУЦЛАГА, СУРГАЛТ СУРТАЛЧИЛГАА, СОЁН ГЭГЭЭРҮҮЛЭХ, АВИЛГААС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ АЖЛЫН ТАЛААР

А. Алба хаагчдын сахилга хариуцлагыг дээшлүүлэх чиглэлээр зохион байгуулсан ажил, арга хэмжээ, түүний үр дүн.

Цагдаагийн газар нь Монгол улсын Засгийн газрын 2017 оны “Сахилга хариуцлага, дэг журмыг чангатгах тухай” 01 дүгээр албан даалгавар, Төрийн албаны сахилга дэг журам, ажлын хариуцлагыг чангатгах тухай 258 дугаар тогтоол, Цагдаагийн ерөнхий газрын дэд даргын 2018 оны 03 сарын 28-ны өдрийн 3/1781 дүгээр албан бичгээр ирүүлсэн “Сахилга хариуцлагыг дээшлүүлэх үүрэг, ажлын чиглэл”, чиглэлийг бие бүрэлдэхүүнд танилцуулж хэрэгжүүлж ажиллах төлөвлөгөө гарган биелэлт үр дүнг тооцож ажиллалаа. Цагдаагийн газрын даргын “Сахилга, ёс зүйг дээшлүүлэх тухай” албан даалгавар 1, албадын дарга нарын манлайллыг дээшлүүлэх, алба хаагчдын сахилга хариуцлагыг чангатгах, алба хаагчдын ажлын хариуцлага, сахилга ёс зүйг сайжруулах чиглэлээр бие бүрэлдэхүүнд 14 удаа үүрэг хүргүүлэн биелэлт, үр дүнг тооцон ажиллаж байна. Тус цагдаагийн газрын даргын 2021 оны А/43 дугаартай тушаалаар захиргааны удирдлагын тасгийн даргаар ахлуулан тасаг, албадын ахлахуудаас бүрдсэн “Сахилга ёс зүйн дэд зөвлөл”-ийг байгуулж, цагдаагийн газрын алба хаагчдын сахилга ёс зүйг дээшлүүлэх, бууруулах чиглэлээр 14 заалт бүхий төлөвлөгөөг хэрэгжүүлэн ажиллалаа.

“Сахилга ёс зүйн дэд зөвлөл”-өөс 7 хоног бүрийн “Даваа” гаригт сахилга, ёс зүйн чиглэлээр бие бүрэлдэхүүнд мэдээлэл хийж алба хаагчдаас гаргаж буй нийтлэг зөрчлийг бууруулах нөлөөллийн ажлуудыг тухай бүр зохион байгуулан ажиллаж байна.

Зөрчил дутагдал гаргасан алба хаагч бүрээс дахин давтан зөрчил гаргахгүй байх “Баталгаа” гаргуулан авч зөвлөгөөг хамт олны өмнө өгч, зөрчил дутагдал гаргаагүй алба хаагчдыг хамт олны өмнө сайшааж, Цагдаагийн газрын даргын “Талархал” гардуулан ажилласнаар алба хаагчдаас гаргах сахилга, дэг журмын зөрчлүүд буурсан эерэг хандлага гарч байгаа юм.

Тасаг албад дотроо 1 дүгээр улирлын “Сахилга ёс зүйн зөвлөгөөн”-ийг хийж, гаргасан санал хүсэлтээ хурлын тэмдэглэлийн хамт ирүүлснийг нэгтгэн цагдаагийн газрын нэгдсэн сахилга хариуцлагын зөвлөгөөнийг зохион байгуулж, үүрэг чиглэл өгч ажиллалаа.

Цагдаагийн газрын 2022 оны 01 дүгээр улирлын “Сахилга хариуцлагын зөвлөгөөн”-ийг сумдын цагдаагийн тасаг, хэсэг, хэсгийн төлөөлөгч, цагдаа нарыг

хамруулан онлайн цахим хэлбэрээр зохион байгуулж, алба хаагчдаас сахилга, ёс зүйн зөрчил дутагдалгүй ажиллах талаар баталгаа гаргуулан авч ажиллалаа.

Цагдаагийн газрын тасаг албадын дарга, ахлахууд нь газрын дотоод журмын дагуу “Ёс журам сахиулах эргүүл”-ийн үүргийг хуваарийн дагуу 24 цагаар гүйцэтгэж алба хаагчийн сахилга ёс зүй зөрчсөн, цагдаач жагсаалч байдал, албаны шуурхай бэлэн байдал хангаагүй зөрчлийг илрүүлэн Цагдаагийн газрын “Сахилга, ёс зүйн дэд зөвлөл”-д шилжүүлэн шийдвэрлүүлэн ажиллаж байна. Зөрчил заагдсан алба хаагчдын зөрчлийг засуулж, зөрчлийг дахин давтахгүй байх талаар баталгаа гаргуулан авч шийдвэрлэжээ.

“ОФИЦЕР БҮРЭЛДЭХҮҮНИЙ ЗӨВЛӨГӨӨН” ЗОХИОН БАЙГУУЛАГДЛАА

Цагдаагийн газрын 2022 оны сургалт, соён гэгээрүүлэх төлөвлөгөө, Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны журам /код 940/-д заасны дагуу “Ёс зүйгээ мөрдөж дүрмээ биелүүлье” аяны хүрээнд сахилга ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх зорилгоор “Офицер бүрэлдэхүүний зөвлөгөөн” 2022 оны 04 дүгээр сарын 13-ны өдөр зохион байгуулалаа. Сумдад үүрэг гүйцэтгэж байгаа тасаг, хэсгийн дарга, хэсгийн төлөөлөгч, экологийн байцаагч нар цахим хэлбэрээр оролцож, нийт 96 офицер алба хаагч нарыг хамруулсан юм.

Зөвлөгөөн Цагдаагийн газрын даргаар батлуулсан удирдамж, төлөвлөгөөний дагуу Цагдаагийн ерөнхий газрын хуулийн хэлтсийн ахлах мэргэжилтэн, цагдаагийн дэд хурандаа Ц.Лхамсүрэн “Цагдаагийн алба хаагчийн тодорхой ажиллагаа явуулах үндэслэл журам, анхаарах асуудал”, Хөрөнгийн үнэлгээний “Дамно” ХХК-ын захирал Ц.Түвшинцэнгэл “Мөрдөн шалгах ажилаагааны явцад хөрөнгийн үнэлгээ хийхэд анхаарах асуудал” сэдвээр цахим сургалт явуулалаа.

Мөн Хүний эрхийн үндэсний комиссын Дорнод аймаг дахь мэргэжилтэн н.Дугардорж “Хүний эрх ба жендер цагдаагийн алба хаагч хүний эрхийг хангах нь”, Аймгийн эрүүл мэндийн газрын сургагч эмч Н.Урангэрэл “Ажлын байрны стрессээс ангижрах арга зам”, аймгийн Хууль эрх зүйн хэлтсийн мэргэжилтэн Г.Мягмрасүрэн нь “Авилгатай тэмцэхэд анхаарах асуудал, ашиг сонирхлын зөрчлийн ойлголт”, тус сэтгэл зүйч цагдаагийн ахлах дэслэгч Ц.Оюундарь “Гэр бүлийн харилцаа”, нягтлан бодогч, цагдаагийн дэслэгч Д.Ганчимэг “Санхүүгийн сахилга бат” сэдвүүдээр алба хаагч нарт сургалт зохион байгуулсан байна.

Удирдамжын дагуу Зөвлөгөөний Дэд хэсэгт “Офицер бүрэлдэхүүн”-ний дунд “Монгол улсын эрүүгийн хууль, эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль, зөрчлийн тухай хуулиуд”-ыг нэг мөр хэрэглэх чиглэлээр 5 багт хуваан, кейс өгч, ажиллуулан хэлэцүүлэг зохион байгуулж ажилласан юм.

Мөн үеэр сахилга ёс зүйн зөрчил гаргасан 2 алба хаагчид “МЭДЭГДЭЛ”, сахилга ёс зүйн зөрчил гаргаагүй үлгэрлэн манлайлж ажилласан 4 алба хаагчид “ТАЛАРХАЛ” гардууллаа.

Аймгийн Хөгжимт драмын театрын дуучин СТА н.Түвшинсайхан ая дууны мэндчилгээ дэвшүүлэн ая дуу өргөснөөр зөвлөгөөн өндөрлөлөө.

Алба хаагчийн сахилга, ёс зүйг сайжруулах, өргөсөн тангарагтаа үнэнч байж, бусдын нэр төр, алдар хүндийг хүндэтгэж, шударга, зарчимч, ёс зүйтэй, шуурхай, мэргэшсэн үйл ажиллагааг хэвшүүлэх чиглэлээр Цагдаагийн ерөнхий газрын даргын

тушаалаар батлагдсан "ИТГЭЛЦЛИЙН ГЭРЭЭ"-г тасаг, хэсгийн дарга нартай Цагдаагийн газрын дарга, тасгийн дарга нар алба хаагч нартай байгуулах арга хэмжээг 01 дүгээр сард зохион байгуулж, алба хаагчдын 2022 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг батлан баталгаажуулав.

Цагдаагийн газрын удирдлагаас алба хаагчдын гаргасан зөрчлийн шинж байдалд тулгуурлан сургалтын хэлбэрүүдийг сонгон мэргэшүүлэх, дадлагажуулах, мэдлэг олгох, гоо зүй, соёлын хичээл сургалт, зөрчил гаргасан алба хаагчдаар бие бүрэлдэхүүнд алдаан дээрээсээ суралцах сургалтуудыг оруулж, тэдний гэр бүлийн гишүүн бүртэй уулзаж сэтгэлзүйн зөвлөгөө өгүүлж, зөрчил дутагдалгүй ажилласан алба хаагчдыг сайшаах, сайн чанаруудыг нь хамт олонд сурталчлах ажлыг зохион байгуулж ажилласнаар 2022 оны гэмт хэрэг, зөрчилд холбогдсон, сахилгын зөрчил гаргаж, арга хэмжээ авагдсан алба хаагч байхгүй байна.

Д. Авилгаас урьдчилан сэргийлэх чиглэлээр зохион байгуулсан ажил, арга хэмжээний талаар, түүний үр дүн:

Цагдаа, дотоодын цэргийн байгууллагын алба хаагчдыг авлигаас урьдчилан сэргийлэх, авлигын шалтгаан нөхцөлийг судлан тогтоох, болзошгүй үйлдлийг таслан зогсоох, урьдчилан сэргийлэх, иргэд олон нийт, төрийн бусад байгууллага руу чиглэсэн хяналт шалгалтын үйл ажиллагаа явуулж, авлигын индексийн түвшинг бууруулах зорилгоор салбар төлөвлөгөөг гарган хэрэгжилтийг ханган ажиллаа.

Тус цагдаагийн газрын угтах үйлчилгээнд ажиллах алба хаагч нарт цагдаагийн байгууллагын үйлчилгээг иргэдэд түргэн шуурхай чирэгдэлгүй хүргэх зорилгоор иргэдийг угтан авч өргөдөл, гомдлын хугацаа, шалгаж буй албан тушаалтны мэдээлэл, хууль зүйн зөвлөгөө өгч, уулзахаар ирсэн иргэдэд жижүүрийн цагдаа зааж өгч нэвтрүүлэх ажлыг зохион байгуулж хэвшсэн. Мөн <http://www.dornod.police.gov.mn/> цахим хуудсанд иргэдийг хүлээж авах хуваарийг байршуулсан.

Иргэдийн гаргасан өргөдөл, гомдлыг хүлээн авах ажил арга хэмжээнд Дэд бөгөөд эрүүгийн тасгийн дарга хяналт тавьж сар газрын даргад танилцуулан ажиллаж байна. Иргэдээс санал хүсэлт авах санал хүсэлтийн хайрцгийг хэлтсүүдэд байрлуулж газар, хэлтсийн даргаас өөр алба хаагч онгойлгох боломжгүй болгож, иргэдийн санал хүсэлтийг цаг алдалгүй түргэн шуурхай хүлээн авч шийдвэрлэж ажиллаж байна. 2022 оны эхний 3 сарын байдлаар байгууллагын албан ёсны цахим хуудсаар иргэнээс ирүүлсэн гомдол мэдээлэл бүртгэгдээгүй байна.

Цагдаагийн газарт шинээр томилогдсон 1, ахлагчаас офицерын бүрэлдэхүүнд орсон 1, ахлах албан тушаалд 1, ажлын байр өөрчлөгдсөн 16 нийт 19 алба хаагчийн асуудлыг шийдвэрлэн ажил үүргээ хэвийн гүйцэтгэж байна. Ковидын үеийн төрийн албаны томилгоог /шагнал урамшууллыг зөвхөн байгууллагын хэмжээнд/ судлан, шалгаж хуульд заасан шаардлага хангаагүй албан тушаалын томилгоо байхгүй болно. Алба хаагчдыг судлах, томилох, албан тушаал дэвшүүлэх ажлыг Төрийн албаны тухай хууль болон холбогдох хууль тогтоомж, журмын дагуу зохион байгуулж, төрийн албаны мерит зарчмыг баримтлан ажиллаж байна. 2022 оны 01 дүгээр сарын 06-ны өдөр Төрийн албанаас зөвлөлөөс зохион байгуулж буй "Төрийн албан хаагчийн ёс зүй, харилцаа, хандлагын өөрчлөлт, бүтээмжийг дэмжих" 2022 оны 01 дүгээр сарын 31-ний өдөр "Хөрөнгө оруулга, ашиг сонирхлын мэдүүлэг", 2022 оны 02 дугаар сарын 17-ны өдөр "Хөрөнгө оруулга, ашиг сонирхлын мэдүүлэг", зэрэг 5 удаагийн цахим сургалтад амжилттай хамрагдсан.

Цагдаагийн газрын алба хаагчдаас Гомдол, мэдээлэлийг хянан шалгаж, шийдвэрлэх, хууль сахиулах үйл ажиллагаанд хөндлөнгөөс нөлөөлөх гэсэн оролдлого гарсан тохиолдолд авлигаас татгалзах талаар эрх бүхий 191 алба хаагчаас баталгаа авсан. "Авлигаас урьдчилан сэргийлэх цагдаагийн байгууллагын үйл ажиллагаа" /код-139/-ын 139.61 "в" маягтын дагуу тэмдэглэл хөтөлж, мэдээлсэн тохиолдолд тасгийн дарга, ахлах нараас байгууллагын даргад мэдэгдэж урамшуулах талаар алба хаагчдад мэдэгдэж, үйл ажиллагаанд нь хяналт тавьж ажиллаж байна.

Тайлангийн хугацаанд цагдаагийн газрын алба хаагч нараас авилга ашиг сонирхлын зөрчил дутагдал гаргасан алба хаагч байхгүй байна. Хөтөлбөрийн дагуу "Авилгад өртөж болзошгүй эрсдэлтэй албан тушаал, түүнд ажиллаж байгаа алба хаагчид, тэдгээрт хяналт тавих албан тушаалтны судалгаа", "Авилгад өртөж болзошгүй алба хаагчдын судалгаа"-зэргийг гарган хяналт тавин ажиллаа УИХ-ын Хууль зүйн байнгын

хорооны 2014 оны 20 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан “Хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө, орлогын мэдүүлэг гаргах албан тушаалтны жагсаалт”-ын дагуу тус Цагдаагийн газраас хувийн ашиг сонирхлын мэдүүлэг гаргах эрх бүхий 95 алба хаагч мэдүүлгээ өөрийн биеэр, тогтоосон хугацаанд бүрэн гаргуулан авч хуулийн хугацаанд баталгаажуулан ажиллалаа.

Хувийн ашиг сонирхлын болон хөрөнгө, орлогын мэдүүлгийг хүлээн авсан, хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлэг, тайлбар, мэдэгдэл, мэдээлэл тэдгээрийн шийдвэрлэлт, хөрөнгө орлогын их хэмжээний өөрчлөлтийн бүртгэлийг маягтын дагуу бүрэн хөтөлж 2022 оны эхний 1 дүгээр улиралд 3 алба хаагч хөрөнгө орлогын мэдүүлэг шинээр мэдүүлж, санд шивж баталгаажууллаа.

Хөтөлбөрийн дагуу “Авилгад өртөж болзошгүй эрсдэлтэй албан тушаал, түүнд ажиллаж байгаа алба хаагчид, тэдгээрт хяналт тавих албан тушаалтны судалгаа”, “Авилгад өртөж болзошгүй алба хаагчдын судалгаа”-зэргийг гарган хяналт тавин ажиллаа. Авилгаас урьдчилан сэргийлэх ажлыг байгууллага, нийт бие бүрэлдэхүүний үйл хэрэг болгон алба хаагчтай байгуулсан үр дүнгийн гэрээнд заалт оруулж, авилгад өртөхгүй байх, удирдах албан тушаалтнуудын үлгэрлэл манлайлалтай ажиллаж, алба хаагч нарт тавих дотоодын хяналт, зарчимч шаардлагыг өндөржүүлэн ажилласнаас гадна авилгын хор уршиг, ашиг сонирхлыг зөрчил, түүнээс ангид байхыг уриалж хамт олноороо авилгыг тэвчиж ажиллахыг санал болгон гарын үсэг зуруулан авилгад өртөхгүй байх баталгааг гаргуулж ажиллаж байна.

Иргэд, аж ахуйн нэгж, байгууллагаас ирүүлсэн гэмт хэрэг, зөрчлийн дуудлага мэдээллийн мөрөөр Цагдаагийн газрын жижүүрийн шуурхай бүрэлдэхүүн дуудлагад очсон хугацаа, ажлын үр дүн, харьцааны соёл, хэрхэн шийдвэрлэсэн талаар тухай өдрийн Ёс журмын эргүүл дуудлага өгсөн иргэн бүртэй утсаар холбогдон санал хүсэлтийг сонсож, дуудлага мэдээлэл шалгалгүй дарагдуулсан, гомдолтой дуудлага мэдээллийг дахин шалгуулахаар хоногийн мэдээнд тусган иргэдийг санал хүсэлтийг сонсож ажилласнаар иргэдийг чирэгдүүлэх, дуудлага мэдээлэл дарагдуулах зөрчил дутагдал буурч байгаа нь зохих үр дүнгээ өгч байна.

A/ Зохион байгуулсан соён гэгээрүүлэх ажил, арга хэмжээ

Тус Цагдаагийн газраас Цагдаагийн ерөнхий газрын даргын 2022 оны А/02 дугаар тушаалаар батлагдсан “Соён гэгээрүүлэх ажлын төлөвлөгөө”, Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны “Соёл, соён гэгээрүүлэх ажил” /код 940/ журам, Цагдаагийн газрын 2021 оны соён гэгээрүүлэх ажлын төлөвлөгөөний хэрэгжилтийг хангах чиглэлээр дараах ажил, арга хэмжээг зохион байгуулж ажиллалаа. **Биеийн тамир, спорын тухай хууль, “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны бодлого, Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд биеийн тамирыг бүх нийтийн хөдөлгөөн болгож, иргэдийн дасгал хөдөлгөөн хийх эрчмийг нэмэгдүүлж, зөв дадлыг бий болгохоор Монгол Улсын Ерөнхий сайдын санаачилсан “Илүүдэл жингүй-Эртэч Монгол” аяны арга хэмжээ Дорнод аймгийн хэмжээнд энэ оны хоёрдугаар сарын 16-наас зургаадугаар сарын 1-ний өдөр хүртэл хугацаанд амжилттай зохион явагдаж өндөрлөлөө.**

Тус аяны хаалтын үйл ажиллагааг Тусгаар тогтнолын талбай дээр 2022 оны 05 сарын 28-ны өдөр зохион байгуулж, шилдэг байгууллага хамт олноор цагдаагийн хурандаа Т.Ганзориг даргатай Цагдаагийн газрын хамт олон шалгарч батламж гардан авлаа.

Аяныг дэмжин эртэч иргэн, эртэч нийгмийг бүрдүүлэхэд идэвх санаачилгатай оролцсон хамт олондоо ажлын өндөр амжилтыг хүсэн ерөөе.

Монгол Улсны ерөнхийлөгч У.Хүрэлсүхийн санаачилгаар улсын хэмжээнд зохион явуулж буй “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөний хүрээнд тус Цагдаагийн газраас гадна талбайд 1000 гаруй суулгац тарьж хэмжээний зурган танилцуулга

Дорнод аймгийн аварга шалгаруулах 2022 оны “Классик пауэрлифтинг” буюу хүчний 3 төрөлт тэмцээн 2022 оны 05 дугаар сарын 27-ны өдөр зохион байгуулагдаж, тус Цагдаагийн газрын баг тамирчид амжилт гарган оролцлоо.

- Классик пауэрлифтингийн -83кг жинд тус Цагдаагийн газрын эдийн засгийн мөрдөгч, ахлах дэслэгч Б.Энхтөр “Суулт”-ын төрөлд мөнгөн медаль, “Нуруу таталт”-ын төрөлд мөнгөн медаль, “Цээж шахалт”-ын төрөлд мөнгөн медаль,
- 74кг жинд Дотоодын цэргийн тусгай салбарын харуулчин, ахлах ахлагч н.Шинэцогт “Цээж шахалт”-ын төрөлд мөнгөн медаль,
- 93кг жинд эрүүгийн мөрдөгч, цагдаагийн ахлах дэслэгч Д.Алтангэрэл “Цээж шахалт”-ын төрөлд хүрэл медаль тус тус хүртсэн байна.

Амжилт гарган оролцсон алба хаагч нартаа спортын өндөр амжилтыг хүсэн ерөөе.

ҮНДЭСНИЙ БӨХИЙН БАРИЛДААНД ЦАГДААГИЙН ГАЗРЫН АЛБА ХААГЧ ТҮРҮҮ БӨХӨӨР ТОДОРЛОО

Монгол Улсад орчин цагийн зэвсэгт хүчин үүсэн байгуулагдсаны 101 жилийн ой, “Монгол цэргийн өдөр”-ийг угтаж, Дорнод аймгийн үндэсний аюулгүй байдлыг хангах, тусгайлсан чиг үүрэг бүхий байгууллагуудын дунд зохион байгуулагдсан “Үндэсний бөхийн барилдаан”-д Цагдаагийн газраас 10 бөх оролцон, Дотоодын цэргийн тусгай салбарын харуулчин, дэд ахагч У.Сумъяабазар түрүүлж, “Өргөмжөл”, алтан медалиар шагнууллаа.

Амжилт гарган оролцсон хүчит бөхчүүддээ баяр хүргэж, цаашдын ажил хөдөлмөр, спортын их гараанд амжилт хүсэж, улс, аймгийн цолтой болохыг ерөөе.

ШАТРЫН ТЭМЦЭЭНД ЦАГДААГИЙН ЭМЭГТЭЙ АЛБА ХААГЧ “ДЭД БАЙР”-НД ШАЛГАРЛАА

Монгол Улсад орчин цагийн зэвсэгт хүчин үүсэн байгуулагдсаны 101 жилийн ой, “Монгол цэргийн өдөр”-ийг угтаж, Дорнод аймгийн үндэсний аюулгүй байдлыг хангах, тусгайлсан чиг үүрэг бүхий байгууллагуудын дунд зохион байгуулсан “Шатрын тэмцээн”-нд Цагдаагийн газрын баг тамирчид амжилттай оролцон, нягтлан бодогч, цагдаагийн дэслэгч Г.Ганчимэг “Дэд байр”-нд шалгарч, “Өргөмжөл”, мөнгөн шагналаар шагнууллаа.

Амжилт гарган оролцсон алба хаагч нартаа спортын өндөр амжилтыг хүсэн ерөөе.

ХАЙРЛАН ДУУЛАХ ЭХ ОРОН” УРЛАГЫН ТЭМЦЭЭНД “ДЭД БАЙР”-НД ШАЛГАРЛАА

Монгол Улсад орчин цагийн зэвсэгт хүчин үүсэн байгуулагдсаны 101 жилийн ой, “Монгол цэргийн өдөр”-ийг угтаж, Монгол цэргийн дайчин замнал, Батлан хамгаалах салбар Зэвсэгт хүчний бодлого зорилт үйл ажиллагааг хүүхэд залуучуудад сурталчлах, таниулах ирээдүй хойч үедээ эх оронч үзэл, хүмүүжлийг төлөвшүүлэх зорилгоор үндэсний аюулгүй байдлыг хангах, тусгайлсан чиг үүрэг бүхий байгууллагуудын дунд зохион байгуулагдсан “Хайрлан дуулах эх орон” сэдэвт тэмцээн 2022 оны 03 дугаар сарын 15-ны өдөр зохион байгуулагдлаа.

Тэмцээнд багийн мэндчилгээ, дуэт дуу, хамтлаг бүжиг, шүлэг гэсэн төрлөөр зохион байгуулагдаж, 6-8 хүний бүрэлдэхүүнтэй 7 баг өрсөлдөж, Цагдаагийн

газрын “Шонхорууд” баг “Дэд байр”-нд шалгарч, “Өргөмжлөл” мөнгөн шагналаар шагнууллаа.

Тэмцээнд оролцож амжилт гаргасан шонхорууддаа баяр хүргэн, цаашдын ажил хөдөлмөрт амжилт хүсэн ерөөе.

Хэрлэн сумын Засаг дарга бөгөөд Чойбалсан хотын захирагч О.Пүрэв-Очир болон Дорнод аймаг дахь нар Хамтын ажиллагааны үр дүнгээр тэргүүлсэн 7 ба 10 дугаар багийн ажлын албадад Цагдаагийн газрын даргын Талархлыг гардуулав.

Цагдаагийн газрын даргын тушаалын хавсралтаар 2021 онд зохион байгуулах “Тэмдэглэлт баяр, ёслолын арга хэмжээ”, “Биеийн тамир спортын уралдаан тэмцээн”, “Ёслол хүндэтгэлийн арга хэмжээ”-ний хуваарь, төлөвлөгөөг хэрэгжүүлэн ажиллаж байна.

Тус цагдаагийн газраас “Дорнод бүсийн эрчим хүчний эрчим хүчний салбар” ТӨХК-тай 2022 онд хамтран ажиллах гэрээгээ шинэчлэн байгуулж, алба хаагчдын бие бялдар, хөдөлгөөний дутагдлаас урьдчилан сэргийлэх чиглэлээр спорт зааланд хичээл сургалт, дасгал хөдөлгөөнийг долоо хоногийн “Пүрэв” гаригт тогтмол хийж ажиллаж байна.

Тайлангийн хугацаанд алба хаагчдын дунд цагдаагийн газрын аварга шалгаруулах “Волейбол”, “Марш тактик”, “Мэргэн буудагч”, “Ширээний теннис”, “Хүчний 3 төрөлт” тэмцээнүүдийг зохион байгуулан алба хаагчдын бүрэн хамруулж ажиллалаа.

Ц ЧОЙБАЛСАН ЦЭРГИЙН ХҮРЭЭНИЙ МАРШ ТАКТИК, ТУСГАЙ БЭЛТГЭЛ ” ТЭМЦЭЭНД ЦАГДААГИЙН ГАЗРЫН АЛБА ХААГЧИД АМЖИЛТТАЙ ОРОЛЦЛОО

Монгол Улсад Дотоодын цэрэг үүсэн байгуулагдсаны 100 жил, зэвсэгт хүчний 101 жилийн ой, “Монгол цэргийн өдөр”-т зориулж, Дорнод аймгийн Үндэсний аюулгүй байдлыг хангах, тусгайлсан чиг үүрэг бүхий болон төрийн байгууллагуудын дунд зохион байгуулсан “Марш тактик, тусгай бэлтгэл”-ийн тэмцээнд Цагдаагийн газрын баг амжилт гарган оролцлоо.

Амжилт гарган оролцсон алба хаагч нартаа цаашдын ажил хөдөлмөр, спорын өндөр амжилтыг хүсэн ерөөе.

“МЭРГЭН БУУДАГЧ” ТЭМЦЭЭНД ЦАГДААГИЙН ГАЗРЫН АЛБА ХААГЧИД ХҮРЭЛ МЕДАЛЬ ХҮРТЛЭЭ

Монгол Улсад Дотоодын цэрэг үүсэн байгуулагдсаны 100 жил, зэвсэгт хүчний 101 жилийн ой, “Монгол цэргийн өдөр”-т зориулж, Дорнод аймгийн Үндэсний аюулгүй байдлыг хангах, тусгайлсан чиг үүрэг бүхий болон төрийн байгууллагуудын дунд зохион байгуулсан “Мэргэн буудагч”-ийн тэмцээнд Цагдаагийн газрын баг амжилт гарган оролцож, ПМ гар бууны төрөлд Захиргааны удирдлагын тасгийн дарга, цагдаагийн дэд хурандаа Б.Батжаргал “Тэргүүн байр”-т шалгарч, алтан медаль, багийн амжилтаар “Гутгаар байр-т шалгарч, хүрэл медалиар шагнуулсан байна.

Амжилт гарган оролцсон алба хаагч нартаа цаашдын ажил хөдөлмөр, спорын өндөр амжилтыг хүсэн ерөөе.

“САГСАН БӨМБӨГИЙН ТЭМЦЭЭН”-НД ЭРЭГТЭЙ БАГ ТАМИРЧИД ТҮРҮҮЛЛЭЭ.

Монгол Улсад Дотоодын цэрэг үүсэн байгуулагдсаны 100 жил, зэвсэгт хүчний 101 жилийн ой, “Монгол цэргийн өдөр”-т зориулж, Дорнод аймгийн Үндэсний аюулгүй байдлыг хангах, тусгайлсан чиг үүрэг бүхий болон төрийн байгууллагуудын дунд зохион байгуулсан “Сагсан бөмбөгийн тэмцээн”-нд Цагдаагийн газрын баг “Тэргүүн байр”-нд шалгарч, алтан медаль гардан авлаа.

Мөн “Шилдэг эрэгтэй довтлогч”-оор мэдээлэл хүлээн авагч, цагдаагийн дэд ахлагч Б.Сүххуяг шалгарч, шагнуулсан байна.

Амжилт гарган оролцсон хамт олондоо спортын өндөр амжилт хүсэе.

“МОНГОЛ ЦЭРГИЙН ӨДӨР”-Т ЗОРИУЛСАН “ОЛС ТАТАЛТЫН ТЭМЦЭЭН”-ИЙГ ЗОХИОН БАЙГУУЛЛАА

Монгол Улсад Дотоодын цэрэг үүсэн байгуулагдсаны 100 жил, зэвсэгт хүчний 101 жилийн ой, “Монгол цэргийн өдөр”-т зориулж, тус Цагдаагийн газраас Үндэсний аюулгүй байдлыг хангах, тусгайлсан чиг үүрэг бүхий болон төрийн байгууллагуудын дунд “Олс таталт”-ийн тэмцээнийг зохион байгууллаа.

Тэмцээнд 11 байгууллага оролцож, хурд хүч, авхаалж самбаагаа сорьсноос “Тэргүүн байр”-нд Зэвсэгт хүчний 327 дугаар анги, “Дэд байр”-нд Зүүн бүсийн төв-Онцгой байдлын газар, “Гутгаар байр”-нд Цагдаагийн газрын баг тамирчид шалгарч, “Өргөмжлөл”, медаль, мөнгөн шагналаар шагнагдлаа.

Тэмцээнд оролцож буй тамирчид, хөгжөөн дэмжигч нарт зориулан Аймгийн Хөгжимт драмын театрын дуучин н.Түвшинсайхан болон цагдаагийн газрын алба хаагчид ая дууны мэндчилгээ дэвшүүлэн, хамгийн идэвхтэй хамт олноо дэмжиж, сахилга баттай оролцсон дэд хурандаа Ганбаатар захирагчтай Хилийн цэргийн 0306 дугаар ангийн хамт олныг урамшуулан “Өргөмжлөл”, мөнгөн шагнал гардуулан өгсөн байна.

Нийт оролцсон баг тамирчид болон хамтран ажилласан “Голомт” банк, Аймгийн Биеийн тамир спортын газрын хамт олонд цаашдын ажил хөдөлмөр, спортын өндөр амжилтыг хүсэн ерөөе.

“ДАРТС”-ЫН ТЭМЦЭЭНД БАГ ТАМИРЧИД ХҮРЭЛ МЕДАЛЬ ХҮРТЛЭЭ

Монгол Улсад Дотоодын цэрэг үүсэн байгуулагдсаны 100 жил, зэвсэгт хүчний 101 жилийн ой, “Монгол цэргийн өдөр”-т зориулж, Дорнод аймгийн Үндэсний аюулгүй байдлыг хангах, тусгайлсан чиг үүрэг бүхий болон төрийн байгууллагуудын дунд зохион байгуулсан “Дартсын тэмцээн”-нд Цагдаагийн газрын баг тамирчид болох цагдаагийн ахлах дэслэгч Ц.Оюундарь, цагдаагийн дэд ахлагч А.Дэлгэрбат нар “Гутгаар байр”-нд шалгарч, “Өргөмжлөл”, хүрэл медаль хүртлээ.

Амжилт гарган оролцсон алба хаагч нартаа спортын өндөр амжилт хүсэе.

“МОНГОЛ ЦЭРГИЙН ӨДӨР”-Т ЗОРИУЛСАН УРЛАГ, СПОРТЫН ТЭМЦЭЭНИЙ НЭЭЛТИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА БОЛЛОО

Монгол Улсад орчин цагийн зэвсэгт хүчин үүсэн байгуулагдсаны 101 жилийн ой, “Монгол цэргийн өдөр”-ийг угтаж, Үндэсний аюулгүй байдлыг хангах, тусгайлсан чиг үүрэг бүхий байгууллагууд болон төрийн байгууллагуудын дунд зохион байгуулагдах урлаг, спортын тэмцээний нээлтийн үйл ажиллагаа 2022 оны 03 дугаар сарын 10-ны өдөр боллоо.

Тэмцээн, уралдаан хуваарийн дагуу Волейболын тэмцээнээр эхэлж, Чойбалсан цэргийн хүрээний марш тактик, тусгай бэлтгэл, Сагсан бөмбөг, Дартс, Олс таталт, Ширээний теннис, Шагайн харваа, Шатрын тэмцээн, Үндэсний бөхийн барилдаан,

“Хайрлан дуулах-Эх орон” урлагийн тэмцээн зэрэг төрлүүдээр 8 өдрийн турш үргэлжлэхээр төлөвлөгдсөн байна.

Тэмцээнд оролцож буй Цагдаагийн газрын баг тамирчдад амжилт хүсэн ерөөе.

“МОНГОЛ ЦЭРГИЙН ӨДӨР”-Т ЗОРИУЛСАН “ВОЛЕЙБОЛЫН ТЭМЦЭЭН”-НД ЭРЭГТЭЙ БАГ ТАМИРЧИД ТҮРҮҮЛЛЭЭ.

Монгол Улсад орчин цагийн зэвсэгт хүчин үүсэн байгуулагдсаны 101 жилийн ой, “Монгол цэргийн өдөр”-ийг тохиолдуулан, Үндэсний аюулгүй байдлыг хангах, тусгайлсан чиг үүрэг бүхий байгууллагууд болон төрийн байгууллагуудын дунд зохион явагдсан “Волейболын тэмцээн”-нд Цагдаагийн газрын эрэгтэй баг тамирчид “Тэргүүн байр”-нд шалгарч, алтан медалийн эзэд боллоо.

Баг тамирчдадаа баяр хүргэн, цаашдын ажил хөдөлмөр, спортын их үйлсэд нь улам их амжилтыг хүсэн ерөөе.

агдаа, дотоодын цэргийн байгууллагаас 2022 онд дэвшүүлсэн зорилтыг хэрэгжүүлэх, алба хаагч, ажилтанд хорт зуршлаас татгалзах, багасгах сэдэл төрүүлэх эрүүл зөв, амьдралын хэвшил, ёс зүй зан үйлийг төлөвшүүлэх, алба хаагчдын бие бялдрыг чийрэгжүүлэх, нийтийн биеийн тамир, спортыг дэмжих чиглэлээр алба хаагчдын идэвх, оролцоог нэмэгдүүлэх зорилгоор Монгол Улсын Ерөнхий сайдын санаачилсан “Илүүдэл жингүй-Эртэч Монгол” аянд цагдаа, дотоодын цэргийн алба хаагчид нэгдлээ. Цагдаагийн газрын “Биеийн тамир спортын хамтлаг”-аас 7 хоног бүрийн Пүрэв гаригт алба хаагчдыг 06.30-07.30 минутын хооронд спорт зааланд биеийн тамир, дасгал хөдөлгөөнд хамруулж байна.

Алба хаагчдын ажиллах урам зоригийг сэргээх, урлаг гоо зүйн соёлыг төлөвшүүлэх зорилгоор ажил, мэргэжлээрээ бусдыгаа манлайлан ажилласан 21 алба хаагчдыг Дорнод хөгжимт Драмын театрын шинэ уран бүтээл “Нүдтэй наран тамга” хөгжимт драмын жүжгийг үзэж сонирхуулсан.

Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны журам “Соён гэгээрүүлэх ажил /код 940/ журам”, хэрэгжилтийг хангах, алба хаагчдын ном ашиглалтыг сайжруулах, чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэх, номыг бүтээлчээр уншиж оюуны чадамж, бичгийн ур чадварыг нэмэгдүүлэх, сэтгэлгээ хандлагыг өөрчлөх зорилгоор “Утастай биш номтой нөхөрлөө” аяныг зохион байгуулан уншиж судалсан номын талаар тэмдэглэл хөтлөн, бие бүрэлдэхүүнд уншсан номын түүврийг танилцуулж ажилласан.

Тус арга хэмжээний хүрээнд аймгийн төв номын сантай 2022 онд хамтран ажиллах гэрээг шинэчлэн байгуулж хамгийн олон ном уншсан алба хаагч, арга хэмжээний хүрээнд идэвх санаачилгатай ажилласан алба хаагчдыг шалгаруулан шагнаж урамшуулсан.

БАХАРХАЛТ ТАМИРЧИД” ӨДӨРЛӨГИЙН АРГА ХЭМЖЭЭ ЗОХИОН БАЙГУУЛАГДЛАА.

Тус Цагдаагийн газраас Дотоодын цэргийн түүхт 100 жилийн ойг угтсан ажил, Цагдаа, дотоодын цэргийн удирдах ажилтны 2022 оны сургалт зөвлөгөөний үеэр Цагдаагийн ерөнхий газрын дэд даргаас өгсөн үүрэг чиглэлийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд Цагдаагийн ерөнхий газрын даргын 2022 оны А/112 тушаалаар батлагдсан “ХОРТ ЗУРШЛААС ТАТГАЛЗАЖ-САЙНААР ҮЛГЭРЛЭЭ” нөлөөллийн аянг нээж, Цагдаагийн газрын алба хаагчдын дунд нийтийн биеийн тамир, спортыг хөгжүүлэх, тамирчин алба хаагчдын алдрыг таниулан сурталчлах зорилгоор “БИДНИЙ БАХАРХАЛТ ТАМИРЧИД” сэдэвт спортын цол, зэрэгтэй алба хаагчдыг алдаршуулах өдөрлөгийн арга хэмжээг 2022 оны 04 дүгээр сарын 29-ний өдөр зохион байгууллаа.

- Арга хэмжээг МҮОНРТВ-ийн MNB sport сувгийн продюсер Д.Батжаргал урилгаар хөтөлж, спортын цол зэрэгтэй алба хаагчдын амжилтыг танилцуулж, алдаршууллаа.

- Өдөрлөгийн арга хэмжээ удирдамж, хөтөлбөрийн дагуу алба хаагчдын спортын амьдрал, түүхэн замналын харуулсан сурвалжлага, нэвтрүүлгийг бэлтгэн, нийт бие бүрэлдэхүүнд сонирхуулж, Монгол Улсын гавъяат жүжигчин Т.Ганзоригт ая дууны мэндчилгээ дэвшүүлсэн юм.

- Мөн үеэр Цагдаагийн газрын хамт олон, алба хаагчдын гавъяа шагналыг иргэд, олон нийтэд сурталчилах зорилготой “Алдарын булан”-ийн нээлт, тууз хайчлах арга хэмжээ зохион байгуулалаа.

- Арга хэмжээний төгсгөлд Цагдаагийн газрын даргаас хамт олноо төлөөлөн спортын тэмцээн, уралдаанд амжилттай оролцож ирсэн алба хаагч, тамирчиддаа “ТАЛАРХАЛ” гардуулан өгч, мөнгөн шагналаар урамшуулсан юм.

- Спортын шилдэг хамт олондоо болон баг тамирчиддаа цаашдын ажил хөдөлмөрт нь өндөр амжилт хүсэе.

“Асралт үйлс” өрхийн эмнэлгийн их эмч Н.Энхмаагаар эрүүл зөв хооллолтын талаар 1 цагийн сургалтыг зохион байгуулж сургалтын материалыг алба хаагч нарыг бүрэн хамруулах зорилгоор “domod tsagdaa surgalt” хаалттай фейсбүүк хаалттай хуудсанд байршуулж ажиллалаа.

Мэдээлэл, сурталчилгааны ажлын хүрээнд: Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны “Соёл, соён гэгээрүүлэх ажил /код 940/” журам, Цагдаагийн газрын 2022 оны соён гэгээрүүлэх ажлын төлөвлөгөөнд тусгагдсан дагуу Цагдаагийн газрын алба хаагчдад ЦЕГ, харъяа албад болон аймаг, сумын төр захиргааны байгууллагаас ирүүлсэн бодлого шийдвэр, хууль тогтоомж, үүрэг ажлын чиглэл, үйл ажиллагаатай холбоотой шийдвэрүүдийг Захиргааны удирдлагын тасгийн дарга тухай бүрт нь танилцуулж мэдээллээр ханган ажиллалаа.

Эхний 1 дүгээр улирлын байдлаар мэдээлэл сурталчилгааны ажлын хүрээнд 48 удаа 7650 алба хаагчдад мэдээлэл хийж, 31 удаа бичиг баримт, шийдвэрийг нийт давхардсан тоогоор 4942 алба хаагчдад танхимаар болон цахимаар мэдээлэл хийж танилцуулав.

Цагдаагийн газрын алба хаагч нарын илтгэх ур чадварыг сайжруулах, харилцааны соёлыг дээшлүүлэх, улс орны болон гадаад орон, аймаг орны онцлог үйл явдал, дотоодод зохион байгуулагдсан ажил, арга хэмжээний “ДОЛОО ХОНОГИЙН СУРВАЛЖЛАГА” мэдээг цагдаагийн газрын эмэгтэй алба хаагчдаас бэлтгэн 7 хоног бүрийн “Даваа” гарагт нийт 10 удаа давхардсан тоогоор 1953 алба хаагчдад, “Долоо хоногийн криминологи судалгаа”-ны танилцуулгыг ахлахуудаас 10 удаа 1953 алба хаагчдад танилцуулан ажилласан байна.

Цагдаагийн газраас Монгол улсын Засгийн газрын 2017 оны “Сахилга хариуцлага, дэг журмыг чангатгах тухай” 01 дүгээр албан даалгавар, Төрийн албаны сахилга дэг журам, ажлын хариуцлагыг чангатгах тухай 258 дугаар тогтоолыг иргэдийн хүлээлгийн танхимд байршуулж, хэрэгжүүлэх чиглэлээр төлөвлөгөө гарган биелэлт үр дүнг тооцож ажиллалаа.

Цагдаагийн газрын даргын “Сахилга, ёс зүйг дээшлүүлэх тухай”, “Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай”, “Хүрээлэн байгаа орчны эсрэг гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай”, “Зөрчил шалган шийдвэрлэх ажиллагааны чанар, үр дүнг ахиулах, зөрчлийн хэргийн илрүүлэлтийг нэмэгдүүлэх тухай”, “Мэдээллийн аюулгүй байдлыг хангуулах тухай”, “Гэрч, хохирогчийг хамгаалах ажлыг эрчимжүүлэх тухай” албан даалгавар 6, албадын дарга нарын манлайллыг дээшлүүлэх, алба хаагчдын сахилга

хариуцлагыг чангатгах, алба хаагчдын ажлын хариуцлага, сахилга ёс зүйг сайжруулах чиглэлээр бие бүрэлдэхүүнд 7 хоногийн Даваа гарагт 14 удаа бичгээр үүрэг тавьж, үүргийг “Дорнод цагдаа-Дотоод ажил” хаалттай группд байршуулан алба хаагч нэг бүрт хүргэж ажиллалаа.

Гэмт хэрэг, зөрчилд холбогдон шалгагдахгүй байх, авилга, хүнд сурталтай холбоотой зөрчил дутагдал гаргахгүй байх талаар Цагдаагийн газрын дарга болон тасгийн дарга, удирдах дарга нараас бие бүрэлдэхүүнд өдөр бүр үүрэг, ажлын чиглэлийг цахимаар хүргүүлэн ажиллалаа.

Соёл, хүмүүжлийн ажлын хүрээнд: Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны журам "Соёл, Соён гэгээрүүлэх ажил" /Код-940/, Цагдаагийн ерөнхий газрын даргын 2019 оны А/37 дугаар тушаалаар батлагдсан “Ахмад, дунд, залуу үеийн залгамж холбоог хөгжүүлэх хөтөлбөр”-ийн хэрэгжилтийг хангах зорилгоор ахмадын сангийн данс нээлгэж 2022 оны төсөв 15.9 сая төгрөг батлуулан ажиллаж байна.

“АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ЭРҮҮЛ МЭНДИЙН СОЁЛЫГ ХАМТДАА ТӨЛӨВШҮҮЛЬЕ” САРЫН АЯНД НЭГДЛЭЭ.

Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн дэлхийн өдрийг угтан хууль тогтоомжийг хэрэгжүүлэх, сурталчилах, аливаа осол, мэргэжлээс шалтгаалсан өвчнөөс урьдчилан сэргийлэх зорилгоор улсын хэмжээнд “Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн сарын аян” зарлагдсаны дагуу тусгаар тогтнолын талбай дээр зохион явагдаж буй төрийн болон , хувийн хэвшлийн 20 гаруй байгууллагуудыг хамруулсан нэгдсэн сурталчилгааны өдөрлөгт тус Цагдаагийн газраас оролцож, хууль тогтоомжийг хэрэгжүүлэх, сурталчилах ажлыг явууллаа.

Уг аян 04 сарын 01-ны өдрөөс 05 сарын 01-ны өдрийг хүртэл явагдаж, иргэд олон нийт рүү чиглэсэн соён гэгээрүүлэх ажил, ХАБЭА-н анхан шатны мэдлэгийн талаар сургалтуудыг үе шаттайгаар явагдах юм.

“ДЭД АХЛАГЧИЙН ӨДӨР” АРГА ХЭМЖЭЭ ЗОХИОН ЯВАГДАЖ БАЙНА.

Цагдаагийн ерөнхий газрын 2022 оны зорилт, Цагдаагийн ерөнхий газрын даргын 2022 оны А/112 тушаалаар батлагдсан “Хорт зуршлаас татгалзаж-Сайнаар үлгэрлэе” нөлөөллийн аян, “Манай хамт олон” арга хэмжээний хүрээнд шинээр томилогдсон ахлагч бүрэлдэхүүнийг сурган дадлагажуулах зорилгоор “Дэд ахлагчийн өдөр” арга хэмжээг 7 хоногийн хугацаатай зохион явуулж байна.

Арга хэмжээний хүрээнд алба хаагчдын албаны бэлэн байдлыг шалгах, жагсаалын бэлтгэл хийх дадлага сургалтыг Зэвсэгт хүчний 327-р ангийн салааны ахлагч а/а Э.Балжиннямтай хамтран зохион байгууллаа.

Мөн олон жил үр бүтээлтэй ажиллаж буй цагдаагийн ахлах ахлагч С.Энхтулга, Э.Бат-Эрдэнэ нар ахлагч нарт зориулж, албандаа хандах хандлагаа зөв төлөвшүүлэх, үүрэгт ажлаа хариуцлагатай, нэр төртэй ажиллахад өөрсдийн дадлага туршлагаа хуваалцаж, харилцан ярилцсан байна.

Мөн Цагдаагийн газрын удирдах бүрэлдэхүүнээс алба хаагч нартай уулзаж, санал хүсэлтийг сонсож ажилласан байна.

-Цагдаагийн байгууллагын түүхэн замнал, ахмад ажилтан нарын алдар гавьяаг алба хаагчдад сурталчлах зорилгоор Цагдаагийн газрын ахмадын хороодын удирдах зөвлөлийн гишүүдтэй уулзалт зохион байгуулж, ахмад ажилтан, цагдаагийн бэлтгэл

хошууч Ж.Дорждэрэм, бэлтгэл хошууч Д.Ганболд, бэлтгэл ахлах ахлагч Б.Маамуу нарын ажил хөдөлмөрийг алдаршуулах, ажил амьдралын туршлагыг шинэ залуу алба хаагч, хойч үедээ сурталчлах зорилгоор “Буянтай буурал” арга хэмжээг зохион байгуулж, хүндэтгэл үзүүлж дурсгалын зүйл хадгалуулав. Мөн Хаврын тэргүүн сар шинийн баярыг тохиолдуулан нийт ахмад ажилтнуудад хүндэтгэл үзүүлж 115 ахмад ажилтанд 3.0 сая төгрөгийн гарын бэлэг, 3 ахмад ажилтанд ууцны хонь гардуулан өглөө.

- Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны журам “Соёл, соён гэгээрүүлэх ажил” /код 940/, тэмдэглэлт баяр ёслолыг тэмдэглэн өнгөрүүлэх хуваарийн дагуу Мөрдөн байцаах тасгаас Олон улсын эмэгтэйчүүдийн эрхийг хамгаалах өдрийг угтан гэмт хэрэгтэй тэмцэх, нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах амаргүй бөгөөд нэр хүндтэй албанд мөр зэрэгцэн ажиллаж буй мөрдэс нэгт бүсгүйчүүддээ Цагдаагийн газрын хамт олны зүгээс хүндэтгэл үзүүлж, гарын бэлэг гардууллаа.

- Монгол Улсад орчин цагийн зэвсэгт хүчин үүсч байгуулагдсаны 101 жилийн ой, Цагдаагийн байгууллагын түүхт 101 жилийн ойн хүрээнд “Монгол цэргийн өдөр”-ийг тохиолдуулан Цагдаагийн газрын эмэгтэйчүүдийн зөвлөлөөс алба хаагчдад хүндэтгэл үзүүлэх арга хэмжээг 2022 оны 03 дугаар сарын 18-ны өдөр хурлын танхимд зохион байгуулж, дүрст видео мэндчилгээг хүргэв.

Арга хэмжээний үеэр алба хаагчдын дунд азтан шалгаруулах сугалааг явуулан харилцагч байгууллагууд болох “Ольхон” дэлгүүр, “1000 айл” барилгын материалын дэлгүүрүүдийн 30 ширхэг гарын бэлгийн азтаныг тодруулан, нийт алба хаагчдад дурсгалын зүйлс гардууллаа.

Цагдаагийн газраас зохион байгуулсан соёл, соён гэгээрүүлэх ажил, арга хэмжээг тухай бүр www.dornod.police.gov.mn вэб сайт болон “Дорнод аймаг дахь Цагдаагийн газар” пэйж хуудсуудад байршуулан иргэд, олон нийтэд түгээх, сурталчлах ажлыг зохион байгуулан ажиллалаа.

Эхний 1 дүгээр улирлын байдлаар соён гэгээрүүлэх ажлын хүрээнд мэдээлэл, сурталчилгаа, соёл хүмүүжлийн чиглэлээр нийт 44 удаа ажил, арга хэмжээ зохион байгуулан ажиллаж, 3450 алба хаагчдад хүргэн ажиллаж, соён гэгээрүүлэх ажлын биелэлт 98 хувьтай байна.

Б/ Зохион байгуулсан албаны сургалтын талаар

Цагдаагийн ерөнхий газрын даргын баталсан удирдамжын дагуу Цагдаагийн ерөнхий газрын Мөрдөн байцаах алба, Хуулийн хэлтэстэй хамтарсан “ХҮНИЙ ЭРХ БА ЦАГДААГИЙН АЛБА ХААГЧИЙН ЭРХ, ҮҮРЭГ” сургалт Дорнод аймаг дахь Цагдаагийн газарт 2022 оны 06 дугаар 06-ны өдөр амжилттай зохион байгуулагдлаа.

Уг сургалт нь Цагдаа, дотоодын цэргийн алба хаагчдын эрх, хууль ёсны ашиг сонирхол зөрчигдөхөөс урьдчилан сэргийлэх, тэдний хууль, эрх зүйн мэдлэгийг дээшлүүлэх, хууль хэрэглэх чадавхийг сайжруулахад чиглэгдсэн юм.

Үр дүнтэй сургалт зохион байгуулсан сургагч багш нартаа цаашдынх нь ажилд амжилт хүсэе.

Дорнод аймаг дахь Цагдаагийн газар нь Монгол Улсын Үндсэн хууль, Боловсролын тухай хууль, Мэргэжлийн боловсрол, сургалтын тухай хууль, Цагдаагийн албаны тухай хууль, Цагдаагийн ерөнхий газрын даргын 2021 оны А/02 тоот тушаалаар батлагдсан “Цагдаа, дотоодын цэргийн алба хаагчдын мэдлэг, ур чадварыг дээшлүүлэх сургалтын нэгдсэн төлөвлөгөө”-ний дагуу Цагдаагийн газрын албаны сургалтын 2022 оны нэгдсэн болон үлгэрчилсэн төлөвлөгөөг цагдаагийн газрын даргаар батлуулж, алба хаагчдын үүрэг гүйцэтгэх ур чадварыг дээшлүүлэх, ёс зүйг төлөвшүүлэх, хууль хэрэглэх чадварыг дээшлүүлэх чиглэлээр нэгдсэн болон мэргэжлийн холбогдолтой сургалтуудыг 7 хоног бүрийн “Лхагва”, нийтийн биеийн тамир, спортыг хөгжүүлж, тэдний бие бялдрыг чийрэгжүүлэх, эрүүл мэндийг хамгаалах, биеийн тамир, спортын арга хэмжээ, тэмцээнийг

зохион байгуулж, албаны спортыг хөгжүүлж, албаны бэлтгэлийг хангах, чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэхтэй холбоотой сургалтыг “Пүрэв” гарагуудад тогтмол явуулж ирлээ.

Албаны сургалтын нэгдсэн төлөвлөгөөний дагуу эхний 1 дүгээр улиралд 49 удаагийн сургалт зохион явуулж, нийт давхардсан тоогоор 8105 алба хаагч хамрагдаж, сургалтын ирц 96.7 хувьтай хамрагдлаа.

Бие бүрэлдэхүүнд мэдвэл зохих хууль тогтоомжийн сургалт 28, алба хаагчийг хөгжүүлэх сургалт 9, дадлагажуулах сургалт 6, Төрийн болон Төрийн бус байгууллагатай хамтран зохион байгуулсан сургалт 3, танхимын сургалтыг 43 удаа, дадлага 3, зайн болон цахим хэлбэрээр 3 удаа тус тус зохион байгуулан ажиллаа.

Цагдаагийн газрын хэмжээнд 2022 онд шинээр томилогдсон 2 алба хаагчийг “Цагдаагийн байгууллагын үйл ажиллагаанд дасан зохицох хөтөлбөр хэрэгжүүлэх” /код 944/-д заасны дагуу томилогдсон албан тушаалд богино хугацаанд дасан зохицох хөтөлбөр, төлөвлөгөө боловсруулж, хэрэгжүүлэн ажиллах чиглэлээр дадлагажуулагч багшийг тушаалаар томилон, алба хаах болон багш шавийн гурван талт гэрээг байгуулан ажиллаж байна.

“АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ЭРҮҮЛ МЭНДИЙН СОЁЛЫГ ХАМТДАА ТӨЛӨВШҮҮЛЬЕ” САРЫН АЯНД НЭГДЛЭЭ.

Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн дэлхийн өдрийг угтан хууль тогтоомжийг хэрэгжүүлэх, сурталчилах, аливаа осол, мэргэжлээс шалтгаалсан өвчнөөс урьдчилан сэргийлэх зорилгоор улсын хэмжээнд “Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн сарын аян” зарлагдсаны дагуу тусгаар тогтнолын талбай дээр зохион явагдаж буй төрийн болон , хувийн хэвшлийн 20 гаруй байгууллагуудыг хамруулсан нэгдсэн сурталчилгааны өдөрлөгт тус Цагдаагийн газраас оролцож, хууль тогтоомжийг хэрэгжүүлэх, сурталчилах ажлыг явууллаа.

Уг аян 04 сарын 01-ны өдрөөс 05 сарын 01-ны өдрийг хүртэл явагдаж, иргэд олон нийт рүү чиглэсэн соён гэгээрүүлэх ажил, ХАБЭА-н анхан шатны мэдлэгийн талаар сургалтуудыг үе шаттайгаар явагдах юм.

Дотоод хэргийн их сургуулийн “Цагдаагийн ажил эрх зүй” мэргэжлийн эчнээ сургалтад 9 алба хаагч, магистрын хөтөлбөрт 1 алба хаагч суралцаж байгаа ба “Боловсрол соёл эрх зүйн” дээд сургуулийн эчнээ сургалтад шинээр 3 алба хаагчийг суралцуулах нөхцөл боломжийг бүрдүүлэн хамруулав.

Мэдвэл зохих хууль, тогтоомжийн сургалтын талаар

Цагдаагийн газрын алба хаагчдад ЦЕГ, харьяа албад болон аймаг, сумын төр захиргааны байгууллагаас ирүүлсэн бодлого шийдвэр, хууль тогтоомж, үүрэг ажлын чиглэл, үйл ажиллагаатай холбоотой шийдвэрүүдийг Захиргааны удирдлагын тасгийн дарга тухай бүрт нь танилцуулж мэдээллээр ханган ажиллалаа. Мэдвэл зохих хууль тогтоомжийн сургалтыг 28 удаа явуулж, 4623 алба хаагчид хамрагдсан ба эхний 1 дүгээр улирлын байдлаар 5 удаа бичиг баримтыг нийт /давхардсан тоогоор/ 798 алба хаагчдад мэдээлэл хийж танилцуулав.

Алба хаагчийг хөгжүүлэх сургалтын талаар

Алба хаагчдыг хөгжүүлэх сургалтыг 9 удаа зохион явуулж, давхардсан тоогоор 1479 алба хаагч хамрагдлаа.

Цагдаа, дотоодын цэргийн анги байгууллагын алба хаагчдын мэдлэг, ур чадварыг дээшлүүлэх 2022 оны давтан мэргэшүүлэх сургалтын нэгдсэн төлөвлөгөөний дагуу гадаад хэлний мэдлэгийг дээшлүүлэх зорилгоор Англи хэлний дунд- гүнзгий шатны 1 сарын сургалтад Булган сум дахь хэсгийн цагдаа, цагдаагийн ахлагч Б.Оргилыг харуулж ажиллаж байна.

Төрийн албаны салбар зөвлөлөөс зохион байгуулагдаж буюу “Төрийн алба хаагчийн ёс зүй, харилцаа, хандлагын өөрчлөлт, бүтээмжийг дэмжих” сэдэвт цахим сургалтыг хүний нөөцийн ахлах мэргэжилтэн, цагдаагийн ахлах дэслэгч Б.Мөнхсүх долоо хоногийн “Пүрэв” гариг бүр хамрагдаж ажиллаж байна.

Дотоодын цэргийн штабаас зохион байгуулсан Дотоодын цэргийн 805 дугаар ангид “Англи хэлний А-2” түвшний сургалтад Энэ оны 02 дугаар сарын 14-ны өдрөөс 03 дугаар

сарын 28-ны өдрүүдэд Дотоодын цэргийн тусгай салбарын харуулчин, ахлагч Б.Баяртулгыг хамруулж ажиллаа.

Мөн Миг даатгалын компаниас санаачлан зохион байгуулсан “Эрсдэлийн форум” сургалтад тус цагдаагийн газраас Захиргааны удирдлагын тасгийн дарга, цагдаагийн дэд хурандаа Б.Батжаргал, зохицуулагч, цагдаагийн дэслэгч Б.Батбаатар нар амжилттай хамрагдсан.

Терроризмтой тэмцэх зөвлөл, Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх хамтын ажиллагааны зөвлөлийн хамтарсан “Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх болон, терроризмын аюул занал” сэдэвт сургалтад тус цагдаагийн газрын дэд бөгөөд эрүүгийн цагдаагийн тасгийн дарга, цагдаагийн дэд хурандаа З.Баянжаргал, шүүх, шүүгчийн аюулгүй байдлыг хангах ажил хариуцсан ахлах байцаагч, цагдаагийн ахмад Ш.Энхбаяр, эдийн засгийн ахлах мөрдөгч, цагдаагийн ахмад Б.Бат-отгон, ахлах мөрдөгч, цагдаагийн ахмад Х.Туяасансар, эрүүгийн мөрдөгч, цагдаагийн дэслэгч О.Мөнхсоёмбо, хэсгийн байцаагч, цагдаагийн дэслэгч Х.Нямдаваа, хүүхдийн асуудал хариуцсан байцаагч, цагдаагийн дэслэгч Ц.Жаргал-Эрдэнэ нарыг хамруулж ажиллаа.

Энэ оны 03 дугаар сарын 10-ны өдөр Хэнтий аймагт зохион байгуулагдсан “Хамтарсан багийн чадавхжуулах”, “Хүүхдэд ээлтэй хүчирхийлэлгүй сум” сэдэвт сургалтад тус цагдаагийн газрын хүүхдийн асуудал хариуцсан ахлах мэргэжилтэн, цагдаагийн ахлах дэслэгч Ч.Анхбаяр, хүүхдийн асуудал хариуцсан байцаагч, цагдаагийн ахлах дэслэгч Н.Гансүх, Булган сум дахь хэсгийн төлөөлөгч, цагдаагийн дэслэгч Б.Анхбаяр нар хамрагдаж ажиллаа.

Дадлагажуулах сургалтын талаар

Төрийн болон Төрийн бус байгууллагатай хамтран зохион байгуулсан сургалтыг 3 удаа зохион явуулж, давхардсан тоогоор 497 алба хаагч хамрагдлаа.

“Асралт үйлс” өрхийн эмнэлгийн их эмч Н.Энхмаагаар эрүүл зөв хооллолтын талаар 1 цагийн сургалтыг зохион байгуулж сургалтын материалыг алба хаагч нарыг бүрэн хамруулах зорилгоор “dornod tsagdaa surgalt” хаалттай фейсбүүк хаалттай хуудсанд байршуулав.

ТАНХИМЫН БОЛОН ДАДЛАГА СУРГАЛТ ЗОХИОН БАЙГУУЛАГДЛАА.

Цагдаагийн ерөнхий газрын даргын тушаалаар баталсан Дадлага, сургалт явуулах ажлын хэсэг 2022 оны 04 дүгээр сарын 21-ний өдөр удирдамж, төлөвлөгөөний дагуу “Хамгаалалтын хувцас хэрэгсэл өмсөх дараалал, хамгаалах-давших-ухрах арга тактик”, “Томилгоот бүлэг, аравтын албадан тараах, тусгай хэрэгсэл хэрэглэх ажиллагаа” сэдвээр дадлага сургуулилт, “Нийтийн эмх замбараагүй байдлын тухай ойлголт, хамгаалалтын төлөвлөлт”, “Олон нийтийн аюулгүй байдлыг хангах үйл ажиллагаанд хүний эрхийг хангахад анхаарах асуудал” сэдвүүдээр танхимын сургалтыг тус тус зохион байгууллаа.

Сургалтанд тус цагдаагийн газрын төв, орон нутгийн 180 гаруй алба хаагч хамрагдсан юм.

“ЭМНЭЛГИЙН АНХНЫ ТУСЛАМЖ” ҮЗҮҮЛЭХ ДАДЛАГА СУРГАЛТ БОЛЛОО

Цагдаагийн ерөнхий газрын 2022 оны зорилт, Цагдаагийн ерөнхий газрын даргын А/155 дугаар тушаалаар батлагдсан “Цагдаа, дотоодын цэргийн байгууллагын соёл, эрүүл мэнд, сэтгэл зүйг төлөвшүүлэх” хөтөлбөрийн хэрэгжилтийг хангах, Улсын хэмжээнд зохион явагдаж буй “Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн сарын аян”-ны хүрээнд тус Цагдаагийн газрын баталсан орон тооны бус “Эрүүл мэнд, сэтгэл зүйн баг”-аас аливаа осол, гэмтэл, мэргэжлээс шалтгаалсан өвчнөөс урьдчилан сэргийлэх, эмнэлгийн анхны тусламжийг үзүүлэхэд алба хаагчийн бэлэн байдлыг хангах зорилгоор “Улаан загалмай хороо”-ны мэргэжилтэн Г.Энхмааг урьж, үзүүлэх дадлага сургалтыг зохион байгууллаа.

Дорнод аймгийн Политехникийн коллежийн ХАБЭА хариуцсан мэргэжилтэн Г.Ганцэцэгээр үйлдвэрийн осол мэргэжлээс шалтгаалах өвчлөл сэдэвт сургалт, Дорнод бүсийн эрчим хүчний систем төрийн өмчит хувьцаат компанийн ХАБЭА хариуцсан мэргэжилтэн Д.Ган-Эрдэнээр Хөдөлмөр аюулгүй байдал, эрсдэлийг эрт илрүүлэх сургалтыг зохион байгуулж сургалтын материалыг алба хаагч нарыг бүрэн хамруулах зорилгоор “dornod tsagdaa surgalt” хаалттай фейсбүүк хаалттай хуудсанд байршуулж ажиллалаа.

Бие бялдрын бэлтгэлжилтийг хангах сургалтын талаар

Алба хаагчийн бие бялдрын бэлтгэлжилтийг хангах сургалтыг 3 удаа зохион явуулж, давхардсан тоогоор 500 алба хаагч хамрагдлаа.

АЛБА ХААГЧДААС МЭРГЭЖЛИЙН ЗЭРГИЙН ШАЛГАЛТ АВЛАА

Цагдаагийн ерөнхий газрын даргын энэ оны А/88 дугаар тушаалын дагуу Тээврийн цагдаагийн албаны дарга, цагдаагийн хурандаа О.Ганбатаар ахлуулсан салбар комиссын бүрэлдэхүүн алба хаагчдаас мэргэжлийн зэргийн шалгалт авахаар 2022 оны 04 дүгээр сарын 20-ны өдөр Дорнод аймаг дахь Цагдаагийн газарт хүрэлцэн ирж, бие бүрэлдэхүүн жагсан хүлээж авлаа.

Шалгалтын ажлын хэсэг алба хаагчдад Цагдаагийн ерөнхий газрын удирдлагаас алба хаагчдын эдийн засаг, нийгмийн баталгааг хангах чиглэлээр хийж хэрэгжүүлж буй ажил, арга хэмжээний талаар мэдээлэл хийж, Цагдаагийн ерөнхий газрын даргын баталсан удирдамж, төлөвлөгөөг танилцуулан, хууль, эрх зүйн мэдлэгийн түвшин тогтоох болон бие бялдрын бэлтгэлжилтийг шалгах шалгалтыг авав.

Маргааш буюу 2022 оны 04 дүгээр сарын 21-ний өдөр “Нийтийн эмх замбараагүй байдал үүссэн үеийн хүч хэрэгслийн бэлэн байдал, түүнийг таслан зогсоох албадан тараах” сэдвээр дадлага сургалтын арга хэмжээ зохион байгуулагдах юм.

Тус цагдаагийн газраас “Дорнод бүсийн эрчим хүчний эрчим хүчний салбар” ТӨХК-тай 2022 онд хамтран ажиллах гэрээгээ шинэчлэн байгуулж, алба хаагчдын бие бялдар, хөдөлгөөний дутагдлаас урьдчилан сэргийлэх чиглэлээр спорт зааланд хичээл сургалт, дасгал хөдөлгөөнийг долоо хоногийн “Пүрэв” гаригт тогтмол хийж ажиллаа.

2022 оны байдлаар биеийн тамир, спортын 5 арга хэмжээ, уралдаан тэмцээн зохион байгуулагдахаар төлөвлөн ажиллаж. Энэ оны эхний 01 дүгээр улирлын байдлаар “Волейбол”, “Марш тактик”, “Буудлага”, “Ширээний теннис”, “Хүчний 3 төрөлт” тэмцээнүүдийг зохион байгуулан алба хаагчдын бүрэн хамруулж ажиллаа.

Монгол Улс орон даяар зохион байгуулагдаж буй “Илүүдэл жингүй, эртэч монгол” аянд алба хаагч нар 1 удаа бүрэн хамрагдаж оролцлоо.

Иргэд, олон нийтэд чиглэгдсэн сургалтын талаар:

Алба хаагчдын мэдлэг, ур чадварыг дээшлүүлэх, хөгжүүлэх, мэдвэл зохих хууль тогтоомжийг судлуулах зорилгоор зохион явуулсан сургалт нэг бүрийг сургалтын мэдээллийн бүртгэлийн санд давхардуулалгүй, баяжилтыг хийж санг бүрдүүлэн ажиллаж, сургалтын материал нэг бүрийг гарын авлага болгон авч алба хаагч нэг бүрт судлуулах зорилгоор “Dornod tsagdaa SURGALT” сургалтын хаалттай цахим группт байршуулан зайн сургалтыг тогтмол, тасралтгүй зохион байгуулж, өдөр тутмын үйл ажиллагаандаа ашиглах, судлах нөхцөл боломжийг бүрдүүлэн ажиллаж байна.

ДӨРӨВ. САНХҮҮ, БҮРТГЭЛ, ХАНГАМЖ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТАЛААР

Байгууллагын санхүү бүртгэл, хангамж үйлчилгээний талаар хийсэн ажил, арга хэмжээний талаар: Төсвийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, шилэн дансны тухай хууль, УСНББОУС, түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу өдөр тутмын үйл ажиллагааг мөрдөн ажиллаж сар бүрийн төсвийн гүйцэтгэлийг тооцон судалж төсөвлөгдөөгүй өр авлага үүсгэхгүй байх талаар анхаарч, санхүүгийн ил тод байдлын хүрээнд тухай бүр хийсэн ажил, гарсан зардлын мэдээг алба хаагчдад танилцуулан, шилэн дансны сайт болон байгууллагын цахим хуудас, санхүүгийн мэдээллийн самбарт төсвийн талаар мэдээг хуульд заасан хугацаанд тогтмол мэдээлэн ажиллаж байна.

Аймгийн Төрийн аудитын газраас 2021 оны санхүүгийн тайланд шалгалт явуулан “Зөрчилгүй санал дүгнэлт” ирүүлснийг Цагдаагийн ерөнхий газрын Санхүү аж ахуйн албанд хуулийн хугацаанд хүргүүлсэн.

Тайлангийн хугацаанд давхардсан тоогоор 21 алба хаагчдад цалингийн зээл, алба хаагчдын татварын буцаан олголтын цалингийн тодорхойлолт, цэргийн алба хаасны

тэтгэвэр тогтоолгох 4 алба хаагчийн сүүлийн 5 жилийн цалингийн тодорхойлолт, Цагдаагийн албаны тухай хуулийн 89.2-т заасан 30 сарын тэтгэмж авах болзол шаардлага хангасан алба хаагчийн сүүлийн 5 жилийн үндсэн цалингийн тодорхойлолтыг тус тус гарган өгч шийдвэрлэв.

Батлагдсан төсөв, түүний зарцуулалт: Цагдаагийн газрын үйл ажиллагааны төсөвт 2022 оны нэгдүгээр улиралд улсын төсвөөс 862,355.5 мянган төгрөг, өөрийн болон гэрээтийн орлогоор 17,696.7 мянган төгрөг нийт 880,052.2 мянган төгрөг батлагдсан, төсвийг хэмнэлтийн горимд шилжүүлэн ажиллаж байна.

Нягтлан бодох бүртгэлээр тавих хяналтыг сайжруулж, тогтмол болон бусад зардлын журналын бичилтийг сар бүр хийж төсвийн гүйцэтгэлийг тооцон судалж төсөвлөгдөөгүй өр авлага үүсгэхгүй байх талаар анхаарч, үүссэн өр авлагын үлдэгдлийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулан удирдлагад танилцуулан өөрийн орлогын төлөвлөгөөг 700.0 мянган төгрөгөөр давуулан биелүүлж, өр авлагагүй ажиллалаа.

Мөнгөн хөрөнгө: Алба хаагчдын цалинд 734.7 сая, байгууллагаас төлөх нийгмийн даатгалын шимтгэлд 15.6 сая, байр ашиглалтын зардалд 17.7 сая, бичиг хэрэг 5,5 сая, шатахуун 33,1 сая, холбооны зардал 2,1 сая, бага үнэтэй түргэн элэгдэл зүйлийн зардал 1,1 сая, хоол, эм бэлдмэлийн зардал 5.8 сая, урсгал засварын зардал 13,4 сая, алба хаагчдад хөдөө орон нутаг болон хотруу албан ажлаар явсан алба хаагчдад томилолт 2,5 сая, байцаан шийтгэх ажиллагааны зардал 2,5 сая, тээврийн хэрэгслийн татвар 0.6 сая, газрын татвар 1.0 сая, сургалт дадлагын зардал 0,1 сая, нэг удаагийн тэтгэмж урамшууллын зардал 0,9 сая нийт 838,9 сая төгрөгийг тус тус зарцуулж 41.8 сая төгрөгийн үлдэгдэлтэй ажиллалаа.

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны зардлын зарцуулалт, эргэн төлөлтийн хэрэгжилтийг хангах чиглэлээр цагдаагийн ерөнхий газрын хяналт шалгалт, дотоод аудитын хэлтсээс өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөө гарган хэрэгжилтийг тооцон эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны зардлыг мэргэжлийн байгууллагын шинжээчээр дүгнэлт гаргуулахад 2.5 сая төгрөгийг олгож, буцаан гэм буруутай этгээдээр 450.0 мянган төгрөгийг нөхөн төлүүлж, бусад гарсан зардлыг төлүүлэх ажлыг эрчимжүүлэн байгууллагыг төлөөлсөн нэхэмжлэгчээр мэдүүлэг өгч материалд хавсарган ажиллав.

Тус цагдаагийн газрын нэмэлт санхүүжилтийн 100070012401 тоот дансанд аймаг орон нутгаас Олон нийтийн цагдаагийн ажилтаны урамшуулал, Аймгийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөлийн 2022 оны төлөвлөгөөнд орсон гэмт хэргээс урьдчилан сэргийлэх хөтөлбөр, олон нийтийн цагдаагийн ажилтны урамшуулал 22.8 сая төгрөгийг төвлөрүүлэн, Сангийн сайдын 2013 оны 73 дугаар тушаалын 02 дугаар хавсралт “Төсвийн санхүүжилтийн болон зарцуулалтын эрхийн тухай журам”-ын дагуу нээлгүүлэн зориулалтын дагуу бүрэн зарцуулан ажиллалаа.

Цалин хөлс бүртгэл: Хөдөлмөрийн тухай хуулийн 60.1 “Ажилтны цалин хөлсийг сард хоёр ба түүнээс дээш удаа, тогтоосон өдөр олгоно” гэж заасны дагуу цалинг сард 2 удаа алба хаагчдын цалинг бодож урьдчилгаанд 889.9 сая төгрөг, сарын сүүлд 2,187.6 сая төгрөгийг голомт, хас, төрийн банкинд байрших алба хаагчдын цалингийн дансанд шилжүүлэн олгосон. Алба хаагч, ажилтны цалинг бодож байгаа байдалд сар бүр, улирлаар давхар хоногийг шалган зөрчилийг тухай бүрт засуулан ажиллаж байна.

Алба хаагчдын цалингаас шүүхийн шийдвэрээс бусад суутгал хийгээгүй ба албанаас шилжсэн болон албан тушаал өөрчлөгдсөн алба хаагч нартай эд хөрөнгө болон бусад тооцоог хийж дуусган тойрох хуудсыг авч 2 алба хаагчын мөнгөн хангалтын аттестатыг олгосон.

Алба хаагчдын ажлын гүйцэтгэл, үр дүн, мэргэшлийн түвшинг дүгнэж Цагдаагийн газрын даргын дэргэдэх зөвлөлийн хурлаар хэлэлцэн цалин нэмж, хасч тооцон батлагдсан төсвийн хүрээнд олгосон. Харилцагч Голомт, Хас банкны удирдлагуудтай цалингийн болон орон сууцны зээлийн нөхцөл хүүд хөнгөлөлт үзүүлэх чиглэлээр уулзалт хийж алба хаагч нараас сэтгэл ханамжийн судалгаа авч мэдээлэл хийлгэн цалингийн зээлийг хүүг

1,1-1,2 хувиар байгуулан ажиллалаа.

Санхүүгийн мэдээллийн ил тод байдал: Төсөв, санхүүгийн ил тод байдалын хүрээнд Цагдаагийн газрын төсвийн орлого, батлагдсан төсвийн зарцуулалтыг www.dornod.police.gov.mn сайтны шилэн дансны хэсэгт, www.shilendans.mn шилэн дансны сайт, байгууллагын санхүүгийн ил тод байдал гэсэн мэдээллийн самбарт 2022 оны жилийн төсөв, өмнөх оны төсвийн гүйцэтгэл, улирал, сарын төсвийн гүйцэтгэл, хагас жилийн тайлан, дараа жилийн төсвийн төсөл, жилийн эцсийн санхүүгийн тайлан, санхүүгийн тайланд хийсэн аудитын дүгнэлт, төсвийн хэтрэлт, хэмнэлт түүний шалтгааны тайлбар, тухайн жилийн төсөвт орсон нэмэлт өөрчлөлт, 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр тус тус байршуулан албан хаагчид болон иргэд, олон нийтийг нээлттэй үзэх боломжоор бүрэн хангаж ажилласан 2022 онд худалдан авах хөрөнгө оруулалт, урсгал зардлын төлөвлөгөөг гарган батлуулан шилэн дансны сайтад мэдээллэн ажилласан. Санхүүгийн мэдээллийн самбарыг шинэчлэн хийлгэн байгууллагын 1 дүгээр конторын үүдэнд байгууллагын батлагдсан төсөв, худалдан авах ажиллагааны тайлан, төсвийн гүйцэтгэлийн мэдээ, 2021 оны санхүүгийн аудитлагдсан тайлан, шилэн дансанд нийт 30 удаагийн мэдээллийг байршуулан тайланг 1 удаа илгээж ажиллалаа.

Хөрөнгө оруулалт: Байгууллагын 2022 оны төсвийн хөрөнгөөр түлш шатах тослох материал худалдан авах нийлүүлэгчийг сонгон шалгаруулах ажлыг Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу www.tender.gov.mn сайтад цахимаар зарлан гүйцэтгэгчийг сонгон шалгаруулан **132.4** сая төгрөгийн гэрээ байгуулан ажиллаж байна.

2022 онд аймаг орон нутгийн төсвийн хөрөнгөөр сумдын хэсгийн төлөөлөгч нарыг унаажуулах ажлын хүрээнд Матад, Булган, Гурванзагал, Баяндун сумын цагдаагийн тасаг, хэсгийн алба хэрэгцээнд нийт 2 автомашин худалдан авах 75,0 сая төгрөг, Сэргэлэн, Цагаан-Овоо сумын цагдаагийн хэсгийн байр /Кобан/-ны засварт 41,2 сая төгрөг нийт **116.6** сая төгрөгийг гүйцэтгэгчийг сонгон шалгаруулалт төндэрийг Аймгийн худалдан авах ажиллагаанд зарлуулан ажиллаж байна.

Цагдаагийн газрын даргын тушаалаар батлагдсан Байгууллагын өмч хамгаалах байнгын зөвлөл байгууллагад шаардлагатай бараа материал худалдан авах ажиллагаанд үнийн судалгаа хийж хамтран ажиллах гэрээг байгуулан ажиллалаа.

Бараа материал, өмч хөрөнгө:

Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 15 дугаар зүйл, Цагдаагийн ерөнхий газрын даргын 2013 оны 422 дугаар тушаалаар батлагдсан Цагдаагийн байгууллагын хэмжээнд мөрдөгдөх Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийн “Бараа материалын бүртгэл” хэсэг, Цагдаагийн газрын даргын тушаалаар батлагдсан Байгууллагын өмч хамгаалах байнгын зөвлөл байгууллагын данс бүртгэлд байгаа тусгай эд хөрөнгийн ашиглалтад хяналт тавьж 2 удаагийн хурал хуралдаж өмчийн ашиглалт хяналтын бүртгэл гарган үр дүнг тооцож ажилласан.

Албан тушаал, ажлын байр өөрчлөгдсөн алба хаагчдын ажил хүлээлцэх актаар эд хөрөнгийн шилжилт хөдөлгөөнийг хийж, ажил хүлээлцэх актыг санхүүд хүлээлгэн өгөөгүй алба хаагчдыг 5 дахь өдрийн санхүүгийн мэдээллийн цагаар танилцуулан ажилласан.

Цагдаагийн газрын даргын тушаалаар байгууллагын эд хөрөнгийг хэсэгчлэн тоолох ажлын хэсгийг томилон алба хаагч нарт эзэмшиж байгаа эд хөрөнгийг нэг бүрчлэн тоолон ажиллаж байна.

Албаны дүрэмт хувцасны хангалт: Албанд шинээр томилогдсон алба хаагч нарын томилгоо цол зэрэг албан тушаал өөрчлөгдсөн тухай бүр тушаалыг Хангалт үйлчилгээний хэлтэст хүргүүлэн алба хаагч нарын хөдөлгөөний баяжилтийг ахлах мэргэжилтэн х/ч Золзаяатай тулгалт хийж шинээр албан томилогдсон болон цагдаагийн 175 алба хаагчдад хантааз, бусад хангалтыг тараан олгосон. Цагдаагийн газраас өөрийн

Одоо Хэсгийн төлөөлөгч, цагдаа нарын ажлыг газар дээр нь шалган зааварчлах, туслах, мөн хэсгийн байцаагч нарын ажил үүргийн гүйцэтгэлд хяналт шалгалт явуулах ажлын хэсгийг тушаалаар байгуулан шалгалтыг явуулж байна.

ЗУРГАА. АЛБА ХААГЧ, АЖИЛТНЫ АЖИЛЛАХ НӨХЦӨЛ, НИЙГМИЙН АСУУДЛЫГ ХАНГАХ, ЭРҮҮЛ МЭНДИЙГ ХАМГААЛАХ ЧИГЛЭЛЭЭР АЛБА ХААГЧ НАРТ ЗОНХИЛОН ТОХИОЛДОХ ХАЛДВАРТ БУС ӨВЧНӨӨС СЭРГИЙЛЭХ ТАЛААР СУРГАЛТ ОРЖ, ЭРТ ИЛРҮҮЛЭГ ҮЗЛЭГ, ШИНЖИЛГЭЭ АВЛАА

Цагдаагийн ерөнхий газрын 2022 оны зорилт, Цагдаагийн ерөнхий газрын даргын 2022 оны А/112 тушаалаар батлагдсан “Хорт зуршлаас татгалзаж-Сайнаар үлгэрлээ” нөлөөллийн аян, Цагдаагийн ерөнхий газрын даргын А/155 дугаар тушаалаар батлагдсан “Цагдаа, дотоодын цэргийн байгууллагын соёл, эрүүл мэнд, сэтгэл зүйг төлөвшүүлэх” хөтөлбөрийн хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд тус Цагдаагийн газрын орон тооны бус “Эрүүл мэнд, сэтгэл зүйн баг”-аас БОЭТөвийн дотоод шүүрлийн тасгийн эрхлэгч эмч, анагаах ухааны магистр, тэргүүлэх зэргийн эмч Д.Цэцэгмааг урьж, “Далд чихрийн шижин, түүнээс урьдчилан сэргийлэх” сэдвээр, Хөдөлмөр аюулгүй байдал, эрүүл ахуйн чиглэлээр Эрүүл мэндийн газрын халдварт бус өвчлөлийн асуулал хариуцсан мэргэжилтэн Э.Бибишийг урьж “Халдварт бус өвчнөөс урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэг үзлэг, шинжилгээ, оношилгоог зохион байгуулах тухай танилцуулга” сэдвээр тус тус сургалтыг 2022 оны 05 дугаар сарын 04-ний өдөр зохион байгууллаа.

Мөн өдөр тус Цагдаагийн газрын бие бүрэлдэхүүнд далд чихрийн шижинг илрүүлэх 1 удаагийн глюкозын ачаалалтай шинжилгээ авч, алба хаагч нарт мэргэжил, арга зүйн зөвлөгөө өгч ажилласан байна.

Цагдаагийн газрын алба хаагчдын эрүүл мэндийг хамгаалах чиглэлээр өвчин, эмгэгийг эрт илрүүлэн оношлох, өвчлөлөөс урьдчилан сэргийлэх зорилгоор аймгийн “Асралт үйлс”, “Дэлгэрэх” эмнэлгийн Үндсэн” шинжилгээ болох “Цусны ерөнхий шинжилгээ”, “Шээсний ерөнхий шинжилгээ”, “Зүрхний бичлэг”, “4D ЭХО”, “Элэгний В, С вирус”, “Сахар”, “Холестрин”, “Элэг, ходоодны маркер”, “Хеликобактер”, “Бэлгийн замын халдварт өвчин”, “Дотрын эмчийн үзлэг” гэх 11 төрлийн үзлэг шинжилгээг 25000 төгрөгийн үнээр 200 алба хаагчийг 5,000,000 төгрөгийн зардлаар хийлгэхээр хамтран ажиллах гэрээний нөхцөлд тусган баталгаажуулж цагдаагийн газрын бие бүрэлдэхүүнийг хуваарьт оруулан алба хаагчдыг үзлэгт хамруулах ажлыг 2021 оны 03 дугаар сарын 05-ны өдрөөс эхлэн 03 дугаар сарын 12-ны өдрийг хүртэлх хугацаанд үе шаттай зохион байгуулан ажиллалаа.

Мөн алба элэгний В,С вирусаас урьдчилан сэргийлэх зорилгоор 78 алба хаагчийг дархлаажуулалтын вакцинд хамруулж ажилласан.

Алба хаагчдыг нөхөн сэргээх сувилалд хөнгөлөлттэй буюу төлбөргүйгээр эмчилгээнд хамруулах ажлыг зохион байгуулж, эрүүл мэндийн байдлыг харгалзан “Сүүж-Уул” сэргээн засах амралт сувилалд амраах алба хаагчийн судалгааг гарган өнөөдрийн байдлаар тус цагдаагийн газраас 1 ээлжинд 10 алба хаагчийг амрааж сувилуулав.

Алба хаагчдыг түр болон удаан хугацаагаар эмнэлэгт хэвтэн эмчлүүлэхэд зориулж хамт олны “Журмын сан”-гаас эхний 01 дүгээр улиралд 120.000 төгрөгийн мөнгөн тусламжийг 2 алба хаагчдад үзүүлсэн байна.

2022 оны хамтран ажиллах гэрээ, төлөвлөгөөний дагуу “Асралт үйлс” өрхийн эмнэлэгээс алба хаагчдын эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлэх ажлын хүрээнд “Эрүүл зөв хооллол”, “Давсны хэрэглээг зохицуулах ач тус”, “Сүрьеэ өвчнөөс урьдчилан сэргийлэх” зэрэг сургалтыг зохион байгуулж сургалтын материалыг алба хаагч нарыг бүрэн хамруулах зорилгоор “dornod tsagdaa surgalt” хаалттай фейсбүүк хуудсанд байршуулж ажиллаа.

Томуу, томуут төст өвчлөл их байгаатай холбогдуулан алба хаагчдыг дархлаажуулах аяныг "Асралт үйлс" ӨЭМТ-тэй хамтран зохион байгуулсан.

Ахмадын сангийн данс нээлгэж 2022 оны төсөв 15.9 сая төгрөг батлуулж, Сар шинийн баярын арга хэмжээнд 115 ахмад ажилтанд 3.0 сая төгрөгийн гарын бэлэг, 3 ахмад ажилтанд ууцны хонь, 3 ахмад ажилтанд "Буянтай буурал" -аар өргөмжлөл тавгийн идээг тус тус гардуулан хүндэтгэлийн арга хэмжээг зохион байгуулсан.

Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны журам "Соёл, Соён гэгээрүүлэх ажил" /Код-940/, Цагдаагийн ерөнхий газрын даргын 2019 оны А/37 дугаар тушаалаар батлагдсан "Ахмад, дунд, залуу үеийн залгамж холбоог хөгжүүлэх хөтөлбөр"-ийн хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд Цагдаагийн газраас ахмад үеэсээ үлгэр дуурайлал авч албандаа хандах хандлага, албаараа бахархах сэтгэгдэл бий болгох зорилгоор нийтийн хэв журам хамгаалах тасгийн "Ахмад, дунд, залуу үеийн уулзалт" арга хэмжээ 2022 оны 03 дугаар сарын 07-ны өдөр зохион явагдаж, урилгаар Ахмадын хорооны дарга, цагдаагийн бэлтгэл хошууч Х.Болдбаатар, цагдаагийн бэлтгэл дэд хурандаа Н.Болдсайхан, цагдаагийн бэлтгэл ахмад Л.Улаан, Б.Отгонсүрэн, цагдаагийн бэлтгэл ахлах ахлагч Ө.Нэргүй, Ц.Энхбаатар нар оролцлоо.

Уулзалтаар Цагдаагийн газраас хийж хэрэгжүүлж буй ажлаа танилцуулан, ахмад дунд залуу үеийн холбоог сайжруулах чиглэлээр санал хүсэлтийг хүлээн авч, ажил хэрэгч яриа өрнүүлж, туршлага судалсан сайхан ярилцлага болж өндөрлөсөн байна.

Мөн тус хөтөлбөрийн хүрээнд Эрүүгийн цагдаагийн тасгаас санаачилан тус цагдаагийн газрын бэлтгэл дэд хурандаа Х.Мөнхжаргалыг урьж, дурсамж уулзалтыг зохион байгуулсан.

Тус цагдаагийн газраас алба хаагчдын ажиллах орчин, нөхцлийг сайжруулах, дэвшилтэт техник технологийг алба хаагчдын өдөр тутмын үйл ажиллагаа, үүрэг гүйцэтгэлтэндээ ашиглах зорилгоор хамгаалуулагч байгууллага "Дорнод Нийтийн аж ахуй" компаниас дотоодын цэргийн тусгай салбарын алба хаагч нарт үүргийн радио гар болон суурин станц, шөнийн дуран, гар чийдэн, дрон зэргийг хүлээлгэн өгсөн.

"ВИТАМИНЖУУЛАЛТ" АЯНГ ЗОХИОН БАЙГУУЛЛАА

Цагдаагийн ерөнхий газрын 2022 оны зорилт, Цагдаагийн ерөнхий газрын даргын А/155 дугаар тушаалаар батлагдсан "Цагдаа, дотоодын цэргийн байгууллагын соёл, эрүүл мэнд, сэтгэл зүйг төлөвшүүлэх" хөтөлбөрийн хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд тус Цагдаагийн газрын баталсан орон тооны бус "Эрүүл мэнд, сэтгэл зүйн баг"-аас алба хаагчдын эрүүл мэнд, дархлааг сайжруулах зорилгоор хүрээнд 2022 оны 04 дүгээр сарын 07-ны өдрөөс "Витаминжуулалт" аяныг эхлүүллээ.

Аяны хүрээнд "Асралт үйлс" өрхийн эрүүл мэндийн төвтэй хамтран дархлаа дэмжих витамин С, D аньс, чацарганы витаминьг тарааж, стресс бухимдлыг саармагжуулах, ядаргаа тайлах амин дэмүүдийн талаар сургалт зохион байгууллаа.

ДОЛОО. ДҮГНЭЛТ

Цагдаагийн байгууллагаас 2022 онд дэвшүүлсэн зорилт, үйл ажиллагааны төлөвлөгөөнд төв, орон нутгийн цагдаагийн газар, хэлтсээс хийж гүйцэтгэхээр заагдсан 5 зорилт, 63 заалтыг хэрэгжүүлэх, гэмт хэрэгтэй тэмцэх, нийгмийн хэв журам сахиулах ажлын арга барилыг боловсронгуй болгох, бүрэлдэхүүний сахилга ёс зүйг дээшлүүлэх тэдний дунд зохиох сургалт соён гэгээрүүлэх ажил, алба хаагчдын нийгмийн асуудал, ажлын байрны тохижилтыг сайжруулах зорилгоор Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны журмын "Цагдаагийн байгууллагын ажлыг төлөвлөх журам"-ын /код 108/

дагуу 5 бүлэг 63 зорилт бүхий цагдаагийн газрын гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулан хэрэгжүүлэн ажиллалаа.

- Байгууллагын үйл ажиллагаа болон шаардагдах төсөв хөрөнгийн талаар аймгийн ИТХ, Засаг дарга нарт холбогдох санал, төсөв хөрөнгийн тооцоо судалгааг гарган хүргүүлж ажилласнаар улсын төсөв, Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөс тодорхой дэмжлэгийг авч, бүтээлч санаачлага гарган ажилласны үр дүнд 2022 онд сумдын хэсгийн төлөөлөгч нарыг унаажуулах ажлын хүрээнд Матад, Булган, Гурванзагал, Баяндун сумын цагдаагийн тасаг, хэсгийн алба хэрэгцээнд нийт 4 автомашин худалдан авах 125,0 сая төгрөг, аймгийн төвийн баг болон сумдад олон нийтийн цагдаа ажиллуулах урамшууллын зардалд 50.4 сая төгрөг, Сэргэлэн, Цагаан-Овоо сумын цагдаагийн хэсгийн байр /Кобан/-ны засварт 41,2 сая төгрөг нийт 216.6 сая төгрөгийн хөрөнгө, санхүүгийн эх үүсвэрийг шийдвэрлүүлэв.

- “Байгууллагын соёл, эрүүл мэнд сэтгэл зүйг дэмжих хөтөлбөр”-ийг хэрэгжүүлэх, “Алба хаагч, ажилтны эрх, хууль ёсны эрх ашгийг хамгаалах” Цагдаагийн газрын алба хаагчдын ахуй амьдралтай танилцах, судлах, Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны тайланг танилцуулах, гэр бүлийн харилцаа хандлагыг тодорхойлох замаар тэдний гэр бүлийн гишүүдтэй уулзаж санал хүсэлтийг сонсох, тулгамдаж буй асуудлыг шийдвэрлэх зорилгоор “ Гэр бүлээ сонсьё” арга хэмжээ, Мөн цагдаагийн газрын алба хаагчдын нийгмийн баталгааг хангах, тулгамдаж буй асуудлыг шийдвэрлэх гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх, нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах, үндсэн чиг үүргийн ажлыг ахиулахад анхаарах асуудал, ажиллах орчин, чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэх, алба хаагчдын эрүүл мэндийг хамгаалах, алба хаагчдаас санал хүсэлтийг хүлээн авч удирдлагын түвшинд шийдвэрлэх зорилгоор “Алба хаагчаа сонсьё” арга хэмжээг зохион байгуулж сарын бүрийн 01-ны өдрийг “Алба хаагчаа сонсох” өдөр болгон хэрэгжүүлэн ажиллалаа.

-Алба хаагчийн үйл ажиллагаанд хяналт тавьж, алба хаагч, ажилтан гэмт хэрэг, зөрчил үйлдэх, ёс зүй, сахилгын зөрчил гаргахаас урьдчилан сэргийлж, шалтгаан нөхцөлийг арилгах арга хэмжээ авах, цагдаагийн албаны дотоод хяналт-аюулгүй байдлыг хангах, алба хаагчдын албандаа хандах хандлагыг эерэг болгож, ажлын бүтээмжийг дээшлүүлэх, харилаа, хандлагыг өөрчлөх зорилгоор бүхий “Ёс зүйгээ мөрдөж, дүрмээ биелүүлье” 1 сарын аяныг 60 хоногийн хугацаатай зохион явуулж байна.

- Цагдаагийн байгууллагаас 2022 онд дэвшүүлсэн зорилтыг хэрэгжүүлэх, удирдлагаас өгсөн үүрэг, чиглэл, зөвлөмжийг хэрэгжүүлж ажилласны үр дүнд эхний 01 дүгээр улирлын байдлаар гэмт хэрэг, зөрчилд холбогдсон алба хаагч байхгүй.

- Цагдаагийн газрын хэмжээнд 2022 оны эхний 01 дүгээр улирлын байдлаар иргэд, аж ахуйн нэгж, байгууллагаас ирүүлсэн гомдол мэдээллийн 85.7 хувийг хуулийн хугацаанд шалгаж шийдвэрлэсэн.

Аймгийн хэмжээнд 2022 оны 3 дугаар сард 106 холбогдогчтой, 460.5 төгрөгийн хохиролтой, 173 гэмт хэрэг бүртгэгдэж, 17 хэргээр буюу 10.9 хувиар урьд оны мөн үеэс өссөн байна. Гэмт хэргийн илрүүлэлт 27.8 хувьтай байгаа нь өмнөх оны мөн үеэс 2.7 хувиар өсч.

Гэмт хэргийн улмаас 4 хүн нас барж, 75 хүн гэмтсэн нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад нас барсан хүн 1 буюу 20 хувиар буурч, гэмтсэн хүний тоо 14 буюу 22.5 хувиар өссөн байна. Иргэд аж ахуйн нэгж байгууллагад учирсан хохирлын 125.5 төгрөг буюу 27.1 хувийг нөхөн төлүүлжээ.

Үйлдэгдсэн байдлаар: Согтуугаар үйлдэгдсэн гэмт хэрэг 46 бүртгэгдэж 28 буюу 1.5 дахин, хүүхэд оролцсон гэмт хэрэг 3 бүртгэгдэж 3 дахин, галт зэвсэгээр үйлдэгдсэн гэмт хэрэг 1 бүртгэгдэж 100 хувиар тус тус өсөж,

Бүлэглэн үйлдсэн гэмт хэрэг 6, мөнсуурсан үедээ 1 бүртгэгдэж ижил түвшинд, урьд ял шийтгэгдсэн хүмүүсээс дахин гэмт хэрэгт 3 хүн холбогдсон нь 24 буюу 88.8.5 хувь, гэр бүлийн хүчирхийллийн улмаас үйлдэгдсэн гэмт хэрэг 7 бүртгэгдэж 6 буюу 46.1%, эмэгтэй хүн оролцсон гэмт хэрэг хэрэг 9 бүртгэгдэж 2 буюу 18.1 хувиар тус тус буурсан.

Үйлдэгдсэн газраар: Гудамж талбайд үйлдэгдсэн гэмт хэрэг 17 бүртгэгдэж 4 буюу 30.7 хувь, олон нийтийн газарт үйлдэгдсэн гэмт хэрэг 8 бүртгэгдэж 6 буюу 3 дахин, байгууллага аж ахуй нэгжид үйлдэгдсэн гэмт хэрэг 8 бүртгэгдэж 1 буюу 14.2 хувь, бусад газарт үйлдэгдсэн гэмт хэрэг 38 бүртгэгдэж 16 буюу 72.3 хувиар тус тус өссөн байна.

Гэр, орон сууцанд үйлдэгдсэн гэмт хэрэг 58 бүртгэгдэж 14 буюу 19.4 хувь, хөдөө хээр үйлдэгдсэн гэмт хэрэг 14 бүртгэгдэж 1 буюу 6.6 хувь, бэлчээрт үйлдэгдсэн гэмт хэрэг 16 бүртгэгдэж 3 буюу 15.7 хувиар тус тус буурчээ..

Хэргийн төрлөөр: Хүнийг алах 2 бүртгэгдэж 100%, Хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг 59 бүртгэгдэж 11 буюу 22.9 хувь, залилах гэмт хэрэг 21 бүртгэгдэж 7 буюу 50 хувь, хууль бусаар мод бэлтгэх гэмт хэрэг 6 бүртгэгдэж 2 буюу 50 хувь, гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх, эрүүл мэндийн эсрэг гэмт хэргүүд тус бүр 1 бүртгэгдэж 100 хувь, бусад төрлийн гэмт хэрэг 17 бүртгэгдэж 4 буюу 1.5 дахин өсөж,

Хүнийг амиа хорлох нөхцөл байдалд хүргэх гэмт хэрэг 1 буюу 50 хувь, бэлгийн эрх чөлөө хөлдөшгүй байдлын эсрэг гэмт хэрэг 3 буюу 60 хувь, дээрэмдэх гэмт хэрэг 2 дахин, мансууруулах эм сэтгэгцэд нөлөөт бодисыг хууль бусаар ашиглах 1 дахин тус тус буурч, хөрөнгө завших, нийтийн албаны ашиг сонирхлын эсрэг, хөдөлгөөний аюулгүй байдал, тээврийн хэрэгслийн ашиглалтын журмын эсрэг гэмт хэрэг ижил түвшинд байна.

Хүний амь насыг болгоомжгүй хохироох, хүүхдийн эсрэг, гээгдэл эд зүйл, алдуул мал завших, улсын хилээр барааг хууль бусаар нэвтрүүлэх, олон нийтийн амгалан тайван байдлыг алдагдуулах, авлигын эсрэг, цахим мэдээллийн аюулгүй байдлын эсрэг гэмт хэргүүд бүртгэгдээгүй байна.

НАЙМ. ЦААШИД ТАВИХ ЗОРИЛТ

1. Цагдаагийн байгууллагаас 2022 онд дэвшүүлсэн зорилтыг бүрэн хэрэгжүүлж ажиллах.
2. Алба хаагчдын эрүүл мэнд, хууль ёсны эрх ашгийг хамгаалж, сургалт, соёл, соён гэгээрүүлэх ажил, арга хэмжээг зохион явуулж, нийгмийн асуудлыг шийдвэрлэх.
3. Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажилд иргэд, олон нийтийн оролцоог нэмэгдүүлэх, байгууллагын үйл ажиллагааг сурталчлах.

ТАЙЛАН БИЧСЭН:
ЦАГДААГИЙН ГАЗРЫН ДАРГА,
ЦАГДААГИЙН ХУРАНДАА

Т.ГАНЗОРИГ